

НЭГ. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2019 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Ногоон алт төслийн зорилго нь Бэлчээрийн зохистой ашиглалт, борлуулалтын ашигтай тогтолцоо, эрхзүй, бодлогын таатай орчны нөлөөгөөр малчин өрхийн амьжиргаа дээшлэх			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Швейцарийн Холбооны Улсын буцалтгүй тусламж.			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Хэрэгжих нийт хугацаа- 4 жил</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, МЭЕГ, АДОБАЗ, ХААҮШУОНТ, УЦУОШГ, ГЗБГЗЗГ, ХААИС, Аймаг, сумдын ЗДТГ, МБАНХ, Аймаг, сумдын бэлчээр ашиглагчдын холбоо, МННХ, МАШҮХ, Дижитал медик ХХК</p>			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: БАХ, бэлчээр ашиглалтын гэрээг өргөжүүлэн нэвтрүүлэх замаар бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зохистой тогтолцоог төлөвшүүлэх</p> <p>Зорилт 2: Зах зээлд хамтран гарах, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар сайжирсны (мал эмнэлгийн үйлчилгээ) үр дүнд малчин өрхийн орлого нэмэгдэнэ</p> <p>Зорилт 3: Малын эрүүл мэнд, бэлчээрийн тогтвортой менежментийн эрхзүйн таатай орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>			
5	Зардал	Төсөв (Нийт зардал)	Төслийн 3 бүрэлдэхүүн хэсэг болон удирдлагын зардалд 2019 онд 5'402'500 мянган төгрөг /2'161 мянган швейцар франк/ төсөвлөж, 4'318'750 мянган /1'727.5 мянган швейцар франк/ зарцуулж 80 хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.		
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл	Хувь
		Бүрэлдэхүүн хэсэг 1	2'145'000'000	1,733,430,000	81%
		Бүрэлдэхүүн хэсэг 2	2'157'500'000	1,874,350,000	87%
		Бүрэлдэхүүн хэсэг 3	1'100'000'000	710,970,000	65%
		Удирдлага			
Нийт		5'402'500'000	4,318,750,000	80.0%	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 15-39 дүгээр хуудас.			
	2-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 39-56 дугаар хуудас.			
	3-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 56-59 дүгээр хуудас.			

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт.</p> <p>1. Тус төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 91.2 хувьтай дүгнэгдэв.</p> <p>2. Малчдын зохион байгуулалтад оруулсан болон мал, малын гаралтай бүтээгдэхүүний эргэн мөшгих тогтолцоо бүрдүүлсэн программ хангамжийг хөгжүүлсэн нь Монгол орны нөхцөлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц ахицтай ажил болсон байна.</p> <p>3. Төслийн жилийн эцсийн тайлан нь үр дүнд суурилсан, биелэлтийг төсөл хэрэгжиж буй сум, малчдын бүлгийн үзүүлэлтээр гарган, үр нөлөөллийг тодорхой тусгасан байна.</p> <p>4. Төсөл хэрэгжүүлэгч нэгж, төрийн, төрийн бус байгууллага, төсөлд хамрагдсан сумын малчдын ажлын уялдаа, хамтын ажиллагаа сайн байна.</p> <p>Зөвлөмж.</p> <p>1. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний эргэн мөшгөх тогтолцооны программд мал эмнэлгийн үйлчилгээний мэдээллийг бүрэн оруулуулах, гарал үүслээс гадна жинхэнэ утгаар нь хүнсний аюулгүй байдлын баталгааг бий болгоход анхаарах,</p> <p>2. Орон нутаг дахь төрийн албан хаагчдад хөрөнгө оруулалт хийж, үйлчилгээ үзүүлж байгаа байдлыг таслан зогсоож, хувийн хэвшлийн аж ахуйд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх (Хөдөө аж ахуйн тасгийн дэргэд хээлтүүлэгч төвлөрүүлсэн, тасгийн мэргэжилтэнд хөрөнгө оруулалт хийж, зохиомол хээлтүүлэг хийлгэсэн зэрэг),</p> <p>3. Сүргийн эргэлтийн программ хангамжийг улс даяар нэвтрүүлэх, малын үржил бүртгэлийн программтай холбож өгөх,</p> <p>4. Мал сүргийн зохистой бүтцийг (зүйл хоорондын болон зүйл доторх харьцаа) тогтоож, бодлогын шийдвэр гаргуулж, үр дүнг баталгаажуулах,</p> <p>5. Төсвийн зарцуулалт хангалттай биш байгаа тул шалтгааныг судалж, зарцуулалтыг сайжруулах шаардлагатай байна.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай сайн				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		91.2	3	95.6	84.3	93.8
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %				

ТОВЧИЛСОН ҮГ

АБАХ	Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо
БАГ	Бэлчээр ашиглалтын гэрээ
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал аж ахуй
МБАНХ	Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЛМ	Ланд менежер
МННХ	Монголын ноос, ноолуурын холбоо
МАШҮХ	Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭС	Мал эмнэлгийн сургууль
МЭХ	Мал эмнэлгийн холбоо
НАМЭМ	Ногоон алт малын эрүүл мэнд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОХУ	Оросын Холбооны Улс
СБАХ	Сумын бэлчээр ашиглагчдын холбоо
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХҮСХХ	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн
УИХ	Улсын Их Хурал
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
УЦУОШГ	Ус цаг уур, орчны шинжилгээний газар
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг
ЭШХ	Эрдэм шинжилгээний хүрээлэн
МЭНС	Мал эмнэлгийн нэгдсэн систем

ХОЁР. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.

2.1. ТӨСЛИЙН ТУХАЙ.

Ногоон Алт (2004-2016) төслийг Швейцарийн Хөгжлийн Агентлаг /ШХА/-аас Монгол улсад хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн төслийн шууд үргэлжлэл болгон хэрэгжүүлж, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малчдыг зах зээл, засаглал, эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох боломжийг сайжруулах: 1) Малчдын хамтын байгууллага, 2) Хэрэглээний судалгаа, 3) Мэдлэг түгээх үйлчилгээ /экстейншин/, 4) Маркетинг гэсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр ХХААХҮЯ, ГХГЗЗГ, УЦОШХ, ХААИС зэрэг байгууллагатай, Малын эрүүл мэнд төсөл (МЭТ, 2012-2016) нь ШХА-ын Мал аж ахуйн төслийн шууд үргэлжлэл байдлаар хэрэгжүүлж, малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах зорилгоор 1) Мал эмнэлгийн бодлого, эрхзүйн дэмжлэг, 2) Халдварт өвчний хяналт (шүлхий, бруцеллез), 3) Мал эмнэлгийн боловсрол гэсэн 3 бүрэлдэхүүн хэсгийг ХХААЯ, МЭҮГ, МЭТЛ, МЭС-тай хамтран хэрэгжүүлжээ.

Ногоон алт – Малын эрүүл мэнд төсөл нь 2016 оны сүүлчээр дууссан Ногоон алт, малын эрүүл мэнд төслийг нэгтгэн 2017 оны 01 дүгээр сараас 2020 оны 12 дугаар сарын сүүлч хүртэл хэрэгжинэ.

Төслийн хэрэгжүүлэлт: Ногоон алт – Малын эрүүл мэнд төсөл нь үндэсний болон орон нутгийн түншүүд (үндэсний ба аймгийн БАХ-ийн холбоо, хоршоод, ГХГЗЗГ, МЭҮГ гэх мэт) нь Удирдах хороотой байгуулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний дагуу үйл ажиллагаа явуулна. ШХА, ХХААЯ (хуучин нэрээр)-ны хооронд харилцан ойлголцлын санамж бичиг, харин төсөл хэрэгжүүлэх гэрээг Сангийн яамтай тус тус байгуулсан.

Төсөл зохицуулах нэгж (ТЗН). төслийн хэрэгжилтийн хяналт, мониторинг явуулж, удирдлага чиглэл, чанарын баталгаагаар хангана.

2.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

2.3. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2019 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

ГУРАВ. ТӨСЛИЙН ХҮРЭЭ.

3.1. Төслийн хүрээ.

Төсөлд 18 аймгийн 183 сум хамрагдаж байгаа нь Монгол орны нийт сумын 51 хувь болж байна.

3.2. Төслийн зорилго. Бэлчээрийн тогтвортой менежмент, сайн маркетинг, бодлого, эрх зүйн таатай орчноор дамжуулан малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх.

3.3. Төслийн зорилт.

1. Бэлчээр ашиглалтын хэсэг, бэлчээр ашиглалтын гэрээгээр дамжуулан бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх:

2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх:

3. Малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийн бодлогын таатай орчныг дэмжих:

3.4. Төслийн нийт төсөв.

Төслийн энэ үе шатанд Швейцарийн хөгжлийн агентлагаас 7,776.00 мянган швейцар франк төсөвлөсөн.

3.5. Хүлээгдэж буй үр дүн

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1. БАХ, БАГ-г өргөжүүлэн нэвтрүүлэх замаар бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зохистой тогтолцоо төлөвшүүлэх.

Үр дүн 1.1. БАХ/БАГ-г төсөл одоо хэрэгжиж байгаа 11 аймагт бэхжүүлнэ.

Үр дүн 1.2. Шинээр хамрагдах 7 аймагт БАХ/БАГ-г нэвтрүүлнэ.

Үр дүн 1.3. Бэлчээр ашиглалтын гэрээний асуудлаар техник арга ажиллагаа, мэдээллийн санг үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагын түвшинд дэмжин хөгжүүлнэ.

Үр дүн 1.4. БАХ-ийн тогтолцооны бүтэц, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх.

Үр дүн 2.1. Боловсруулагч, БАХ-ийн хоршоодын холбоо хоорондын хамтын ажиллагааг зуучлан бэхжүүлнэ.

Үр дүн 2.2. БАХ-ийн дэргэдэх хоршоодыг чадавхжуулна.

Үр дүн 2.3. Мал аж ахуйн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулна.

Үр дүн 2.4. Сонгосон аймгуудын мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3. Малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийн бодлогын таатай орчныг дэмжих.

Үр дүн 3.1. Малын эрүүл мэнд, бэлчээрийн хууль эрхзүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Үр дүн 3.2. Яам, агентлагийн хүсэлтэд тулгуурласан бодлогын арга хэмжээг дэмжинэ.

Бэлчээрийн тогтвортой менежмент (Үр өгөөж 1): 18 аймгийн 180 сумын 80000 малчин өрх (320000 хүн, 50% эмэгтэй); 7000 малчин ахлагч (30% нь эмэгтэй), албан хаагч (15% эмэгтэй), хурлын төлөөлөгч (10% нь эмэгтэй) бэлчээрийн тогтвортой менежментийн сургалтад хамрагдаж чадавхжсан байх; 25000 малчин өрх (100000 хүн) дундын сан, эсвэл хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан буцалтгүй тусламжийн жижиг эх үүсвэрээс хүртэх боломжтой болсон байх

Зах зээл, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарын сайжралт (Үр өгөөж 2): анхан шатны 100 хоршоо (сум), дундын 10 хоршоо (аймаг)-ны 500 гишүүд (30% нь эмэгтэй)-ийн маркетинг, зохион байгуулалт, бизнесийн арга барил сайжирсан байх; 2000 малчин (30% нь эмэгтэй), малын эмч/хөдөө аж ахуйн мэргэжилтэн (20% нь эмэгтэй), боловсруулах компаний эзэд (50% нь эмэгтэй)-ийн техник ажиллагаа, зохион байгуулалтын дадлага, арга барил сайжирсан байх;

Бодлогын таатай орчин (Үр өгөөж 3): бэлчээр, малын эрүүл мэндийн бодлого цэгцэрч төлөвшөөс Монгол улсын бүх иргэд ашиг хүртэх болно; 1500 албан хаагч, бодлого боловсруулагч, малын эмч, яам, агентлаг, орон нутгийн байгууллагын техник ажилтны чадавх сайжирна (15% хувь нь эмэгтэй).

3.6. Төсөл хэрэгжих хугацаа.

Төсөл 2017 оны 1 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үргэлжилнэ.

3.7. Төслийн санхүүжилт.

Төслийн 3 бүрэлдэхүүн хэсэг болон удирдлагын зардалд зориулан 2019 онд 1,721,600.00 швейцар франк төсөвлөж, 1,727,488.00 швейцар франк зарцуулж, 2019 оны санхүүжилтийн гүйцэтгэл 100.3 хувийн биелэлттэй байна. Төслийн төлөвлөсөн нийт санхүүжилтээс 2017 онд 89.8, 2018 онд 81.9, 2019 онд 100.3 хувийг тус тус буюу нийт 5,678,100.00 (73%) швейцар франк зарцуулсан байна.

ДӨРӨВ. ХУРААНГУЙ.

Сүүлийн 5 жилийн хугацаанд малын тооны өсөлт дунджаар 10 хувь байсан бол 2019 онд хамгийн бага буюу 0.4 хувийн өсөлттэй байгаа ч дотоодын махны хэрэгцээг бүрэн хангаж байна. Гэвч энэ оны 10 сарын байдлаар мах, махан бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.6 хувиар өссөнтэй холбоотойгоор Засгийн газраас үхрийн махны экспортыг зогсоосон, махны экспортыг гурван төрөл дээр ирэх оны зургаан сар хүртэл зогсоож, адууны махны экспортыг тодорхой хэмжээгээр хийх болсон. Мах, махан бүтээгдэхүүний экспорт 2019 оны эхний 10 сарын байдлаар 34,2 мян тн хүрсэн байна. Махны экспортыг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад адууны мах 19.6%, хонь, ямааны мах 28.0%, үхрийн мах 100.0% буурсан үзүүлэлттэй байна. Махны экспорт буурснаас малчид хүссэн хэмжээнд хүртэл борлуулалт хийж чадахгүй байсан нь бэлчээрийн ачааллыг бууруулахад хүндрэл учруулах хүчин зүйл боллоо.

МБАНХ-ноос ХХААХҮЯ-тай улсын аварга малчин өрх шалгаруулах болзлын талаар хамтран ажилласны үр дүн гарч, улсын аварга, хошой аварга малчин өрх, улсын аварга фермер, улсын аварга саальчин шалгаруулах журмыг Засгийн газраас шинэчлэн баталлаа.

Төрийн болон төрийн бус 9 байгууллагатай бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, малчдын хоршооны зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж байна. Малчдыг БАХ-ийн зохион байгуулалтад оруулах, БАГ-гээр дамжуулан бэлчээр сайжруулах, малчдын байгууллагыг хөгжүүлэх ажлыг МБАНХ-гоор дамжуулан хэрэгжүүлснээр төсөлд нийт 18 аймгийн 183 сум хамрагдаж байгаа нь Монгол орны нийт сумын 51.0% болж байна. Эдгээр аймаг, сумдад бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, бэлчээрийн харилцааг хариуцлагажуулах, малын эрүүл мэнд, үүлдэр угсааг сайжруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдыг зохион байгуулалтад ороход нь мэргэжил арга зүйгээр хангаж ажилласнаар 64 БАХ, 5 ХАА-н хоршоо, 9 ХЗХ шинээр байгуулагдаж, 81,6 мянган малчин өрхийг хамарсан 1509 бэлчээр ашиглагчдын хэсэг, 157 СБАХ, 18 АБАХ, 75 ХАА-н хоршоо, 33 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Малчдын байгууллагын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 14-өөр нэмэгдлээ.

ХХААХҮЯ-ны АДОБАЗ-тай хийсэн гэрээний хүрээнд бэлчээрийн даац багтаамж тооцох арга аргачлалыг ХХААХҮЯ-ны дэргэдэх салбар дундын ажлын хэсгээс шинэчлэн боловсрууллаа. Ингэснээр биологийн болон бодит ургац тодорхойлох арга, улирлын үргэлжлэх хугацаа, малын төрлийг хонин толгойд шилжүүлэх итгэлцүүрийг нэг болгож ХААИС-ийн эрдмийн зөвлөл, Үндэсний статистикийн газрын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн А/113, А/422, А-250 дугаар тушаалаар батлуулснаар улсын хэмжээнд нэгдсэн арга зүйтэй боллоо.

Аймаг дундын отрын бүс нутагт бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, мэргэжилтнүүд болон малчдын санал авч, бэлчээрийн төлөвлөлтийн зураглал гарган, аймаг дундын отрын бэлчээрийг зохистой ашиглах талаар аймаг, сумдын хооронд гэрээ байгуулан ажилласнаар отрын бэлчээрт зөвшөөрөлгүй орох явдал буурч, аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт сайжирч, бэлчээрийн маргаан буурч байна. Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт зөвшөөрөлгүй орсон малчин өрхөд холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авснаар отрын бүсэд зөвшөөрөлгүй мал оруулдаг, тогтоосон хугацаанд отрын бэлчээрийг чөлөөлдөггүй зөрчил буурч байна.

ХААИС-тай байгуулсан гэрээний хүрээнд тус сургуулийн багш, судлаачдын багаас мал сүргийн тоо төрлийг тухайн орон нутгийн онцлог, даацад тохируулахад чиглэсэн сүргийн эргэлтийг 5-10 жилээр боловсруулж загвар сумдын хэмжээнд БАХ-аар болон малчин өрхийн малын тооны шатлалаар туршиж, сүргийн эргэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох мэргэжилтнүүд, малчдад зориулсан сургалт зохион

байгуулж нэвтрүүлж эхэллээ. Сүргийн эргэлтийн схемийг боловсруулсан зарчим, түүнд зориулан хөгжүүлсэн программ хангамжийг ХААИС-ийн эрдмийн зөвлөл, ХХААХҮЯ-ны дэргэдэх шинжлэх ухааны зөвлөлөөс сайшааж, улсын хэмжээнд ашиглах нэгдсэн арга зүйгээр баталлаа.

НАМЭМ төслийн дэмжлэгтэйгээр бэлчээрийн мониторингийн арга зүйг шинэчлэн улсын хэмжээнд нэгтгэн сайжруулснаар УЦУОСШГ, ГЗБГЗЗГ бэлчээрийн экосистемийн төлөв байдлын өөрчлөлт, бэлчээр ашиглалтын үр нөлөөг тус тусад нь хянах мониторингийн 2 том сүлжээний дэргэдэх үндэсний хэмжээний сан нь МАА-н үйлдвэрлэлийг хариуцлагажуулах, түүний тогтвортой байдлыг хангах үндсэн суурь болж байна.

Монгол орны бэлчээрийн үндэсний мониторингийн улсын сүлжээний арга зүйг стандартчлах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, багаж тоног төхөөрөмжөөр хангах, тайлан мэдээ гаргах, олон нийтэд түгээх чиглэлээр УЦУОСМХ-тай хамтран ажиллаж бэлчээрийн төлөв байдлын үндэсний мэдээллийн сан байгуулснаас хойш 8 жилийн мэдээг хадгалаад байна. Ус цаг уурын улсын сүлжээн дэх бэлчээрийн төлөв байдлын мониторингийн хөтөлбөр нь улсын хэмжээнд 1516 цэг хамарч бэлчээрийн экосистемийн төлөв байдал, бүтээмж, өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж зэрэг мэдээллээр үйлчилж байна. УЦУОСМХ дээрх бэлчээрийн экосистемийн төлөв байдлын үндэсний хэмжээний санг шинэчлэх, тогтвортой ажиллуулах, мэдээллийн чанар үнэмшлийг дээшлүүлэх, тоон мэдээллийг боловсруулж хэрэглэгчдэд хүргэх, олон улсын хэмжээний мониторингийн сүлжээнд холбогдох чадавх бэхжүүлэх зорилгоор мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтад хамруулахын зэрэгцээ сангийн программын шинэчлэл өөрчлөлтийн талаар АНУ-ын ХААЯ-ны Хорнадагийн ЭШТөвийн мэргэжилтэн Эрика Коуртрайт зөвлөн ажиллаж байна.

УЦУОСМХ бэлчээрийн төлөв байдлын мониторинг үнэлгээний улсын сүлжээний дэргэд инженер техникийн ажилтнуудыг чадавхжуулах давтан сургалтыг жил бүр зохион байгуулснаар мониторингийн эх мэдээг дахин шалгах, мэдээллийн санд зөв оруулсан эсэхийг тулгаж мэдээллийн сангийн баяжилтыг жил бүр хийж байна. Мөн бэлчээрийн төлөв байдлын тайлан, сэргэх чадавхын зураглал, өвөл хаврын бэлчээрийн даац багтаамжийг аймгийн түвшинд гаргаж орон нутгийн шийдвэр гаргагчид, малчдад танилцуулж байна. Энэ нь мэдээлэл үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах, орон нутаг дахь оролцогч талуудын үйл ажиллагааны уялдаа, хамтын ажиллагааг сайжруулахад чухал үүрэгтэй. Ус цаг уурын улсын сүлжээний нэг гол бүтээгдэхүүн үйлчилгээ болох “Бэлчээрийн сэргэх чадавхын цэгэн зураглал”-ыг растер зурагт хувиргаснаар зүүн бүсийн 4 аймаг (Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь), төвийн бүсийн 7 аймгийн (Улаанбаатар хот, Архангай, Булган, Дархан-уул, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймаг) бэлчээрийн 1:1000000 хэмжээст зургийг шинэчиллээ. Ийнхүү растер зурагт хувиргаснаар бэлчээрийн төлөв байдлын мониторинг, үнэлгээний системийн төлөөлөх байдал, мэдээлэл боловсруулалтын чанарыг нэмэгдүүлэх боломж нэмэгдэж байна.

ГХБХБГ дахь газрын харилцааны ЛМ программын бэлчээр ашиглалтын гэрээний мэдээлэл, гэрээт бэлчээрийн фотомониторингийн дүн мэдээллийн хэрэглээ нэмэгдэж, бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилт хянах, хариуцлагатай малчид, хариуцлагатай бүтээгдэхүүн тодорхойлох гол шалгуур болж байгаа тул орон нутаг дахь газрын харилцааны мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх давтан сургалтыг 12 аймагт зохион байгууллаа. Мөн ЛМ программын бэлчээр ашиглалтын гэрээ бүртгэх, фотомониторингийн мэдээлэл боловсруулалтын хэсэгт нэмэлт сайжруулалт хийснээр фотомониторингийн цэгүүд сэргэх чадавхаар ангилагдан өөр өөр өнгөөр харагдах, сонирхсон жилээр харьцуулалт хийх, холбогдох гарын авлага материалыг ашиглахын зэрэгцээ хавсралт мэдээллийг хэвлэх цэстэй болсноор даамлын ажлыг мэдэгдэхүйц хөнгөлж байна.

Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах гол арга хэрэгсэл болох бэлчээрийн сэргэх чадавх болон ашиглагчдад суурилсан

ашиглалтын загварын дагуу бэлчээр ашиглагчдыг зохион байгуулалтад оруулах, ашиглалтын хил зааг тодорхойлж зураглах, бэлчээрийн нөөцөд тохируулан ашиглалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр нөлөөг хянах, мониторинг үнэлгээний дүнг дараа дараагийн төлөвлөлтийн суурь болгон ашиглах суурь алхамуудаас тогтох олон талт хамтын ажиллагаанд суурилсан бүтэц бий болон ажиллаж байна. БАГ-ний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор БАХ-ийн бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх ажлын суурь үндэс болсон бэлчээрийн фотомониторингийг 18 аймагт сумдын газрын даамал, СБАХ тэргүүн, БМАХ-ийн гишүүд хамтран 320 сумын нутагт 4781 цэгт хийж мэдээллийг боловсруулан орон нутгийн удирдлага, малчдад мэдээлж, БАХ, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний суурь, бэлчээрийн төлөв байдлыг хянах гол хэрэгсэл болгон ашиглаж байна.

Төслийн хуучин 7 болон дунд шатны 4 аймагт БАГ-ний хэрэгжилтийг сайжруулах, бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан ашиглалтыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумдын АБАХ, СБАХ бэлчээрийн менежментийн ажлын хэсгүүдтэй хамтран зохион байгуулж байна. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, малын тоог даацад тохируулах, малын тоо, төрлөөс хамааран бэлчээрийн хураамж төлж бэлчээр хамгаалах сан байгуулах ажлыг баталсан Баянхонгор аймгийн Засаг Дарга, ИТХ-ын санаачилгыг Завхан, Архангай, Увс, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймагт хэлэлцэн туршиж байна. Завхан аймаг ХЗДХЯ-аар аймгийн журмаа батлуулж, дээрх 12 аймгийн 42 сумын ИТХ бэлчээр хариуцлагажуулах журмыг батлан хэрэгжүүлж байна.

Орон нутагт бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан ашиглалтыг хэрэгжүүлэх ажлыг сум, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан бэлчээрийн менежментийн ажлын хэсгүүд зангидан зохион байгуулж байна. Ховд, Завхан, Увс, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн 18 суманд байгуулагдсан бэлчээр хамгаалах санд нийт 268 сая төгрөг хуримтлагдаж, 6500 гаруй өрхийн малчид 165.2 сая, орон нутгийн төсөв, ОНХС-гаас 38.2 сая, НАМЭМ төслөөс 65 сая төгрөгийг бэлчээр сайжруулах арга хэмжээнд зарцуулахаар төвлөрүүлсэн байна. Үүнээс Ховд, Завхан, Увс, Говь-Алтай аймгийн 18 сум бэлчээр хариуцлагажуулах журмын хүрээнд бэлчээр хамгаалах/бэлчээрийн эрсдлийн сан үүсгэсэн бөгөөд Баян-Өлгий аймгийн сумд ХЗХ-доо 4 сан үүсгэсний нэг нь бэлчээрийн сан юм. Энэ оны 11 сарын байдлаар бэлчээр хамгаалах сангаас 78.7 сая төгрөгийг малчдын олонхийн саналаар малын өвс, тэжээл бэлтгэх, багийн өвс, тэжээлийн агуулах засах, оготно устгалын ажилд зарцуулсан байна. БАГ нь малчдын бэлчээр ашиглах уламжлалт эрхийг баталгаажуулж, бэлчээрээ зохистой ашиглах хариуцлагыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бэлчээр нутаг, нүүдэлчдийн соёл уламжлалаа хадгалан, хойч үедээ шилжүүлэх, гэрээт бэлчээр дэх байгалийн дагалт баялгаа ашиглах анхдагч эрхийг баталгаажуулах, мал, малын гаралтай бүтээгдэхүүнээ зах зээлд өндөр үнээр борлуулах эрх зүйн гол баримт бичиг болж байна. 2019 онд шинээр 235 БАХ СЗД-тай БАГ байгуулснаар БАГ байгуулсан БАХ-ийн тоо 16 аймагт 1065-д хүрлээ. Үүний 1004 буюу 94% нь хавсралт мэдээлэл бүрэн буюу БАХ-ийн бэлчээрийн төлөв байдлын мэдээлэл, ургац, даац, өрхийн тэргүүн, эзэгтэйн гарын үсэг бүхий мэдээллийг хавсаргаж шинэчилсэн БАГ байна. Малчид отор нүүдэл хийх, хадлан тэжээл бэлтгэх, худаг засварлах, малын үүлдэр угсааг сайжруулах, бодлогын бичиг баримт хэлэлцүүлж батлуулах зэрэг ажилд хамтран оролцож, улс, орон нутаг болон малчдаас нийт 1.5 тэрбум төгрөгийг бэлчээр сайжруулахад зарцуулсан байна. 2019 оны байдлаар 5 аймгийн 14 суманд нийт 20 гаруй БАХ бэлчээр хамгаалах, мал сүргээ эрсдлээс хамгаалах зорилгоор 80,7 сая төгрөгийн хөрөнгө бүхий бэлчээр хамгаалах/эрсдэлийн сан байгуулан, 13 сая гаруй төгрөгийг хадлан, тэжээл бэлтгэлтэй холбоотой ажилд зарцуулсан байна.

Бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан ашиглалтын хэрэгжилтийг хангах гол арга хэрэгсэл болох БАГ хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх орон нутаг дахь дэд бүтцийн тогтвортой байдлыг хангах үүднээс гэрээг Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлжүүлж, цахимжсан цогц мэдээлэл үүсгэж гэрээний эрхийг баталгаажуулах ажлыг

амжилттай эхлүүлээ. 2019 оны 11 сарын байдлаар хавсралт мэдээлэл бүрэн БАГ-ний 45% хувь буюу нийт 455 БАГ фотомониторингийн мэдээллийн сантай холбогдсон ЛМ-2 программд бүртгэгдлээ. Ингэснээр эдгээр 455 БАХ-ийн гэрээгээр ашиглаж буй бэлчээрийн эрх баталгаажлаа.

НАМЭМ төсөл, МБАНХ, ХАС банк хамтран бэлчээрийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих, малчдыг бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог төлөвлөгөөний дагуу аажмаар бууруулах, малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мал, мах бэлтгэж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг судлах "Ногоон бэлчээр" туршилтын төслийг Ховд аймгийн Чандмань суманд 2020 оны 10 сар хүртэл хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. "Ногоон бэлчээр" төслийн судалгаанд сумын нийт малчин өрхийн 73,4 хувь буюу 481 малчин өрх хамрагдсанаас "Хариуцлагын гэрээ" байгуулан хамтран ажиллах шалгуур үзүүлэлт хангасан 97 малчин өрх 500 сая төгрөгийн зээл авч, гэрээнд заасан үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2019 оны фотомониторингийн дүнгээр зээл авсан малчдын гэрээт бэлчээрийн төлөв байдал ерөнхийдөө тогтвортой, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу улирлын сэлгээг төлөвлөсний дагуу 100% хийж, 86 хувь нь малынхаа 10-аас доошгүй хувийг зах зээлд борлуулан гэрээний үүргээ биелүүлж байна.

МБАНХ-ны дэргэдэх "Хариуцлагатай нүүдэлчид" түүхий эд нийлүүлэлтийн эргэн мөшгөх системд "Сүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах мөшгөх тогтолцооны модуль" цахим системийг Дижитал медик, Витафит компани хамтран боловсруулж жил орчим хугацаанд хөгжүүлж бэлэн боллоо. Ингэснээр сүү боловсруулах үйлдвэрүүд тухайн модулийг ашиглан малчдаас авч буй сүүний чанар, эрүүл ахуйн холбоотой мэдээлэл, сүү нийлүүлэгч малчид/фермер, тэдний ашиглаж буй бэлчээр, малын эрүүл мэнд гэх мэт олон мэдээллийг бүртгэж, хэрэглэгчдэд гарал үүсэл нь тодорхой, хариуцлагатай малчдын нийлүүлсэн бүтээгдэхүүнээр үйлчилж буйгаа батлах, мөшгөх боломжтой болж байна. 2019 оны 3-11 дүгээр сард Витафит компани тус системийг ашиглан Төв аймгийн Борнуур, Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Мандал, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын 300 гаруй малчид/фермерээс 304 тн сүү худалдан авч, бүртгэлжүүлж, малчдад 243 сая төгрөгийн орлого оруулсан байна. Цахим системийн үр дүн болох гарал үүсэл тодорхой, эрүүл малын гаралтай бүтээгдэхүүний савлагаан дээр тавигдах QR кодыг шинээр байршуулахаар Витафит компанитай хамтран ажиллаж байна.

Монгол Улсын мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд дэмжлэг болох зорилгоор НАМЭМ төсөл МЭЕГ хамтран "Малын эрүүл мэндийн мөшгөх систем"-ийг 2017 оноос хөгжүүлж 2018 онд МЭЕГ-ын өмчлөлд албан ёсоор хүлээлгэн өгснөөр улсын хэмжээнд нэвтрүүлэх боломжтой болсон. Завхан аймаг 2019 оны орон нутгийн төсвөөс 105.0 сая төгрөг шийдвэрлэж, бусад зардлыг НАМЭМ төсөл, МЭЕГ гаргаж аймгийн хэмжээнд нэвтрүүллээ. Ингэснээр Завхан аймгийн нутаг дэвсгэрээс гадагш гарч байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлгийн цахим гэрчилгээ олгож, 2019 оны 5-11 сард нийт 3785 гэрчилгээ бичигдсэн байна. Малын эрүүл мэндийн мөшгөх системийг нэвтрүүлэхээр Ховд аймаг 76.8 сая, Говь-Алтай аймаг 63.2 сая, Увс аймаг 78.8 сая, Баянхонгор аймаг 115.0 сая, Дархан-Уул аймаг 31.2 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс шийдвэрлэж, 2019 онд багтаан аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэхээр НАМЭМ төсөл, МЭЕГ гэрээ байгуулан ажиллаж байна. Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймаг болон нийслэлийн Мал эмнэлгийн газар малын эрүүл мэндийн мөшгөх системийг ирэх онд бүрэн нэвтрүүлэх сонирхлоо илэрхийлсэн.

Хариуцлагатай үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг үндэсний, олон улсын түвшинд баталгаажуулах, үйлдвэрлэгчид, бизнесийн салбарынхантай холбох тал дээр тодорхой ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, гарал үүсэл нь тодорхой ноос ноолуур, мах, сүүн бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог нэвтрүүлэн, байгаль орчинд ээлтэй, нэмүү өртөг шингэсэн, үр ашигтай үйлдвэрлэл эрхэлдэг компаниар дамжуулж хэрэглэгчдэд нийлүүлэх

ажлыг ХХААХҮЯ, МБАНХ, АБАХ, 29 сумын ЗДТГ, СБАХ, Дижитал медик ХХК, сумын мал эмнэлэг, малчдын төлөөлөл хамтран 29 сумыг загвар болгохоор туршиж байна. 2019 онд МБАНХ-ны дэргэдэх Ногоон алт дундын хоршоо Мах маркет компанитай 50000 мал нийлүүлэх гэрээ байгуулж, Ногоон алт дундын хоршоо, АБАХ, СБАХ, тэдгээрийн дэргэдэх хоршоодоор дамжуулан нийт 140,528 толгой мал борлуулсан нь өнгөрсөн оноос 2.7 дахин нэмэгдсэн байна.

ХХААХҮЯ, Ховд аймгийн ИТХ, Ховд аймгийн ЗДТГ, НАМЭМ төсөл, МБАНХ, Ховд аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо хамтран бэлчээрийн үндэсний III форумыг бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн доройтлыг хязгаарлах, зүй зохистой ашиглалтыг нэвтрүүлэх, малчны хариуцлагыг өндөржүүлэх замаар хойч үедээ өвлүүлэн үлдээх хүндтэй үүргийг хүлээсэн орон нутгийн малчдад нэгдсэн мэдээлэл өгөх, харилцан туршлага солилцох, цаашдын оролцоог тодорхойлох зорилгоор “Ногоон хөгжлийн төлөөх хариуцлагатай малчид” уриан дор зохион байгууллаа. Нийт 500 орчим оролцогчтой форумар бэлчээрийн чанар бүтээмжийг тогтвортой хадгалах, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр бусдыгаа манлайлагч хариуцлагатай малчид, хариуцлагатай БАХ-ыг алдаршуулан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх боломж бүрдүүллээ. Дундын бэлчээрээ хамтдаа зохистой ашиглаж буй малчид мал ахуйгаа хөтөлж байгаа, малын түүхий эдийн болон хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлж буй орон нутгийн сайн туршлага, сургамжийн талаар малчдад танилцуулж туршлагаа хуваалцлаа.

Төслийн гэрээт байгууллага болох МБАНХ нь БАХ, малчдын ашиг, сонирхлыг хамгаалах үндэсний хэмжээний дээвэр холбоо болж олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж байна. МБАНХ 2019 онд Хас Банк хамтран Ховд аймгийн Чандмань суманд “Ногоон зээл” төсөл, Европын холбооны SWITCH ASIA төслийн Ядуурлыг бууруулах, Монгол улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилго бүхий “Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, Эко шошгожуулалт” төсөл, Олон улсын хөдөө аж ахуйн сан (IFAD)-ийн “Зах зээл ба бэлчээрийн удирдлага” төсөл, НҮБ-ын ХХААБ-ын “Нүүдэлч, малчдын мэдээллийн сан бүрдүүлэх” төсөл зэрэг 4 томоохон төслийг хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжүүлж байна. МБАНХ нь 2019 онд УИХ, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, Ховд аймгийн ЗДТГ, АБАХ-тай хамтран “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” үндэсний хэлэлцүүлэг, Бэлчээрийн үндэсний III форумыг зохион байгуулж, 1300 гаруй малчид хоорондоо туршлага судлах, суралцах, бэлчээрийн эрх зүйн орчныг сайжруулах талаар төр засгийн бодлого шийдвэрт саналаа тусгах боломж олгосон.

ТАВ. ТӨСЛИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТ.

5.1. ҮР НӨЛӨӨ 1.

БАХ, БАГ-г ӨРГӨЖҮҮЛЭН НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЗОХИСТОЙ ТОГТОЛЦОО ТӨЛӨВШҮҮЛЭХ.

НАМЭМ төслөөс 2019 оны хувьд бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, мониторинг, бэлчээр ашиглалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага болон орон нутаг дахь холбогдох мэргэжилтнүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг уялдуулан хамтын ажиллагааг сайжруулж бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, Бэлчээр ашиглалтын гэрээнд заасан үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нэг талаас бэлчээр ашиглагчид болох малчид, бэлчээр ашиглагчдын хэсгүүд, нийтийн өмч болсон бэлчээрийн газрын зохион байгуулалт, хяналт үнэлгээг хариуцдаг мэргэжлийн байгууллага, ЭШХ, агентлагууд, бодлого боловсруулагчдыг чадавхжуулах, уялдаа холбоог сайжруулах, бэлчээрийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ өндөр хэвээр байна.

5.1.1. Үр дүн 1.1

Төслийн хамтран ажиллаж буй 11 аймгийн БАХ-гүүд БАГ байгуулж хэрэгжүүлнэ

НАМЭМ төсөл нь орон нутагт бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, бэлчээрийн харилцааг хариуцлагажуулах, малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэлэмж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор МБАНХ-гоор дамжуулан 2019 онд 183 суманд 1504 БАХ-тэй хамтран ажиллалаа. Үүнээс төслийн хуучин 7 аймаг, дунд шатны 4 аймгийн 143 суманд нийт 1243 БАХ буюу нийт БАХ-ийн 82% нь хамтран ажиллаж байна. Төслийн хуучин 7 аймагт бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, БАХ-ийн БАГ-ний хэрэгжилтийг сайжруулах, БАГ-г газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

НАМЭМ төсөл, МБАНХ-ноос БАГ-ний хэрэгжилт, хяналтыг сайжруулах, бэлчээрийн харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, бэлчээрийн зохистой ашиглалтыг дэмжсэн бодлого, эрх зүйн орчин бий болгох чиглэлээр 18 аймгийн 157 суманд аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан БМАХ-тэй хамтран ажиллалаа. Ажлын хэсэгт орон нутгийн төрийн болон ТББ, БАХ-ийн малчдын төлөөлөл болох 1650 гаруй хүн ажиллаж байна. БМАХ нь БАХ/БАГ-ний тогтвортой байдлыг хангах, орон нутагт бэлчээрийн тогтвортой менежмент хэрэгжүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг уялдуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. 2018 оноос эхлэн Баянхонгор аймгийн загвараар аймаг, сумын БМАХ-тэй хамтран бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг боловсруулж, малчид, аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласнаар 2019 оны 12 сарын 01-ний байдлаар 12 аймаг, 42 сум бэлчээр хариуцлагажуулах журмаа аймаг, сумын ИТХ, ХЗДХЯ-аар батлуулсан байна.

Ховд, Завхан, Увс, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн 18 суманд байгуулагдсан бэлчээр хамгаалах санд нийт 268 сая төгрөг хуримталсан ба үүнд 6000 гаруй малчин өрхөөс 165.2 сая, орон нутгийн төсөв, ОНХС-гаас 38.2 сая, НАМЭМ төслөөс 65 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Ховд, Завхан, Увс, Говь-Алтай аймгийн 18 сум бэлчээр хариуцлагажуулах журмын хүрээнд бэлчээр хамгаалах/бэлчээрийн эрсдлийн сан үүсгэсэн бөгөөд Баян-Өлгий аймгийн сумд ХЗХ-доо 4 сан үүсгэсний нэг нь бэлчээрийн сан юм. Энэ оны 12 сарын байдлаар бэлчээр хамгаалах сангаас 31.7 сая төгрөгийг малчдын олонхийн саналаар малын тэжээл бэлтгэх, багийн өвс, тэжээлийн агуулах засах, оготно устгах ажилд зарцуулсан байна. Аймаг, сумд жил бүр санд төвлөрөх дүнг малын тоонд үндэслэн шинэчлэх юм.

Завхан аймгийн БМАХ-ийн гишүүд аймгийн бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын төслийг аймгийн ИТХ-ын ээлжит 6-р хуралдаанаар хэлэлцэн баталж, ХЗДХЯ-нд бүртгүүлснээр бэлчээрийн чиглэлээр аймгийн хэмжээнд баримтлах томоохон бодлогын дэмжлэг бий болсон. Мөн АБАХ-ноос аймгийн мал эмнэлгийн газартай хамтран малын эрүүл мэндийн мөшгөх системийг туршилтаар хэрэгжүүлж буй ажил, түүний ач холбогдол, үр дүнгийн тухай, системийг аймгийн бүх сумдыг хамруулан хэрэгжүүлэх, хамтран ажиллах талаар орон нутгийн удирдлагуудад танилцуулсны үр дүнд аймгийн Засаг даргын 2019 оны үндсэн чиглэлд Малын эрүүл мэндийн гарал үүслийн мөшгөх тогтолцоог НАМЭМ төслийн загвар сумдаас бусад бүх сумдад нэвтрүүлэх ажлыг тусгаж хөрөнгийн эх үүсвэр болох 105 сая төгрөгийг батлуулан, аймгийн ЗДТГ, МЭГ, ХХААГ, АБАХ хамтран бүх сумдад “Малчдын зөвлөгөөн 2019” зохион байгуулж малын эрүүл мэндийн мөшгөх тогтолцоо болон аймгийн бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг малчдад танилцууллаа. Бэлчээр хариуцлагажуулах журмыг Сантмаргаз, Шилүүстэй сумд батлан хэрэгжүүлж Сантмаргаз, Шилүүстэй, Тэс сумдад бэлчээрийн эрсдлийн сан байгуулан, 1028 малчин өрх санд хөрөнгө төвлөрүүлж, 60.4 сая төгрөгийн хөрөнгө бүхий сан бүрдсэн байна. Тэс сумын малчид олонхийн саналаар сангийн хөрөнгөөс 6.6 сая төгрөгийг малын тэжээл бэлтгэхэд зарцуулж бэлчээрийн санг орон нутагтаа бүрдүүлж, үр шимийг нь хүртсэн байна.

Говь-Алтай аймгийн АБАХ, Баян-Уул сумын СБАХ нь сумын удирдлага болон БМАХ-ийн гишүүдтэй хамтран ажиллаж, сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг Багийн ИНХ-аар хэлэлцүүлэн малчдын саналыг тусгаж, 2018 оны 12 сард сумын

ИТХ-аар батлуулсан байна. Журмын хүрээнд баг тус бүрт бэлчээрийн эрсдлийн сан байгуулж малчид өөрийн малын хонин толгой тутамд 100 төгрөгийг сандаа жил бүр сайн дураар төвлөрүүлэх болон сангийн хөрөнгө бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавихтай холбоотой заалтуудыг тусган баталсан. Энэ журмын дагуу тухайн жилд бэлчээрийн эрсдлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг багийн Засаг дарга гаргаж малчин өрх бүрт хүргэх, төвлөрсөн хөрөнгийн 70-80 хүртэл хувийг БАХ, Багийн ИНХ-аар хэлэлцэж олонхийн санал авч баталсан ажилд захиран зарцуулах, жилийн эцсийн мал тооллогын дүнгээр дараа онд төвлөрөх сангийн хөрөнгийн тооцоог гаргах замаар эрсдлийн сангийн хөрөнгийг байнгын эргэлттэй тогтвортой байлгах, банкны дансны нэгдүгээр гарын үсгийг багийн Засаг дарга, багийн Засаг даргатай ашиг сонирхлын зөрчилгүй нэг малчныг малчид дундаасаа сонгож хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг олгох, хяналтын зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2 жил тутам сольж байхаар тусгасан байна. 2019 оны 8 сарын 1-ний байдлаар 612 малчин өрхийн 18.6 сая төгрөг эрсдлийн санд төвлөрсөн байна. Сум өөрийн хадлангийн талбайгүй тул жил бүр өөр аймаг, сумын нутгаас өвс бэлтгэж цаг хүндэрсэн үед 1 боодол өвсийг 15 мянга хүртэл төгрөгөөр авч хүндрэл бэрхшээлтэй байнга тулгардаг, 2019 оны өвөл цаг хүндрэх төлөвтэй тул малчид сангийн хөрөнгөөр энэ онд малын өвс, тэжээл худалдан авах, оготно устгалд зарцуулах шийдвэр гарган хэрэгжүүлжээ. Тухайлбал, Баян тал БАХ-ийн малчид хураамжаа 100% төвлөрүүлж, сангийн хөрөнгөөр худалдан авсан 15 тонн өвсийг малчиддаа хуваарилж, мөнгөө буцаан байршуулж дахин тэжээлийн нөөц бүрдүүлэхээр шийдвэрлэсэн байна. Журам хэрэгжүүлснээр бусад сумын малчид дур мэдэн бэлчээрийн хил зааг зөрчиж маргаан үүсэх явдал багассан. Тухайлбал, бэлчээр хариуцлагажуулах журмын дагуу зэргэлдээх Халиун сумын малчид бэлчээр ашигласны хураамжаа эрсдлийн санд төлөөд тус сумын нутагт өвөлжих зэргээр хариуцлагажуулах журам жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэллээ.

Сумдын БМАХ, малчид бэлчээр хариуцлагажуулах журам хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна. Ховд аймгийн Дуут сумын БМАХ-ийн гишүүн “Шивэр” багийн Засаг дарга Соронзонболд: “Сумын БМАХ 2018 онд бэлчээр хариуцлагажуулах журмыг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Манай баг 3 БАХ-тай, Хөшөөт БАХ-ийн нутагт зэргэлдээх Баян-Өлгий аймгийн Буянт сумын малчид ирж зусдаг, бэлчээр их доройтолтой. Бид малчид, цагдаа, байцаагчтайгаа явж ирсэн айлуудыг оруулахгүй гэж хөөдөг, торгууль тавьдаг байсан. Энэ жил БМАХ-ийн төлөвлөгөөнд тусгасны дагуу тус зуслангийн бэлчээрт 10 хоног пост ажиллуулж зэргэлдээх сумын малчдад шаардлага тавьж мэдэгдсэнээр, өмнөх жил 80-90 өрх, хамгийн багадаа 50 өрх зусдаг байсан бол энэ жил 20 өрх л зуссан. Буянт сумын “Нарийн” багийн Засаг дарга, малчидтай нь зөвшилцсөний дагуу тэдгээр 20 өрх 7 сарын 20-25-ны хооронд бэлчээр чөлөөлж нүүсэн бөгөөд өрх бүр 100 боодол буюу нийт 2000 боодол өвс бэлчээр ашигласны төлбөрт өгөхөөс 11 сарын байдлаар 1500 боодлыг тус БАХ-ийн малчдад өгсөн байна”.

Малчид БАГ байгуулж бэлчээрээ зүй зохистой ашиглаж, хамгаалахаар ажиллаж байна. 2019 онд аймаг, сумдын БМАХ-тэй хамтран хуучин 7 аймагт өмнө байгуулсан БАГ-г шинэчилсэн загварт шилжүүлэх, хавсралт мэдээллийг гүйцээх, улсын газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх чиглэлээр илүүтэй анхаарал хандуулсан бол дунд шатны 4 аймаг БАГ-г малчид, орон нутгийн засаг захиргаанд танилцуулах, гэрээний хавсралт мэдээг бүрдүүлэх, тус бүр 18 БАГ байгуулж бүртгүүлэхээр ажиллажээ. Ингэснээр төслийн аймгуудын хэмжээнд нийт 1065 БАГ байгуулагдсаны 1004 нь шинэчилсэн маягт бүхий хавсралт мэдээлэл бүрэн БАГ бөгөөд нийт БАГ-ний 90%-ийг хуучин болон дунд шатны 11 аймагт байгуулж бэлчээрээ сайжруулахаар малчид хамтран ажиллаж байна.

Малчид БАГ хэрэгжүүлэхэд шаардлагатай жижиг төсөл хэрэгжүүлж байна: Бэлчээр ашиглалтын гэрээнд заасан үүрэг хариуцлага болон тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан ажлаа хэрэгжүүлэхэд малчдад туслах зорилгоор бэлчээр хамгаалах, малын тэжээл тариалах, бэлчээрийн усан хангамж болон ашиглалтыг сайжруулах,

нэмэгдүүлэх, оготно устгал, малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр 16 аймгийн 66 сумын малчид, малчдын байгууллагад жижиг төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүллээ. Нийт 102 төсөл хэрэгжүүлснээс 66% нь хадлан, тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлэхэд зарцуулсан байна.

Архангай аймгийн АБАХ, бэлчээрийн менежментийг сайжруулах, БАГ-ний хэрэгжилт хангах, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, тэжээлийн нөөц хангамж нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 сумын 6 төсөлд 10.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Малчид өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл, солом тариалах, хадлан бэлтгэх төсөл хэрэгжүүлснээр өвөл, хавар цаг хүндэрсэн үед малаа тэжээх 350 тн хадлан, 28 тн тэжээл бэлтгэлээ. Өвөлжөөний бууцанд солом тариалах болон байгалийн хадлан бэлтгэх эдгээр жижиг төслийн үр дүнд бэлчээрийн даац багтаамж хэтэрсэн, малд идэх жилийн өвс тэжээлийн хүрэлцээ хангамж дутагдалтай БАХ-ийн малчид шаардлагатай нэмэлт тэжээлээ хямд өртгөөр бэлтгэснээр мал аж ахуй болон өрхийн амьжиргааны хувьд эрсдэл багасах, бэлчээрийн ачааллыг хөнгөвчлөх үр дүнтэй байна гэж үр дүнг хүртсэн 4 сумын 16 БАХ-ийн малчид баяртай байна. Өвс хадлан, гар тэжээл бэлтгэх үйл ажиллагааг тухайн сумдын СБАХ удирдан чиглүүлж, арга зүйн зөвлөгөө өгөх, зохион байгуулж хамтран ажиллалаа.

Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумын 11 БАХ нийт 60 га талбайд хошуу будаа, гурвалжин будаа, арвай, вандуйны холимог ногоон тэжээл, 10 га талбайд царгас тариаллаа. Сум, орон нутгийн удирдлагаас дэмжиж бэлчээр ашиглах хэсгийн малчдад хүн хүч, техникийн туслалцаа үзүүллээ. ХХААХҮЯ-ны ХААШУОНТ “Тайшир өргөө” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан сайн чанарын үрээр хангаж, тус компанийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийн тусламжтайгаар үрийн нормыг тооцоолон тарилт хийв. Хоёр сумын хэмжээнд нийт 114.5 тн холимог тэжээл хураан авч 11 БАХ-ийн малчид малаа нэмэлт тэжээлээр тэжээж бэлчээрээ тодорхой хугацаанд амраах нөхцөл бий болж байна. ХААШУОНТ-ийн зөвлөхүүд малчдад тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалах агротехнологи сэдвийн хүрээнд үр бэлтгэх, тарих талбай сонгох, хамгаалалт хийх, хөрс боловсруулах, тариалах хугацаа, тариалах арга, үрийн норм, үр суулгах гүн, арчилгаа, хураалт, малын тэжээл бэлтгэх боломж, ургамлыг зөв сонгон тариалах, газар тариалангийн талбайг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах, бусад техник хэрэгсэл ашиглах арга ажиллагааны талаар нийт 160 гаруй малчин сургалтад хамрагдаж, гарын авлагаар хангагдсан байна.

Сүмбэр сумын 5 БАХ-ийн малчид 28 тн тэжээл хурааж авснаас 18 тн-ыг малчдад хуваарилж, 10 тн тэжээлээр дарш бэлтгэн борлуулж ирэх жил тэжээл тариалах үрийн нөөц болон уринш хийх зардлаа гаргаж авахаар шийдвэрлэжээ.

Жижиг төслийн санхүүжилтээр малын үүлдэр угсааг сайжруулж малаа чанаржуулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо бүрдүүлэх зорилгоор сайн үүлдрийн хээлтүүлэгчээр хангах ажлыг сумын СБАХ, ХААТ, малчид хамтран зохион байгуулсан. Сүмбэр сумын 5 БАХ гарал үүслийн гэрчилгээ бүхий сүүний чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн 5 бухан бяруу, Баянцагаан үүлдрийн 18 өсвөр хуц, 2 ухна, Борнуур сумын 3 БАХ Дорнод аймгийн Хөлөнбуйр сумаас үзэмчин үүлдрийн 4 өсвөр хуц, 1 ухна, Голштен үүлдрийн 1 бухан бяруу, махны чиглэлийн Эдельбай үүлдрийн 4 хурган хуц, хар тарлан үүлдрийн бухтай болжээ.

БАГ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд малчид малын тоог бэлчээрийн даацад тохируулахаар ажиллаж байна: Увс аймгийн Давст, Бөхмөрөн сумын БМАХ бэлчээр сайжруулахын тулд мал чанаржуулах, малын тоог бууруулах бодлого барьж, сумын мал зүйч, ХААИС-ийн багш нартай хамтран боловсруулсан БАХ-ийн сүргийн эргэлтийн төлөвлөгөөг малчдад танилцуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. АБАХ-ны зүгээс “Мах маркет” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, малчдаас мал бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулснаар Давст сумын ажлын хэсэг Давс эрдэнэ, Тун мэнд, Бичигт хад, Мөнх цахир БАХ-ийн малчдаас зах зээлд нийлүүлэх малын судалгаа авах ажлыг

зохион байгуулж, нийт 58 малчин өрх 8991 толгой мал, Бөхмөрөн сумын малчид 627 мал Мах маркет компанид нийлүүлэх боломжтойг тогтоосон. Гэрээний хүрээнд Давст сумаас 360 ямаа, 300 хонь буюу 660 толгой бог мал, Бөхмөрөн сумын малчид 7471 толгой мал Мах маркет компанид нийлүүллээ. Сүргийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу Давст сум 2019 онд малын тоог 22035 толгойгоор бууруулахаас 11,200 толгой мал буюу 51%-ийг, Бөхмөрөн сум малын тоог 176,669 толгойгоор бууруулахаас малчдын зах зээлд нийлүүлсэн болон хүнсэндээ хэрэглэсэн малын тоо 7471 толгой буюу 4.2 % боллоо.

Завхан аймгийн загвар сумдад малын тоог бэлчээрийн даацад тохируулах, ХААИС-тай хамтран хэрэгжүүлж буй сүргийн эргэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БАХ-ийн сүргийн эргэлтийн төлөвлөгөө, түүнд суурилан малаа зах зээлийн эргэлтэд оруулж борлуулах талаар малчдад сургалт хийлээ. Тус төлөвлөгөөний дагуу 4 суманд нийт 157,138 хонин толгой мал борлуулах төлөвлөгөө гарсан бөгөөд Эрдэнэхайрхан сум 3144 толгой хонийг Мах маркет компанид, Завхан хүнс компанид 1774 толгой хонь, зах зээлд 2497 мал буюу нийт 7415 толгой мал, Шилүүстэй сум 6729 толгой мал, Баянтгэс сум 17056, Сантмаргаз сум 18,209 толгой мал, нийт 49,409 мал борлуулсан байна.


Завхан аймагт нэвтрүүлж буй Малын эрүүл мэндийн гарал үүслийн мөшгөх тогтолцооны ажлын хүрээнд 2019 оны 12 сарын 18-ны байдлаар тус аймгаас цахим бүртгэлд хамрагдсан, гарал үүсэл тодорхой 97057 толгой мал, 730 тн махыг зах зээлд борлуулахаар 4243 цахим гэрчилгээ авч үйлчлүүлсэн байна.

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын улсын хошой аварга малчин Г.Лхаживынх 2018 оны тооллогоор 2378 мал тоолуулсан. Тэрээр малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, эрүүл чанартай малтай, хариуцлагатай малчин болох өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлэхээр бусад малчиддаа, ялангуяа мянгат малчдыг уриалж манлайлан ажиллахаа илэрхийлж, сумын ХААТ-ийн үржлийн мэргэжилтэн Гантулгатай хамтран өрхийн сүргийн эргэлтийг 3 жилээр төлөвлөж гаргасны дагуу 2019 онд малын тоог 880 толгойгоор бууруулахаас зах зээлд 635 толгой мал борлуулж, өөрийн хүнсний хэрэглээнд 53 мал хэрэглэсэн байна. Мөн хүүхдээ гэр бүл болоход нь 515 толгой мал шилжүүлжээ. Ингэснээр төлөвлөсөн малынхаа 78.1 хувийг зах зээлд борлуулж, өрх тусгаарласан хүүдээ мал шилжүүлж өгснөөр төлөвлөгөөний биелэлт 137% болсон байна. Аварга малчин Лхажив 2017 онд ОНХС-гийн 10 сая төгрөгийн санхүүжилтээр ингэний ферм ажиллуулж байна.

Малчид БАГ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж байна: БАГ-ний хүрээнд БАХ-ийн малчид бэлчээрийн эрсдлийн сан байгуулж жил бүр малын тэжээл бэлтгэл, хадлангийн хашаа барих, засах зэрэг үйл ажиллагаанд зарцуулж байна. 2019 оны байдлаар 5 аймгийн 14 сумын 24 БАХ 80.7 сая төгрөгийн сан байгуулан, 12.8 сая төгрөгийг хадлангийн хашаа барих, ногоон тэжээл тариалах, тэжээлийн агуулах засварлахад зарцуулсан байна.

БАГ-ний хүрээнд малчид бэлчээрээ сэргээн сайжруулж байна: Төсөл хэрэгжиж буй бүх аймаг, сумдад малчид БАГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлж бэлчээрээ сэргээж, сайжруулахын тулд улирлын нүүдэл, сэлгээний төлөвлөгөө гарган мөрдөн ажиллаж байна.

Архангай аймгийн Их тамир сумын Хөх нуур, Хужир улаалзай, Хөхдаваа, Алтан сандал, Ар зуу, Ишгэнт, Бугат, Хүнүйн гол зэрэг 8 БАХ зун намрын улиралд давтан ашиглаж ирсэн 33200 га бэлчээрийг 2019 оны 6-8 сард чөлөөлж, сэлгэн ашигласны үр дүнд бэлчээрийн ургамлын бүрхэц, ургацын хэмжээ, малд идэмжтэй ургамлын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд өссөн үр дүнтэй байна.



2017, 2019 оны фотомониторингийн үр дүнгээр бэлчээрээ сэлгэж ашигласан газруудын халцгай газрын эзлэх хэмжээ тодорхой хэмжээгээр багассан, ургамлын төрөл зүйлийн тоо нэмэгдсэн, ургацын хэмжээ Хужир Улаалзай БАХ-ийн судалгаан дээр нэмэгдсэн зэрэг нь бэлчээрийн сэлгээ үр дүнтэй болсныг илтгэж байна.

Увс аймгийн Давст сумын Торхилог, Хандгайт багийн Тунд мэнд, Давс-Эрдэнэ БАХ-ийн 50 малчин өрх Шавартын голын зуслангийн доройтсон бэлчээрийг сэргээхээр зуслангийн бэлчээрээ зун, намрын дөрвөн сарын хугацаанд 36375 толгой малын хөлөөс 100 хувь чөлөөлж 125 км зайтай нүүдэллээ. Энэ ажлыг сумын БМАХ, СБАХ, ХЗХ хамтран зохион байгуулж, малчдын нүүдэл хийхэд шатахууны дэмжлэг үзүүлж, зохион байгуулсан байна. Малчид бэлчээрээ чөлөөлсөн, зун хур тунадас сайтай байсны үр дүнд бэлчээр тодорхой хэмжээнд сэргэж үр дүнгээ өглөө. Бэлчээр сэлгэсэн 2 БАХ-ийн бэлчээрийн фотомониторингийн 2018-2019 оны дүнг харьцуулахад ургац нэмэгдэж, бэлчээрийн сэргэх чадавхын ангиллаар II-IV шатлалд хамрагдаж байсан бэлчээр I-III ангилалд шилжсэн байна.

Бэлчээрийн даац ачаалал, тэжээллэг чанар, сүргийн бүтэц, сүргийн эргэлтийг экологийн чадавхад тохируулах чиглэлээр ХААИС-тай хамтран ажиллаж байна: Ийнхүү мал сүргийн бүтэц, сүргийн эргэлтийг тухайн орон нутгийн нийгэм, экологи, эдийн засаг, зах зээлийн нөхцөлд тохируулах, МАА-н үйлдвэрлэлийн орлого, зарлага, эдийн засгийн үр ашгийг өрхийн аж ахуй, малчдын бүлэг, хэсэг, баг, сумын хэмжээнд төлөвлөж, малчдын орлогыг бууруулахгүйгээр мал сүргийн тоо, толгойг бэлчээрийн даацад тохируулах зорилгод нийцүүлэн бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийх аргачлалын дагуу сүргийн эргэлтийг тооцох, төлөвлөх вебэд суурилсан программ (bams.digitalmedic.mn)-ыг төслийн хүрээнд боловсруулж, 10 аймгийн 24 суманд ХААИС-тай хамтран хөгжүүлж туршлаа. Тус программ хангамжийг ашигласнаар бэлчээрийн монгол малын нөхөн үржихүйн норм, норматив, ашиг шим, бүтээгдэхүүн, түүхий эдийн стандарт үзүүлэлтийн дагуу мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийх боломж бүрдэж байгаа тул "Сүргийн эргэлт боловсруулах аргачлал, тооцоолох программын заавар"-ын гарын авлагыг 500 хувь хэвлэж ХХААХҮЯ-тай хамтран Монгол Улсын бүх аймаг, сумдын мал аж ахуйн мэргэжилтнүүдэд хүргүүлэв. Мөн тус төслийн хүрээнд малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдэд зориулан "Халгай лууль зэрэг олдоц, арви ихтэй ургамлаар дарш бэлтгэх

арга", "Бэлчээрийн мал сүргийн эргэлт тооцоолох программ" гэсэн 2 видео кино хийж олны хүртээл болгов. Программ хангамжид сүргийн эргэлтийг тооцохдоо бэлчээрийн одоогийн ачааллыг хонин толгойгоор тооцож, тухайн бүс нутгийн малын төрлийн зохистой харьцааны хувьд 1980-1985 оны дундаж үзүүлэлтийг удиртгал болгож, зах зээлийн одоогийн эрэлтэд нийцүүлэн тооцсон. Загвар 24 суманд малын тоо даацаасаа 11-154 хувиар хэтрэлттэй, ялангуяа Архангай, Өвөрхангай аймгийн хувьд хамгийн их хэтрэлттэй, харин сүүлийн хоёр жил дараалсан ган, зудын нөлөөгөөр Завхан, Говь-Алтай аймгийн зарим сумдад нөхцөл байдал арай ялгаатай, даацаас хэтэрсэн малын тоо 30 хүртэл хувьтай байна.

Бүс нутгийн экологийн онцлог, малын үүлдэрлэг байдал, зах зээлийн эрэлттэй нийцүүлэн байгаль экологид сөрөг нөлөөгүй, эрсдэл даах чадвартай, тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэлийн загварыг бий болгох зорилгоор загвар сумдын хэмжээнд бэлчээрийн даац, ачааллын одоогийн түвшин, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо, хээлтэгчийн эзлэх хувь, зүй бус хорогдол, заазлалтын норматив үзүүлэлтэд тулгуурлан сүргийн эргэлтийн төлөвлөлтийг сумын хэмжээнд 10 жилээр тооцож, аймаг, сумын мал аж ахуйн мэргэжилтнүүдийн боловсруулсан 10 аймгийн 24 сумын 228 БАХ-ийн сүргийн эргэлтийн тооцооллыг ХААИС-ийн багш нар хянаж, баталгаажуулсан. Сүргийн эргэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр борлуулах малын тоог шинээр нэмэгдэх төлийн хувиас гадна аажмаар буюу 8 хувиас ихгүй үргэлжлүүлэн бууруулах нийтлэг зарчим баримталсан. Загвар сумдын сүргийн эргэлтийн тооцоололд үндэслэн 2019 онд 24 суманд 2,080,746 хонин толгой малыг зах зээлд борлуулахаар төлөвлөсөн ба төлөвлөгөөний биелэлт 32.35 хувьтай байна.

Загвар сумдад нийт 690,884 хонь борлуулахаар төлөвлөснөөс 26.3 хувь буюу 181,492 толгой хонийг зах зээлд борлуулсан байна. Үүнээс, Хөвсгөл аймгийн Арбулаг, Цэцэрлэг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төлөвлөлтийн биелэлт 60 хувиас их байгаа бол Өвөрхангай аймгийн Уянга, Баянхонгор аймгийн Богд, Говь-Алтай аймгийн Чандмань, Дэлгэр, Ховд аймгийн Чандмань, Мөнххайрхан, Дуут, Архангай аймгийн Их тамир, Өндөр-Улаан, Тариат сумын төлөвлөлтийн биелэлт 10 хувиас бага байна.

Загвар сумдад нийт 572,312 ямаа борлуулахаар төлөвлөснөөс 17.1 хувь буюу 98,117 толгой ямааг зах зээлд борлуулсан байна. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Увс аймгийн Бөхмөрөн сум 60 хувиас их борлуулалт хийсэн бол Өвөрхангай аймгийн Уянга, Баянхонгор аймгийн Богд, Говь-Алтай аймгийн Чандмань, Баян-Өлгий аймгийн Буянт, Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Архангай аймгийн 3 сум, Ховд аймгийн 2 сум 10-аас бага хувийн борлуулалттай байна. Ямааны аж ахуйн төлөвлөлтийн гүйцэтгэл бусад төрлийн малаас бага байгаа нь ямааны ноолуурын үнэ өндөр байгаатай холбоотой.

Загвар сумдад нийт 97036 үхэр борлуулахаар төлөвлөснөөс 48.5 хувь буюу 47018 толгой үхрийг зах зээлд борлуулсан байна. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Төв аймгийн Өндөрширээт, Завхан аймгийн Баянтэс сумын төлөвлөлтийн биелэлт 50 хувиас их байгаа бол Архангай аймгийн Өндөр-Улаан сум 181,2, Завхан аймгийн Сантмаргаз сум 141,9 хувиар тус тус төлөвлөлтийг давуулан борлуулсан байна.

Загвар сумдад нийт 53985 адуу борлуулахаар төлөвлөснөөс 33,4 хувь буюу 18031 толгой адууг зах зээлд борлуулсан байна. Баянхонгор аймгийн Богд, Завхан аймгийн Баянтэс, Сантмаргаз, Шилүүстэй, Хөвсгөл аймгийн Арбулаг, Архангай аймгийн Өндөр-Улаан сум 50-аас дээш хувийн биелэлттэй байсан бол Өвөрхангай аймгийн Уянга, Говь-Алтай аймгийн Чандмань, Увс аймгийн Бөхмөрөн, Давст, Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Архангай аймгийн Их тамир сумын борлуулалтын хувь 10-аас бага байна.

Загвар сумдад нийт 749 тэмээ борлуулахаар төлөвлөснөөс 88.5 хувь буюу 661 толгой тэмээ зах зээлд борлуулсан байна. Загвар сумдын мал борлуулалтыг ерөнхийд нь үзэхэд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Баян-Өлгий аймгийн Улаанхус, Увс аймгийн Бөхмөрөн, Завхан аймгийн Баянтэс, Сантмаргаз, Хөвсгөл аймгийн Арбулаг, Цагаан-Уул, Цэцэрлэг,

Төв аймгийн Өндөрширээт суманд мал борлуулах төлөвлөлтийн биелэлт сайн байна. Харин малын төрөл дотор хамгийн өндөр хувьтай бууруулахаар төлөвлөсөн ямааны борлуулалт нийт дүнгээрээ бага хувьтай, бод малын борлуулалт өндөр байна.

Эдгээр загвар 24 сумаас орон нутгийн идэвх оролцоо, 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт, бодит үр дүн, малын тоо, толгойг бэлчээрийн даацад тохируулах, сүргийн эргэлтийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан байдлаар нь үнэлэхэд Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Архангай, Төв аймгийн 11 сум энэ онд малын үржил, ашиг шимийн гарц, чанар, тэжээлийн нөөц, хангамжийг сайжруулах сууриа тавьж тодорхой ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлсэн.

Архангай, Их тамир сумын Хан-Өндөр, Ишгэнт, Их хужирт БАХ-ийн малчдын суурьт үзлэг ангилалт хийж, цөм сүргийн хонийг ялгаж бүртгэлжүүлсэн тул хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах суурь нөхцөл бүрдсэн. УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн хэрэгцээний эрлийзжүүлэгт ашиглах Эдельбай үүлдрийн 10 толгой хуц нийлүүлэх болсон.

- "Их тамирын итгэл" үржүүлэг технологийн нэгжийн тэжээл үйлдвэрлэлийн төвд түшиглэн хэрэгцээний эрлийзжүүлэг хийсэн эм хонийг нэмэгдэл тэжээлтэй онд оруулах болсон тул хэрэгцээний хургыг эрчимтэй өсгөн бойжуулж, намар бордож зах зээлд борлуулах боломжийг нэвтрүүлэх суурь тавигдсан.

Архангай, Өндөр-Улаан сумын ХААТ-ийн мэргэжилтэн нь зохиомол хээлтүүлэг хийх чадвар, туршлагатай, хувьдаа Эдельбай үүлдрийн хуцтай, төслийн зүгээс зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслээр дэмжсэнээр Эдальбай хуцаар 150 эм хонинд хэрэгцээний эрлийзжүүлэг хийсэн.

Архангай, Чулуут - Бог малын хээлтүүлэгчийг сумын үржлийн нэгжүүдэд төвлөрүүлж, тэжээлийн хангамж нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн. Сумын үржлийн нэгжүүд өсвөр хээлтүүлэгч бэлтгэж, өсгөн бойжуулж байна. 10 БАХ-ийн сүргийн эргэлтийн тооцооллоо боловсруулсан.

Архангай, Цахир - Бог малын хээлтүүлэгчийг сумын ХАА-н тасгийн дэргэд төвлөрүүлсэн тул чанар сайтай малтай шилмэл хээлтүүлэгч тавьсан малчин өрхүүдэд түшиглэн өсвөр хээлтүүлэгч бойжуулж, хээлтүүлэгчийн хангамжийг сайжруулах улмаар малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

Төв, Өндөрширээт - Богийн хээлтүүлэгчийн суурьт ангилалт хийж шилмэл 3 хуцыг сонгосон. - БАХ-ийн малчдад сургалт хийж, шилмэл хуцаар зохиомол хээлтүүлэг хийлгэх ач холбогдлыг таниулснаар малчин өрхүүд зохиомол хээлтүүлгийн гэр пункт, суурь бүрдүүлж маллах зардлыг гаргах болсон.

Өвөрхангай, Бат-Өлзий - Өвөрхангай аймгийн цөм сүргээс зохиомол хээлтүүлэгт ашиглах үржлийн шилмэл хуцаар хангах болсон. - Аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн зохиомол хээлтүүлэг хийх талаар дадлага туршлагатай, сумын мэргэжилтнүүдийг аргагүй, багажаар хангах боломжтой. - Сумын СБАХ-ийн ахлагч нь идэвх санаачилга сайтай байлаа.

Завхан, Баянтэс - Мал аж ахуйн мэргэжилтэн, СБАХ, БАХ-ийн хамтын ажиллагаа сайн - Аймгийн засаг даргын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Малын үржлийн ажил сайжруулах, МАА-ийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажил, төсөв тавигдаж ИНХ-аар батлагдсан.

Завхан, Сантмаргаз, Баянхонгор, Жинст - Мал аж ахуйн мэргэжилтэн, СБАХ-ийн хамтын ажиллагаа сайн - БАХ-ийн гишүүд орон нутгийн нөөцийг ашиглан тэжээлийн хангамж нэмэгдүүлэх ажил хийдэг

Хөвсгөл, Цэцэрлэг - Мал аж ахуйн мэргэжилтэн, СБАХ-ийн хамтын ажиллагаа сайн - Хурганы өсөлтийн эрчим сайн, тэжээлийн нөөц, хангамж бүрдүүлэх ажил сайн хийгддэг - "Маш мах" ХХК-тай өсвөр мал нийлүүлэх гэрээ хийсэн.

Хөвсгөл, Цагаан Уул - Мал аж ахуйн мэргэжилтэн, СБАХ-ийн хамтын ажиллагаа сайн, - БАХ-ийн гишүүд хамтын ажиллагаа сайтай, тэжээлийн хангамжийг сайжруулах ажлыг хамтран хийж хэвшсэн.

- МАА-н мэргэжилтэн, СБАХ, БАХ-ийн ахлагч нар орон нутгийн нөөцийг ашиглан дарш, багсармал холимог тэжээл хийх сургалтад хамрагдсан.

НАМЭМ төсөл ХААИС-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ХААИС-ийн боловсруулсан МАА эрхлэх зохистой загварт үзүүлснээр малын үржүүлэг технологийн нэгж нь тэжээлийн сургалт үйлдвэрлэлийн төв, мал бордох аж ахуйтай байснаар цогц үйл ажиллагаа явуулах боломж нэмэгдэнэ. Бог малын үржүүлэг технологийн загвар нэгжийг "Их тамирын Итгэл" нэртэйгээр Их тамир суманд байгуулан 2 дахь жилдээ ажиллаж байна. "Ихтамирын Итгэл" үржүүлэг технологийн загвар нэгж хоршоог БАХ-ийн ахлагч, мэргэжилтнүүдийн хамтарсан гишүүнчлэлтэй байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн. Өнгөрсөн жилийн хувьд цөм сүргийг төвлөрүүлэх, өвөлжөө, хаваржаа, хадлангийн газартай болох, тэжээл тариалах талбайтай байх зэрэг дэд бүтэц байгуулахад илүү анхаарч байсан бол энэ жилийн хувьд шилмэл хээлтүүлэгчээр орон нутагт үйлчилгээ үзүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, дарш хийх үзүүлэх сургалт зохион байгуулах, хадлангийн талбайг бордох, үр хачирлан тордож сайжруулах ажлыг гүйцэтгэсэн байна.

Сүүлийн 20 жил малын үүлдэр угсааг сайжруулах асуудал орхигдсоноос эцэг малын чанар, тоо хэмжээ хязгаарлагдмал байсантай уялдуулан 2018 онд 25 өсвөр хээлтүүлэгч болон шилмэл хуцаар зохиомол хээлтүүлэг хийснээр 2019 онд 39 өсвөр хээлтүүлэгч бойжуулсан, аймгийн ОНХС-гийн санхүүжилтээр Цагаан-Уул сумаас 100 өсвөр хуц худалдан авч хээлтүүлэгчийн суурьт нийт 164 хээлтүүлэгчийг төвлөрүүллээ. 2019 онд үржлийн шаардлага хангасан 125 шилмэл хээлтүүлэгчээр орон нутгийн малчдад үйлчилгээ үзүүлж, малын чанарыг сайжруулах ажил хийгдэж байна.

Нутгийн малчдын сууриудад үзлэг ангилалт хийж, цөм сүргийн сууриас зохиомол хээлтүүлгээр гарсан төлөөс сонгон тэмдэглэх замаар "Тамир" үүлдрийн хонины цөм сүргийг төвлөрүүллээ.

Малын чанар, ашиг шимийг сайжруулахад тэжээллэг, арчилгааны асуудал 70 гаруй хувийн нөлөө үзүүлдэг гэж судлаачид үздэг тул "Их тамирын Итгэл" үржүүлэг технологийн нэгж нь тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, бэлтгэх, асуудалд онцгой анхаарч ажилладаг. Нөгөө талаас бэлчээрийн даац хэтэрсэн өнөө үед малын чанар, ашиг шимийг сайжруулж, тоо толгойг бууруулж, бэлчээрийн даацад тохируулахад тэжээлийн хангамж чухал ач холбогдолтой.

Эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд өвөл, хаврын улиралд малыг нэмэгдэл тэжээлтэй оруулах шаардлагатай. Судалгааны дүнгээс үзэхэд нэмэгдэл тэжээлтэй байсан эм хониноос нэмэгдэл тэжээлгүй байсан эм хонины хоногийн нэмэгдэл жин 3 дахин бага, сүүний гарц 75-80 хувь, ноосны гарц 200 гр, хурганы амьдын жин 8-11 хувиар доогуур байдаг. Мөн үржүүлэг технологийн нэгжийн бэлтгэсэн дарш болон холимог тэжээлээр тэжээж байсан суурийн өсвөр хээлтүүлэгч амьдын жингээ 4.39 кг нэмэгдүүлж онд орсон бол нэмэгдэл тэжээлгүй өвөлжсөн суурийнх намрын амьдын жингээ 3.69 кг алдаж онд орсон болно.

Бэлчээрийн МАА хөгжүүлэх зохистой загварын 2 дахь үндсэн хэсэг болох тэжээлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь малчдад танилцуулах зорилгоор хадлангийн 1 га талбайг хашиж загвар байдлаар бууцаар бордож хамгаалалтад авснаар ургацын хэмжээ, чанарыг нэмэгдүүллээ. Мөн "Ихтамирын Итгэл" үржүүлэг технологийн нэгжийн хээлтүүлэгчийн суурийн хэрэгцээнд зориулан нэмэлт тэжээл, тухайлбал орон нутагт олдоц ихтэй халгай, царгасаар дарш хийж, хадлан тэжээлийг шаардлагатай хэмжээгээр бэлтгэв.

Тэжээлийн сургалт үйлдвэрлэлийн төв дээр Их тамир сум төдийгүй бусад сумын малчид, холбогдох мэргэжилтнүүдэд "Хадлангийн талбай сайжруулах, хадлан бэлтгэх, царгас, халгайгаар дарш хийх, төрөл бүрийн холимог, багсармал тэжээл бэлтгэх" сэдэвт үзүүлэх сургалтууд зохион байгуулснаар гар тэжээл бэлтгэх, урьд өмнө бэлтгэдэг байсан ч мартагдсан жор технологиудыг сэргээлээ. Мөн түүнчлэн олдоц ихтэй түүхий эд ашиглан бага өртгөөр чанар сайтай тэжээл бэлтгэх нь зах зээлээс авч хэрэглэдэг хивэг гэх мэт

тэжээлтэй харьцуулшгүй чанартай болохыг малчид ихээхэн сонирхож байлаа. Тэжээлийн сургалт үйлдвэрлэлийн энэхүү төв нь цаашдаа МАА-н мэргэжилтнүүдийг давтан сургах, МАА, бэлчээр, тэжээлийн боловсон хүчин бэлтгэх сургалт, дадлагын бааз болох боломжтой юм.

Малчид хариуцлагатай үйлдвэрлэлд нэгдэж байна: НАМЭМ төсөл, МБАНХ, ХАС банк хамтран бэлчээрийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих, малчдыг бэлчээрийн даацаас хэтэрсэн малынхаа тоог төлөвлөгөөний дагуу аажмаар бууруулах, малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мал, мах бэлтгэж, өрхийн орлого нэмэгдүүлэх боломжийг судлах туршилтын төслийг 2019 оны 1 сараас 2020 оны 10 сар хүртэл Ховд аймгийн Чандмань суманд хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу Ховд аймгийн Чандмань суманд хэрэгжүүлэх "Ногоон бэлчээр" төслийн суурь судалгааны тоон мэдээллийг цуглуулах судалгаанд сумын нийт малчин өрхийн 73,4 хувь буюу 481 малчин өрх хамрагдсан. Эдгээрээс "Ногоон бэлчээр" хөнгөлөлттэй зээлийн "Хариуцлагын гэрээ" байгуулан, зээлийн шалгуур үзүүлэлт хангасан 97 малчин өрх сарын 1%-ийн хүүтэй 500 сая төгрөгийн зээл авчээ. Энэхүү төсөлд хамрагдсан бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн малчдын бэлчээрийн төлөв байдал сайжрах, суурь төвшнөөс муудаагүй байх, малын тоо толгой тогтвортой буурсан байх, малчид малын гарал үүсэл, эрүүл мэндийн мэдээллийн технологид суурилсан малчнаас боловсруулах үйлдвэр хүртэлх мөшгөх системийг нэвтрүүлэх, малчин өрхүүдийн малын тоо толгойн бууралтыг бэлчээрийн даацаа тохирсон чанартай, зах зээлийн эрэлт хэрэгцээ, стандартад нийцсэн, үнэлэмж өндөртэй цөөн мал, өндөр чанартай ноолуур нийлүүлэх замаар нөхөх боломж, ижил хэмжээний орлого олох эдийн засгийн загварыг гаргах явдал юм. 2019 оны 5, 10 дугаар сард МБАНХ-ноос дотоод хяналт хийхэд малчид гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагаа сайн биелүүлж байна. Хөнгөлөлттэй зээлийн төсөлд хамрагдсан 97 малчин хариуцлагын гэрээнд тусгагдсаны дагуу БАХ дотроо бэлчээрийн фотомониторингийн улирал төлөөлсөн цэгтэй, 2019 оны фотомониторингийн дүнгээр гэрээт бэлчээрийн төлөв байдал ерөнхийдөө тогтвортой, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу улирлын сэлгээг 100% хийсэн, малчдын 86 хувь нь малынхаа 10-аас доошгүй хувийг зах зээлд нийлүүлж, мал эмнэлгийн тасагт бүртгүүлж гарал үүслийн цахим гэрчилгээтэй мал зах зээлд борлуулсан байна.

2019 оны эцсийн мал тооллогын дүнгээр Чандмань сумын хэмжээнд малын тоо 5 төрөл дээрээ өсөж 15,8 мянгаар нэмэгджээ. Харин зээлд хамрагдсан 97 малчин өрхийн нийт малын тоо 305 толгойгоор нэмэгдсэн нь малчид малын тоогоо өсгөлгүй өнгөрсөн жилийн хэмжээнд барих, бэлчээрийн даацад тохирсон малтай байхад маш их ач холбогдол өгснийг илтгэж байна. Зээлд хамрагдсан малчдын малын өсөлтийг төрлөөр нь авч үзэхэд бэлчээрт халтай адуу, хонь, ямааны тоо өмнөх оноос буурч бэлчээрт ээлтэй тэмээ, сарлаг үхрийн тоо нэмэгдсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад зээлд хамрагдсан малчдын 49,5% буюу нийт 48 малчин өрх малын тоог дунджаар 18 хувиар, хамгийн өндөр нь 66 хувиар бууруулсан. Сумын мал өмнөх жилээс 7.7%-иар нэмэгдсэн бол зээлд хамрагдсан малчдын малын тооны өсөлт 0.6% байна. Энэ нь сумын дунджаас 13 дахин бага байгаа нь эдгээр малчдын хувьд үүрэг хариуцлагаа ухамсарлаж байгааг харуулж байна.

Бэлчээр сайжруулах хөрөнгө оруулалт: Малчдаас бэлчээрт оруулсан хөрөнгө оруулалт энэ онд 2 дахин өссөн байна. БАХ-ийн зохион байгуулалтад орсон сумдын малчид бэлчээр сайжруулахад орон нутгаас санхүүгийн болон бодлогын дэмжлэгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад 6 дахин нэмэгдсэн нь орон нутгийн засаг захиргаанаас малчдын гаргасан санаачилгыг дэмжиж, хамтран ажилладаг, бэлчээр сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж байгааг илтгэж байна. Улс, орон нутгаас оруулах хувь хөрөнгийн хэмжээ өссөн нь говийн бүсийн аймгуудад инженерийн хийцтэй гүний худаг олныг гаргасан нь ихээхэн нөлөөлсөн. Орон нутгаас оруулсан хөрөнгө

оруулалтын ихэнх нь худаг шинээр гаргах болон засварлах, хадлан тэжээл бэлтгэл, хадлангийн талбай хаших зэрэг үйл ажиллагаанд зарцуулсан байна. Тухайлбал, улсын төсвөөс болон малчдаас бэлчээр зохион байгуулахад оруулсан хөрөнгө оруулалтыг аймгаар авч үзвэл Дорноговь аймаг хамгийн их буюу 309 сая төгрөг, малчдаас Говь-Алтай аймаг 102.9 сая төгрөг зарцуулсан байна.

БАХ-ийн бэлчээрийн төлөв байдлын фотомониторинг: НАМЭМ төсөл 2015 оноос эхлэн бэлчээрийн фотомониторингийн улсын сүлжээг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх” хөтөлбөрийг хамтран улсын хэмжээнд 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. 2019 онд НАМЭМ төсөл нь МБАНХ, аймаг, сумдын БАХ, газрын даамлуудтай хамтран БАХ-ийн улирлын бэлчээрийг төлөөлөх 2809 цэгт шинээр бэлчээрийн хяналт үнэлгээний фотомониторингийн судалгаа хийснээр 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумыг хамарсан 4781 бэлчээрийн мониторингийн цэг байгуулан, тогтмол судалгаа явуулж байна.

Фотомониторингийн 2019 оны мэдээлэл дээр тулгуурласан бэлчээрийн төлөв байдлын зураглалаас харахад Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн дийлэнх нутаг, Хэнтийн өмнөд нутгаар бэлчээр дундаас их доройтсон зэрэглэлд байна. Дорноговийн баруун, Өмнөговийн ихэнх нутаг, Баянхонгор, Говь-Алтай, Ховдын өмнөд хэсгийн цөлийн бүсэд хамрагдах бэлчээр харьцангуй соргог буюу бага зэрэг өөрчлөгдсөн байна. Мөн судалгааны дүнгээр 2019-2020 онд улсын хэмжээнд хонин толгойд шилжүүлснээр 77 сая толгой мал өвөлжиж, хаваржих боломжтой байна. 2018 оны жилийн эцсийн малын тоо 110 сая хонин толгой байгаа нь боломжит даацаасаа 33 сая хонин толгойгоор хэтэрсэн байна. 2019 онд Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Дорноговь аймгийн хувьд бэлчээрийн даац хэтрээгүй, бусад аймгийн хувьд бэлчээрийн даац хэтэрсэн байна. Фотомониторингийн мэдээллийн боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бэлчээрийн төлөвлөлт хийх, бэлчээр ашиглалтын үр нөлөөг хянах чухал хэрэгсэл болж байна.

Завхан аймгийн Сантмаргаз сум 2013 оноос эхлэн 5 БАХ-ийн дөрвөн улирлын бэлчээр дэх 14 фотомониторингийн цэгт жил бүр бэлчээрийн төлөв байдлын судалгаа хийж байна. Тус сумын газрын даамал Баярхүү олон жил ажиллаж буй туршлагатай мэргэжилтнүүдийн нэг бөгөөд сумын БМАХ-ийн гишүүдийн хамт жил бүр фотомониторингийн үр дүнг сумын ИТХ, сум, багийн Засаг дарга, малчдад танилцуулан, БАХ бүрээс төлөвлөгөөнд тусгах ажлыг Багийн ИНХ-аар хэлэлцүүлэн сумын ТЖГЗБТ-нд тусгаж хэрэгжүүлдэг. Судалгааны үр дүнд тулгуурлан орон нутгийн удирдлага, СБАХ-ноос малчдад бэлчээрийг хуваарьтай ашиглах, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх талаар зөвлөж, малчид жил бүр улирлын хуваарийн дагуу нүүж, бэлчээр чөлөөлж, амрааж хэвшсэн. 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 5 БАХ-ийн 5 байршилд нийт 2050 га бэлчээрт сэлгээ хийж, мэргэчдийн голомттой, нягтшил ихтэй газарт сумын цаг уурын мэргэжилтэн, БОХ-ын байцаагч, Байгаль хамгаалагч, СБАХ-ны тэргүүн, БАХ-ийн ахлагч нартай хамтран газар дээр нь тооллого, зураглал үйлдэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10400 га талбайд 11 сая төгрөгөөр оготно устгал хийж, ОНХС-ийн 5 сая төгрөгийн санхүүжилтээр Дөрөлжийн улаан, Хавтгай, Ихмаргаз БАХ-ийн хаваржаа, намаржааны бэлчээрийн хуучин гар худгуудийг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг сайжруулсан байна. 2015-2019 оны хооронд бүх БАХ зуслан, намаржааны бэлчээрийн сэлгээ хийснээр ургамлын бүрхэц 25-43%-иар нэмэгдсэн байна. Тухайлбал, сэлгээ хийснээр ургацын гарцыг сүүлийн 3 жилээр харьцуулахад Баяндавс багийн Ихмаргаз БАХ-ийн Тоонон чулууны хавтгай 600 га бэлчээрийн ургацын хэмжээ 180 кг/га, ургамлын бүрхэц 30%-иар, Баяннуур багийн Хавтгай БАХ-ийн Баяннуурын хоолойн ар 600 га сэлгээ хийснээр ургацын хэмжээ 210 кг/га ургамалын бүрхэц 39%-иар нэмэгдсэн байна.

Бэлчээрийн үндэсний гуравдугаар форумыг “Ногоон Хөгжлийн Төлөөх Хариуцлагатай Малчид” уриан дор зохион байгууллаа: Бэлчээрийн харилцаанд оролцогч

бүх талууд хамтран амжилт ололт, асуудал, бэрхшээлээ хэлэлцэж, шийдэл боловсруулдаг гол индэр болсон бэлчээрийн үндэсний форумыг МБАНХ 2017 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. Бэлчээрийн үндэсний III форумыг төслийн үр шимийг хүртэгчид болон гол оролцогч талууд ажлын үр дүн, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох, хамтын ажиллагааны сүлжээ бий болгох зорилгоор зохион байгуулж, форумд ХХААХҮЯ, Ховд аймгийн ИТХ, Ховд аймгийн ЗДТГ, МБАНХ, ШХА-ийн Ногоон-Алт малын эрүүл мэнд төсөл, Ховд аймгийн БАХ-ны төлөөлөл, Ховд аймгийн УЦУОШГ, төсөл хэрэгжиж буй аймаг, сумдын малчдын байгууллагын төлөөлөл, залуу малчид, судлаачид болон бэлчээрийн менежментийн чиглэлээр ажиллаж буй төрийн болон ТББ-ын төлөөллөөс бүрдсэн 500 төлөөлөгч оролцлоо. Форумын үеэр малын эрүүл мэндийн мөшгөх систем, “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах эрх зүйн зохицуулалт” Баянхонгор аймгийн санаачилга, “Ногоон зээл-Хариуцлагатай малчин” ХАС банкны хөнгөлөлттэй зээл, Малчны байгууллагын хөгжил-10 жилд, Баруун бүс нутгийн ургамалжилтын судалгааны дүн гэсэн 5 үндсэн сэдвээр төслийн хүрээнд хийж буй ажлын үр дүн, хэрэгжилт, бэрхшээлийн талаар төлөөлөгчид илтгэл тавьж хэлэлцүүлээ. Мөн “Бэлчээр нутгаа таньж тодорхойлох нь зохистой ашиглалтын үндэс мөн” сэдэвт залуу малчдад зориулсан тэмцээн зохион байгуулж газар газраас ирсэн 30 залуу малчин 5 баг болон экологийн бүс, бүслүүр болон ургамлыг зургаас харж ялган таних уралдаанд идэвхтэй оролцож энэхүү тэмцээнийг анх удаа малчдын дунд зохион байгуулснаараа онцлог боллоо. Түүнчлэн бэлчээр нутаг, байгаль орчин, мал сүрэгтээ ээлтэй хариуцлагатай малчид, малчдын байгууллагын төлөөлөл малчдын эдийн засгийн эрх чөлөөг нэмэгдүүлэх “Мөнгөн сүрэг-мөнгөтэй малчин” хөтөлбөр, Мал аж ахуйн бүтээгдэхүүний төрөл, чанарыг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэх арга зам, “Хариуцлагатай малчин - Хариуцлагатай үйлдвэрлэл”-ийг хөтлөгч техник технологийн шинэчлэлийн нэгэн хэсэг болох “Малын түүхий эдийг эргэн мөшгөх мэдээллийн сан”-гийн талаар сайн туршлагаасаа хуваалцлаа. Форумд оролцогчдоос нэгдсэн зөвлөмж гаргаж, форумын төгсгөлд “10000 мод - Олон ястны угтах хаалга” төслийн багийн санаачилгыг дэмжин Монгол орны Бэлчээрийн үндэсний III форумын нэрэмжит төгөл барихад зориулан хандивын аян өрнүүлж, оролцогчид 800 мянга гаруй төгрөгийн хандив өргөлөө.

5.1.2. Үр дүн 1.2.

БАХ/БАГ эрээний системийг өргөжүүлж нэвтрүүлэх арга хэмжээг шинэ 7 аймагт хэрэгжүүлнэ.

НАМЭМ төсөл МБАНХ-оор дамжуулан төслийн сумдад малчдыг БАХ-ийн зохион байгуулалтад оруулах, бэлчээр ашиглагчдын хэсгүүдийг чадавхжуулах, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон гэрээ байгуулах, экологийн чадавхад суурилсан бэлчээрийн зохистой ашиглалт, хамгаалалт, бэлчээрийн мониторинг, ашиглалтын талаар мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилго бүхий 265 удаагийн сургалт, арга зүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлээ. Сургалтад нийт 27,862 оролцогч хамрагдсанаас 21,344 буюу 77% нь малчид байна. Сургалтад хамрагдсан малчдын 8,630 буюу 40 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бэлчээрийн чиглэлээр сургалтад 1,934 төрийн албан хаагч хамрагдсанаас эмэгтэйчүүд 859 буюу 44 хувь, ИТХ-ын төлөөлөгч нийт 953 хүнээс 387 эмэгтэй буюу 41 хувь эмэгтэйчүүд байна. 2017 онтой харьцуулахад сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 5 хувиар нэмэгдэж 42 хувьд хүрсэн байна.

МБАНХ-оос шинэ 7 аймагт байгуулагдсан БАХ, малчдын байгууллага, БМАХ-ийг чадавхжуулах зорилгоор 9 төрлийн гарын авлага, сургалтын материал бэлтгэж орон нутгийн малчид, БАХ-ийн ахлагч, төрийн байгууллагуудын холбогдох ажилтнуудад хүргэлээ.

1. Бэлчээр ашиглагчдын хэсгийн гарын авлага – Хэрхэн бэлчээр нутгийнхаа эзэн нь болж амьдрах вэ, 1-р комик ном

2. Бэлчээр ашиглалтын гэрээний гарын авлага – Хэрхэн бэлчээр нутгийнхаа эзэн нь болж амьдрах вэ, 2-р комик ном

3. Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцооны гарын авлага

4. Бэлчээр ашиглах алтан дүрэм

5. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын мэдээлэл

6. Малчдын байгууллагын байгальд ээлтэй, тогтвортой түүхий эдийн бэлтгэлийн сайн туршлагыг тодорхойлох судалгааны тайлан

7. Малын гаралтай түүхий эд бэлтгэл, чанар, мөшгөх тогтолцооны тэргүүн туршлагууд

8. Хоршооны засаглалын тэргүүн туршлагууд

9. Бэлчээрийн менежментийн тэргүүн туршлагууд

Бэлчээр ашиглалтын хэсэг 1-р комик

Бэлчээр ашиглалтын гэрээ 2-р комик

Малын гаралтай түүхий эдийн мөшгих тогтолцоо

Бэлчээр ашиглах алтан дүрэм

Монгол орны бэлчээрийн төлөв байдал

Хоршооны сайн туршлагын цуврал гарын авлага

Түүхий эд бэлтгэлийн сайн туршлагын тайлан

Сургалт, техникийн туслалцааны үр дүнд 2019 онд шинээр 1 СБАХ, 64 БАХ байгуулагдлаа. Ингэснээр төсөл хэрэгжиж буй 183 суманд 81.6 мянган малчин өрхийг хамарсан 1509 БАХ зохион байгуулагдаж, БАХ-т тулгуурласан малчдын байгууллага болох 18 АБАХ, 157 СБАХ-г хөгжүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж байна.

Сэлэнгэ аймгийн Орхон сумын “Арвин ундарга” БАХ-ийн малчид хамтран өвөлжөө, хаваржаа болон хадлан бэлтгэдэг Арбулан орчмын намаг, шавартай газрын замыг засах орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын тендерт шалгаран 10-р сард уг ажлыг гүйцэтгэсэн байна. Уг төслийг хэрэгжүүлэх, гүйцэтгэхэд БАХ-ийн ахлагч Буянбат, СБАХ-ны тэргүүн Мандах нар идэвхи, санаачилга гарган, сумын ЗДТГ-аар шийдвэрлүүлж, замын ажилд малчдаа зохион байгуулан 3 өдөр давхардсан тоогоор 41 хүн, 14 машин, техниктэйгээр ажилласан байна. Зам засахад ОНХС-гаас 6,250,000 төгрөгийн санхүүжилт авч, 170 метр намаг, шавартай газрыг чулуу, хайргаар дүүргэн тэгшилж, автомашин явахад саадгүй болгосноор тус БАХ-ийн малчид төдийгүй орон нутгийн иргэдийн цаг хугацаа, эдийн засагт хэмнэлт бий болгосон үр дүнтэй ажил болжээ. Мөн СБАХ, БАХ-ийн ахлагч нарын идэвхи, санаачилга, малчдын хамтын хөдөлмөр, орон нутгийн дэмжлэгт урамшсан БАХ-ийн малчдаас 38 хүн дундын сандаа шинээр 950,000 төгрөгийн хуримтлалыг нэмж төвлөрүүлсэн байна. Малчид зохион байгуулалтад орж, нэг санаагаар хамтран ажиллавал амжилтад хүрч болдогийг тус БАХ-ийн малчид бусдадаа үлгэрлэн харууллаа.

МБАНХ шинэ аймгуудад БАГ байгуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж байна: Энэ онд шинэ 7 аймаг буюу Булган, Дорноговь, Дундговь, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв аймагт БАГ-г малчид, орон нутгийн засаг захиргаанд танилцуулах, гэрээ байгуулах, бүртгэлжүүлэхэд анхаарал тавьж ажилласны үр дүнд шинээр 96 БАХ шинэ маягтаар, хавсралт мэдээлэл нь бүрэн БАГ-г байгуулснаар гэрээний тоо өмнөх оноос 8 дахин нэмэгдэж 109-т хүрлээ. БАГ байгуулсан хувийг бусад аймгуудтай харьцуулахад хуучин долоон аймаг 56-100 хувийн хооронд БАГ байгуулсан бол шинэ аймгууд 55-аас дээш хувьтай байна. Ингэснээр малчид бэлчээр ашиглах уламжлалт эрхээ баталгаажуулах боломж бүрдсэн ба бусад газар ашиглалтын хэлбэрт шилжихээс хамгаалах боломжтой болж байна.

БАГ малчдын эрх ашгийг хамгаалж байна: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын гурван БАХ-ийн 8 бүлгийн малчид бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан байна. Тухайлбал, Бүрэгтий БАХ-т өмнө нь уул уурхай ашиглаж байгаад орхигдсон газарт нөхөн сэргээлт нэрийн дор зөвшөөрөлгүйгээр эрүүл газрыг ухаж, алт олборлож байсан иргэд, аж ахуйн

нэгжүүдэд удаа дараа шаардлага тавьж, БОХУБайцаагч шүүхэд өгч байсан ч хэргийг шүүхээс хэрэгсэхгүй хааж байсан. 2018 онд БАХ-үүд сумын Засаг Даргатай бэлчээр ашиглах гэрээ байгуулж, сумын ИТХ-ын төлөөлөгчдөд хүсэлт гарган олборлолт хийж байгаа газрыг үзүүлж, олборлолт явуулж байгаа иргэдэд бэлчээр газар нутаг чөлөөлөх хугацаатай албан шаардлага өгсөн ч олборлолт хийгдсээр байсан. Иймд тус БАХ-ийн 251 малчин, СБАХ хамтран улс, аймгийн МХГ, БОАЖЯ, Засгийн газрын гомдол санал хүлээн авах 11-11 төв, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх 6 дугаар тасаг зэрэгт гомдол, мэдээлэл гаргаж тэмцсэнээр 2018 оны 08 дугаар сараас энэхүү үйл ажиллагааг бүрэн зогсоож чадсан байна. Мөн Хүйтэн булаг БАХ-ийн 23 га бэлчээрийн газрыг олон Улсын хэмжээний цанын бааз байгуулах нэрээр сумын ИТХ-аар батлуулж, бүтээн байгуулалтын ажил эхлүүлж байсан. Сум орон нутгийн засаг захиргааны байгууллагаас эхлэн аймаг, улсын Олимпын хороо, Цанын холбооны хяналтын зөвлөл зэрэг газруудад асуудал тавьж, уйгагүй ажилласны үр дүнд энэ нь хувийн аж ахуйн нэгж аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байсныг таслан зогсоож, бэлчээрийн газрыг чөлөөлсөн байна.

5.1.3. Үр дүн 1.3.

БАГ-г орон нутгийн болон үндэсний хэмжээнд мэдээллийн санд оруулж бүртгэлжүүлэх, техникийн ур чадвар бий болгоход дэмжлэг үзүүлэх.

Малын тоо хяналтгүйгээр өсөж бэлчээрийн даацаас олон дахин хэтэрснээс бэлчээрийн экосистемийн бүтээмж, үйлчилгээ улам бүр буурч буй өнөөгийн нөхцөлд ашиглалтыг бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад тохируулан малчид, орон нутгийн мэргэжилтнүүдийн оролцоонд суурилан зохион байгуулах, талуудыг хариуцлагажуулах арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ. Бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан ашиглалтыг нэвтрүүлэхэд малчдыг идэвхжүүлэх, хариуцлагажуулах, холбогдох мэргэжилтнүүдийн оролцоог хангах гол арга хэрэгсэл бол сумын засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээ болно. БАГ-г бүртгэлжүүлж малчдын бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулж байна: ГЗБГЗЗГ-ийн дэргэдэх улсын газрын мэдээллийн нэгдсэн сангийн “Лэнд менежер” программ дээр НАМЭМ төслийн дэмжлэгээр нэмэлтээр хөгжүүлсэн “Бэлчээр ашиглалтын гэрээ” болон “Бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх” мэдээллийн сан тус системд бүртгэгдэн хадгалагдаж байна. Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, орон нутаг дахь дэд бүтцийн тогтвортой байдлыг хангах үүднээс гэрээг ГЗБГЗЗГ дахь Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлжүүлж, цахимжсан цогц мэдээлэл үүсгэж малчдын бэлчээр ашиглах уламжлалт эрхийг баталгаажуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Уг системд сум, багийн Засаг даргын захирамж, тогтоол, фотомониторингийн жил жилийн мэдээлэл, тухайн бэлчээрийн одоогийн төлөв байдал, Бэлчээр ашиглагчдын хэсгийн хил зааг, гишүүн малчдын нэр, улирлын бэлчээрийн хил зааг, экологийн чадавхын зураглал зэрэг мэдээллийг бүртгэж байна. 2019 оны байдлаар 19 аймгийн 1415 БАХ-ийн хил заагийг мэдээг электрон байдлаар оруулж, 1004 БАХ-ийн сумын Засаг Даргатай байгуулсан хавсралт мэдээлэл бүрэн БАГ-нээс 455 нь ЛМ мэдээллийн санд бүртгэгдлээ. Энэ онд МБАНХ-ноос бүртгэлтэй гэрээний дутуу мэдээллийг санд нэмж оруулах, БАГ-нд нэмж гарын үсэг зурсан малчдын мэдээллийг оруулахад илүү хүч анхаарал чиглүүлж, аймаг, сумдын газрын даамал болон мэргэжилтнүүдэд сургалт зохион байгууллаа. Ингэснээр бүртгэлтэй гэрээний тоо өмнөх оноос 74-өөр нэмэгдсэн байна. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн гэрээний тоог авч үзвэл хуучин 7 аймгаас нийт 325 гэрээ, дунд дөрвөн аймгаас 79 гэрээ, шинэ 7 аймгаас 51 гэрээ бүртгэгдсэн байна. Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Төв аймгуудад байгуулагдсан БАГ-ний 80-с дээш хувь нь бүртгэгдсэн байна. ЛМ программын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор БАГ-ний бүртгэл, фотомониторингийн мэдээлэл боловсруулалтын хэсэгт веб системд дараахь нэмэлт сайжруулалтыг хийж, эдгээр мэдээллийг веб системд орууллаа. Үүнд:

•БАХ-ийн нутаг дэвсгэрийн зураг, улирлын бэлчээрийн байршил, экологийн чадавхын зургийн хэвлэлийн эх бэлтгэх

•Фотомониторингийн цэгүүдийг сэргэх чадавхаар ангилан харуулах

•Хэрэгцээтэй гарын авлага байршуулах

•Боловсруулсан мэдээг экспортолж excel өргөтгөлөөр харах

• 2018 оны жилийн эцсээр шинэчлэн гаргасан “Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд”-ын 22 ангиллаар:

✓ Экологийн чадавхын зураг

✓ Цэг тус бүрийг сэргэх чадавхаар ангилан тооцоолох томъёо

✓ Байгалийн бүс, бүслүүрийн суурь зураг г.м

МБАНХ-ны greenmongolia.mn сайтын цахим номын сан хэсэгт байршуулсан “Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд” гарын авлагыг байгалийн бүс, бүслүүр тус бүрээр, “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх” заавар, “Сумын бэлчээрийн газрын экологийн чадавхаар ангилан зураглах” заавар, бэлчээрийн фото зургийг аж ахуйн бүлгээр ангилан боловсруулахад хэрэглэх “Sample point” программ зэрэг өдөр тутмын ажилд ихээр хэрэглэгддэг гарын авлагуудыг сумын даамлуудын ажилладаг веб системд оруулснаар мэдэхгүй болон мартсан зүйлээ цаг алдахгүй унших боломжтой болж байна.

БАГ-ний сан бүрдүүлэх, ЛМ программ дээр БАГ-г бүртгэх арга аргачлалд сургалаа: ГЗБГЗЗГ, ХААИС, АБАХ-тай хамтран Сүхбаатар, Ховд, Баян-Өлгий аймгийн барилга хот байгуулалтын газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон сумдын газрын даамал, нийт 50 хүнийг БАГ-ний аймаг, сумын түвшний сан бүрдүүлэх, БАХ-ийн улирлын хил зааг болон БАГ-г ЛМ программд бүртгэх арга зүйн давтан сургалтад хамруулснаар 31 сумын 107 БАХ-ийн хил заагийг засварлан ЛМ мэдээллийн системд оруулж, 128 БАГ-ний бүртгэл үүсгэлээ. 2019 онд ГЗБГЗЗГ-аас аймгуудын фотомониторингийн мэдээлэл боловсруулалтад мониторинг хийж чанарын шаардлага хангахгүй байгаа чиглэлийг аймаг бүрээр гаргаж, Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод, Дархан уул, Хөвсгөл, Төв, Архангай, Дорноговь, Өмнөговь, Завхан зэрэг 12 аймгийн ГХБХБГ-ын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумдын газрын даамлуудад зориулсан давтан сургалт зохион байгууллаа. Сургалтад дээрх аймгуудын мониторинг хариуцсан 13 мэргэжилтэн, 212 газрын даамал бүгд 225 мэргэжилтэн оролцсоноос 141 буюу 63 хувь нь эмэгтэйчүүд байлаа. Тус сургалтаар ялангуяа шинээр ажиллаж байгаа даамлууд бэлчээрийн фото зургийг Sample Point программ дээр боловсруулж, бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгийн түвшинд таних чадварыг эзэмшсэн.

Ногоон Алт төслийн өмнөх шатанд Монгол орны бэлчээрийн үндэсний мониторингийн улсын сүлжээний арга зүйг стандартчилах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, багаж тоног төхөөрөмжөөр хангах, тайлан мэдээ гаргах, олон нийтэд түгээх чиглэлээр хамтран ажиллаж бэлчээрийн төлөв байдлын үндэсний хэмжээний мэдээллийн санг 2011 онд байгуулснаас хойш эдүгээ 8 жилийн мэдээлэл хадгалагдаад байна. Цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн дэх Бэлчээрийн экосистемийн төлөв байдлын үндэсний хэмжээний санг шинэчлэн хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах, мэдээллийн чанар үнэмшлийг дээшлүүлэх, тоон мэдээллийг боловсруулж хэрэглэгчдэд хүргэх, олон улсын хэмжээний мониторингийн сүлжээнд холбох чиглэлээр чадавх бэхжүүлэх зорилгоор мэргэжилтнүүдийг холбогдох урт богино хугацааны сургалтад хамруулж, сангийн программын шинэчлэл өөрчлөлтийн хувьд АНУ-ын ХААЯ-ны Хорнадагийн ЭШ төвийн мэргэжилтэн Эрика Коуртрайт зөвлөн ажиллаж байна. Ус цаг уурын улсын сүлжээн дээрх бэлчээрийн төлөв байдлын мониторингийн хөтөлбөр нь улсын хэмжээнд эдүгээ 1516 цэгийг хамарч бэлчээрийн экосистемийн төлөв байдал, бүтээмж, өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж зэрэг мэдээллээр үйлчлэн ажиллаж байна.

Цаг уурын улсын сүлжээн дээрх мониторингийн дүн мэдээ, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор Монгол орны бэлчээрийн төлөв байдлын цэгэн зураглалыг растер зурагт хувиргаснаар зүүн бүсийн 4 аймаг (Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь), төвийн бүсийн 7 аймгийн (Улаанбаатар хот, Архангай, Булган, Дархан-уул, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймаг) бэлчээрийн 1:1000000 хэмжээст зургийг шинэчлэн зохиолоо. Ийнхүү растер зурагт хувиргаснаар бэлчээрийн төлөв байдлын мониторинг, үнэлгээний системийн төлөөлөх байдал, мэдээлэл боловсруулалтын чанарыг нэмэгдүүлэх боломжтой боллоо.

“Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан” (2018), түүний гол үр дүн болох бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, нэг төлөвөөс нөгөө төлөв рүү шилжиж буй түгээмэл өөрчлөлтийн талаар холбогдох зураглалын хамт БОАЖЯ-наас 2 жил тутамд гаргадаг “Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан”-гийн 2017-2018” оны дугаарт дэлгэрэнгүй өгүүлсэн байна. (http://www.mne.mn/wpcontent/uploads/2019/08/Tuluv-Baidal-Tailan-20172018_2_compressed.pdf).

Бэлчээрийн даацыг улсын хэмжээнд шинжлэх ухааны үндэслэлтэй нэгдсэн нэг аргачлалаар гүйцэтгэх шаардлагад нийцүүлэн бэлчээрийн даац тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, шинэчилсэн аргачлалыг МААЭШХ, ХААИС-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох саналуудыг тусгасны үндсэн дээр 2019 оны 4-р сард ХХААХҮЯ болон БОАЖЯ-ны сайдын зөвлөлийн хурлаар, мөн Монголын үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн хурлаар тус тус дэмжигдсэнээр улсын хэмжээнд мөрдөх нэгдсэн арга зүйтэй боллоо.

Голын эргийн бүсийн экосистемийн бүтэц, үйл ажиллагаа хэвийн түвшнээсээ хэрхэн өөрчлөгдөж буйг тодорхойлох арга аргачлалаас сурах, энэ чиглэлээр ХААИС-ийн багш, залуу судлаачдыг чадавхжуулах зорилгоор АНУ-ын Невадагийн их сургуулийн профессор Свансон Шерманыг урьж байгалийн нөөцийн салбарын мэргэжилтнүүдэд зориулан “Голын эргийн бүсийн экосистемийн үйл ажиллагааны үнэлгээ, менежмент” сэдэвт танхимын болон хэрийн үзүүлэх сургалтыг Архангай аймгийн нутгаар урсах урд болон хойд Тамирын голыг түшиглэн зохион байгууллаа. Сургалтад БОАЖЯ, МУИС, зарим усны сав газрын захиргаа, ШУА-ийн Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн, Бэлчээр ашиглагчдын үндэсний холбоо, ХААИС зэрэг 12 байгууллагын 45 оролцогч хамрагдлаа. Эргийн бүсийн экосистемийн үйл ажиллагааны үнэлгээний дүнгээс үзэхэд Хойд Тамир голын эргийн бүсийн экосистемийн хэвийн үйл ажиллагаа тодорхой түвшинд алдагдсан, зарим хэсэгт бүр эрсдэлтэй түвшинд хүрсэн байна. Голын эрэг орчмын экосистемийн үйл ажиллагааг сонгогдсон БАХ бүрээр тодорхойлж, цаашид шаардлагатай арга хэмжээний зөвлөмжийг малчдад танилцууллаа.

Отрын бүс нутгийн бэлчээрийн төлөв байдлыг хянах, зохистой ашиглалтыг зохион байгуулах чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна: Отрын нөөц бэлчээрийн зохистой менежментийг хөтлөх чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2017 онд Хэрлэнбаян-Улаан, Чилэнгийн отрын бүс нутагт, 2018 онд Говь-Алтай аймгийн Аргалант, Завхан аймгийн Багахайрхан, Говьсүмбэр аймгийн Малах отрын бүс нутагт, 2019 онд Ховд аймгийн Баяннуруу, Увс аймгийн Ачит нуурын отрын бүс нутгийн бэлчээрийн экологийн чадавхыг тодорхойлон зураглах, улмаар ашиглалтын хилтэй холбон бэлчээрийн төлөв байдал, ашиглалтыг хянах мониторингийн цэг байгуулан, тэмдэгжүүлэх, суурь мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлуудыг ХХААХҮЯ-ны АДОБАЗ-тай хамтран амжилттай хэрэгжүүлж байна.

Аймаг дундын отрын бэлчээрийн нэгдсэн мэдээллийн санг вебэд суурилснаар байршлын (координат) болон бусад мэдээллийг өдөр тутам оруулах, мэдээлэл дээр ажиллах боломжийг олгож хялбарчилж өгсөн.

2019 онд “Аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ХХААХҮ-ийн сайдын

тушаалаар Завхан аймгийн Багахайрхан, Булган аймгийн Чилэн, Говьсүмбэр аймгийн Малахын аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд холбогдох аймаг, сумдын засаг дарга, мэргэжилтнүүд болон малчдын саналыг тусгав. Тус төлөвлөгөөний дагуу Завхан аймгийн Багахайрханы аймаг дундын отрын бүс нутагт байгаа иргэдийг төлөвлөлтийн дагуу отрын бүс нутгийг чөлөөлөх талаар орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран ажилласны дүнд отрын бэлчээрийг ургалтын хугацаанд хэсэгчлэн чөлөөллөө.

Аймаг дундын отрын бүс нутгуудын бэлчээр ашиглалтын байдалд хяналт тавих ажлыг сар бүр зохион байгуулж, Увс аймгийн Ачитнуур, Ховд аймгийн Баяннуруу, Завхан аймгийн Багахайрхан, Өвөрхангай аймгийн Хөхдэл, Говьсүмбэр аймгийн Малах, Дорнод аймгийн Чойбалсангийн аймаг дундын отрын бүс нутгууд малын хөлөөс бүрэн чөлөөлөгдсөн байна. Харин Булган аймгийн Чилэнгийн отрын бүс нутагт 6 малчин өрх, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 86 малчин өрх аймаг дундын отрын бүс нутгийг чөлөөлөөгүй байна. Отрын бүс нутгийг чөлөөлөөгүй байгаа 92 малчин өрхөд албан мэдэгдэл хүргүүлж ажилласан байна. Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутгуудад 2018-2019 онд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цэвэрлэх, малын хашаа хороо, хонд бууц, өвөлжөө хаваржаа, худаг, уст цэгийг ариутгах ажлыг отрын бүс нутаг хариуцсан мэргэжилтнүүд батлагдсан удирдамжийн дагуу, аймгуудын Хүнс, хөдөө, аж ахуйн газар, сумдын засаг даргын тамгын газар, харьяа мал эмнэлгийн байгууллага, мал отроор өвөлжүүлсэн малчдыг хамруулан 2019 оны 4-5 дугаар сарын хооронд зохион байгуулж, нийт 14 өвөлжөө, хаваржааны 55 бод бог малын сэг, зэм устган ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт өвөлжиж хаваржих малчин өрхийн мал сүргийг байгалийн гэнэтийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Булган аймгийн Рашаант сумын нутаг Шар толгойн тариалангийн талбайд ногоон тэжээл тариалж 68 тонн ногоон тэжээл хурааж авлаа.

Отрын бүс нутаг дахь тэжээлийн аюулгүйн нөөцийг хадгалах агуулах, саравчны нөөц, чанарыг сайжруулах зорилгоор Чилэнгийн отрын бүсэд агуулах, саравч, хамгаалалтын хашааг шинээр барьж байгууллаа.

“Элсэн тасархай”, “Бадын гол”-ын чиглэлд отор нүүдэлд хяналт тавих 2 пост дээр 9 албан хаагч, 3 авто машин отор нүүдэлд хяналт тавьж, отроор ирж буй өрхүүдийг бүртгэлжүүлэх, мэдээллийн самбараар мал тууврын маршрут, бусад хууль тогтоомжийн мэдээлэл өгч, малын эрүүл мэндийн дэвтэр, түүн дээр бичилт хийгдсэн эсэхийг шалгах, тариалангийн талбайд буусан малчин өрхийг талбайгаас нүүлгэх, отрын ихэнх малчид сумын Засаг даргын тодорхойлолт байхгүй хаана очих нь тодорхойгүй байсан учир бичиг баримтын бүрдлийг хангах талаар заавар өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

5.1.4. Үр дүн 1.4.

БАХ-ийн тогтолцооны бүтэц, хөгжлийг дэмжинэ.

НАМЭМ төсөл нь малчдын байгууллагын засаглал, менежментийн ур чадвар, тогтвортой байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах, чадавх бүрдүүлэх арга хэмжээ авч байна. Байгууллагын чадавхыг бэхжүүлэх, цаашдын тогтвортой байдлыг хангах зорилгоор МБАНХ болон аймаг, сумдын БАХ-ны үйл ажиллагаанд Нидерланд Улсын MDF байгууллагын экспертүүд чадавхын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан. Зөвлөхүүд МБАНХ-ны удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, бодлогын зөвлөл, хамтрагч төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд болон аймгийн бэлчээр ашиглагчдын холбооны гүйцэтгэх захирлуудтай уулзаж, хамтрагч бүх талуудын байгууллагад үзүүлэх үүрэг, байгууллагын цаашдын алсын хараа, үйл ажиллагааны чиглэл болон стратегийн зорилтуудын талаар ярилцаж, үнэлгээ дүгнэлт өгсөн. Байгууллагын чадавхын үнэлгээ

хийсэн зөвлөхүүд МБАНХ-ноос цаашид анхаарч ажиллах шаардлагатай стратегийн 6 чиглэлийг тодорхойлж, зөвлөмж өгсөн нь байгууллагын цаашдын хөгжилд чухал хувь нэмэр үзүүлэхүйц үнэтэй зөвлөгөө болж чадлаа. Үүнд:

- Удирдлага, удирдлагын бүтэц
- Хүний нөөцийн менежмент
- Санхүүгийн тогтвортой байдал
- Гишүүнчлэл, үйлчилгээ
- Зах зээл, маркетинг
- Бодлого, хууль эрх зүйн орчин

МБАНХ мэргэжлийн сургалтын байгууллагаар бүртгүүллээ: МБАНХ нь 2019 онд ХНХЯ-ны А/192 шийдвэрийн дагуу “Ойжуулагч, малчин” сургалтын төрлөөр сургалт явуулах шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагаар бүртгүүлсэн бөгөөд энэхүү бүртгэлийн дагуу цаашид бэлчээрийн тогтвортой менежмент, бэлчээрийн мониторинг, үнэлгээний чиглэлээр сургалт явуулах боломжтой болсон нь байгууллагын чадавхын үнэлгээгээр өгсөн зөвлөмжид тусгагдсан нэг чухал чиглэл юм.

БАХ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тогтвортой байдлыг хангахын тулд орон нутгийн малчдын байгууллага болох СБАХ, хоршоодоос малчдад үйлчилгээ үзүүлэх, малчдын эрх ашгийг хамгаалах чадавхыг бэхжүүлж байна. 2019 оны байдлаар МБАНХ нь 157 СБАХ, 74 ХАА-н хоршоо 33 ХЗХ-той хамтран ажиллаж эдгээр байгууллагын үйл ажиллагаанд малчдыг оролцуулахын тулд дараахь бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна.

БАХ-ийн ахлагч нь төрийн бус байгууллагыг хөгжүүлэх, малчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх чухал үүрэгтэй тул 2018 оноос МБАНХ-ноос БАХ-ийн ахлагчдыг дэмжих, урамшуулах талаар хэд хэдэн арга хэмжээ авч ажиллаж байна. Тус бодлого, чиглэлийн дагуу 13 аймгийн 68 сумын 64 СБАХ-ны тэргүүн, 45 БАХ-ийн ахлагч нарт нийт 19,2 сая төгрөгийн урамшууллыг журмын дагуу олгож идэвхжүүлсэн байна.

АБАХ, СБАХ-ыг тоног төхөөрөмжөөр хангаж, ажиллах нөхцөл боломжийг сайжруулж байна: 2019 онд шинээр байгуулагдсан СБАХ-г чадавхжуулах үүднээс 7 аймгийн 35 СБАХ-г компьютер тоног төхөөрөмжөөр хангаснаар ажиллах нөхцөл боломжийг нь сайжрууллаа. Архангай аймгийн Ихтамир суманд зохион байгуулагдсан Сарлаг фестивалийн үеэр НАМЭМ төсөл хэрэгжиж буй шинэ 7 аймгийн 35 сумын СБАХ-ны тэргүүн болон БАХ-ийн ахлагчдын төлөөллүүд хоршооны болон бэлчээрийн менежментийн сургалтад хамруулж сургалт, мэдээлэл өглөө. Энэ үеэр Ихтамир сумын СБАХ-ны тэргүүн Нэргүйбаатар болон БАХ-ийн ахлагчид СБАХ-ны байрандаа оролцогчдыг хүлээн авч үйл ажиллагаагаа танилцуулан, туршлага хуваалцсан нь шинэ СБАХ-ны тэргүүнүүдэд чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Малын үүлдэр угсааг сайжруулах цөм сүргийн аж ахуйг АБАХ, СБАХ эрхэлж байна: НАМЭМ төсөлд 2016 оноос хамрагдсан Дорнод аймгийн АБАХ, Цагаан-Овоо сумын “Айраг” БАХ-ийн 10 малчин өрхийн 3200 гаруй хонинд ангилалт хийж 55 кг-аас дээш жинтэй 500 толгой эм хонь шилэн сонгож эх сүргээс тусгаарлан, 65 кг-аас доошгүй амьдын жинтэй 10 хуц сонгож сүрэглэн хээлтүүлэг хийснээр 2018, 2019 онд 538 хурга бойжуулсан. Нийт бойжсон эр хурганд үзлэг шилэлт хийж жин, өсөлт, хөгжилт, зүс, галбираар үржлийн шаардлага хангасан 88 хуцаар цөм сүрэг бүрдүүлэх боломж бүрдэж малчдын хонины чанарыг сайжруулах үүднээс түрээсээр ашиглуулж байна. Хуцан хурганы 7 сартай үеийн сүргийн дундаж амьдын жин 38 кг байгаа нь ижил насны эр хурганыхаас даруй 6 кг буюу 18,8 хувиар илүү байна. Энэ ажлын үр дүнд төсөл хэрэгжиж буй сумдын малчдын хонин сүргийг Дорнодын уужим тал нутгийн бэлчээрийн мал маллагааны нөхцөлд дасан зохицсон “Барга” үүлдрийн хониор сайжруулах, ингэснээр хонины дундаж амьдын жинг 1.2-1.5 кг буюу 3-4 хувиар ахиулах, тухайн үүлдрийн хонины хээлтүүлэгчийн цөм сүргийг орон нутагт бий болгож, үржлийн ажилд ашиглах юм.

МБАНХ олон улсын 4 байгууллагын гэрээт ажлыг үндэсний хэмжээнд гэрээгээр гүйцэтгэж байна: 2019 оноос Хас банктай хамтран “Ногоон бэлчээр” төслийг Ховд аймагт хэрэгжүүлж байна. Мөн Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Японы Сүмитомо зэрэг байгууллагуудын хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл дээр хамтарч ажиллах, техник арга зүйн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.

НҮБ-ын ХХААБ-ын “Нүүдэлч малчдын мэдээллийн сан” бүрдүүлэх хоёр шатны мэдээлэл цуглуулах төслийг 18 аймгийн АБАХ, СБАХ болон хамтран ажилладаг төрийн байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Хоёр шатны судалгаагаар нийт 114,757 малчин өрхөөс малчин өрхийн нийгэм эдийн засаг, мал аж ахуй, газар ашиглалт, бэлчээр тэжээл, усан хангамжийн чиглэлээр судалгаа авч, төслийг 2019 онд амжилттай хэрэгжүүлж дууссан. Тус төслийг Монгол, Аргентин, Чад орнуудад хэрэгжүүлсэн бөгөөд удирдан зохион байгуулсан НҮБ ХХААБ-ын Нүүдэлчдийн Мэдлэгийн Сангаас 2019 оны 11 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд Ром улсын Итали хотод хамтрагч байгууллагуудын нэгдсэн уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үеэр төслийн үр дүнг хамтрагч байгууллагуудад танилцуулахаас гадна мэдлэгийн сангийн хамтрагч байгууллагууд нүүдэлч, малчдын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сайн туршлагаасаа хуваалцлаа. Хамтрагч байгууллагын уулзалтад оролцогчид нүүдэлч малчид, бэлчээрийн мониторинг үнэлгээний чиглэлээр улс, бүс нутаг, олон улсын төвшинд мэдээлэл, судалгаа дутмаг, цаашид хамтарч энэ чиглэлээр Малчдын Мэдээллийн сангийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай талаар онцолж, НҮБ ХХААБ-ын нэг салбар нэгж болгож, цаашид үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг улам идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харилцан тохирлоо. МБАНХ олон улсын газрын эвслээс 2020 онд зохион байгуулах Азийн газрын хурлыг зохион байгуулах ажилд оролцох, 2019 оны 12 сард зарлагдах Кадастрын төслийн сонгон шалгаруулалтад оролцохоор хамтрагч байгууллагуудтай санал солилцлоо.

Тэсийн Голын Монголчууд кино олон улсын кино фестивалд шалгарлаа: МБАНХ, Тэгт Тойрог Кино компанитай хамтран бүтээсэн “Тэсийн Голын Монголчууд” кино дэлхийн улс орнуудын мал маллагаа, мал аж ахуй эрхлэх амьдралын хэв маягийг олон нийтэд таниулах зорилготой Perspectives on pastoralism буюу Мал аж ахуйн чиг хандлага нэртэй олон улсын кино фестивалд шалгарчээ. Тус кино фестивалд дэлхийн олон орны чадварлаг уран бүтээлчдийн баримтат болон түүхэн төрлийн олон кино өрсөлдсөнөөс Тэсийн Голын Монголчууд киноны зураг авалтыг маш өндөр түвшинд хийсэн хэмээн шүүгчид онцолсон байна. Тус кинонд Тэсийн гол нь Булнайн нуруунаас эх авч Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, ЦагаанУул, Завхан аймгийн Баянтэс, Тэс, Увс аймгийн Баруунтуруун, Тэс сумд, Монгол, Оросын нутгийг дамжин урсаар Увс нуурт цутгадаг. Нэг голын уснаас ундаалж байгаа нутгийн уугуул малчдын амьжиргаа, аж амьдралын хэв маяг, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж ирсэн уламжлалт ёс заншил, бэлчээрээ нүүдэл сэлгээтэй даац багтаамжид тохируулан мал аж ахуйгаа адгуулан ирсэн уламжлалыг Тэсийн голын эхэн, дунд, адагт амьдран буй гурван айлаар жишиж харьцуулан үзүүлсэн.

“Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” сэдвээр үндэсний хэлэлцүүлэг хамтран зохион байгууллаа: УИХ, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, НАМЭМ төсөл, МБАНХ хамтран “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт УИХ-ын дарга, гишүүд, Засгийн газрын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох яам, агентлагийн албан тушаалтнуудаас гадна 21 аймгийн ИТХ-ын дарга, ХХААГ-ын дарга, нар болон малчид, тариаланчдын төлөөлөл нийт 850 гаруй хүн оролцов. “Монгол Улсын бэлчээр нутгийн өнөөгийн төлөв байдал”, “Бэлчээрийг ашиглах, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх арга замууд, үр дүн сургамж”, “Малчдын бүлгийн зохион байгуулалтад үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлсэн туршлага”, “Малын тоог

бэлчээрийн даацад нийцүүлэх асуудлууд”, “Малчдын санаачлагаар бэлчээр ашигласны хураамжаар суманд эрсдэлийн сан бүрдүүлж, зарцуулсан туршлага сургамж” зэрэг сэдвээр илтгэл, танилцуулга хийж, хөдөө орон нутгаас ирсэн 800 гаруй малчид төлөөлөгчдөөр хэлэлцүүлсэн. Төлөөлөгчдийн зүгээс бэлчээрийн тухай хуулийн төслийг нэн даруй батлах шаардлагатайг онцлохын зэрэгцээ малын тоо толгойг цөөрүүлэх, улсын сайн, аварга малчин шалгаруулахдаа тоо бус чанарт анхаарсан журам боловсруулах, малчдын өвөлжөө, хаваржаа болон сэлгээний газрыг эзэмшүүлж, хадлан бусад газрыг нийтийн эзэмшилд үлдээх, отрын бүсийн зохицуулалтыг оновчтой тодорхой болгох, бэлчээрийн тухай хуульд говь, хангай, хээрийн бүсийг харгалзсан зохицуулалт, уул уурхайн лицензийг олгохдоо бэлчээр сүйтгэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхаарах шаардлагатай гэсэн саналыг олон малчин гаргалаа.

Малчид, малчдын байгууллагууд жижиг төсөл хэрэгжүүлж үр шимийг нь хүртэж байна: НАМЭМ төсөл, МБАНХолбооноос төсөл хэрэгжиж буй аймаг сумын малчдын байгууллага, хоршоодыг чадавхжуулах, бэлчээр, малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах, МАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчин, бэлчээрт ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор жижиг төслийн уралдаан зарлаж, 18 аймгийн АБАХ, СБАХ, БАХ-ийн шаардлага хангасан 135 жижиг төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Үүнээс, эргэн төлөгдөх нөхцөлтэй 28 төсөлд 56,250,000 төгрөг, эргэн төлөгдөхгүй, хөрөнгө оруулалтын нөхцөлөөр 107 төсөлд 104,600,000 төгрөг, нийт 154,850,000 төгрөгний дэмжлэг олголоо. Эдгээр жижиг төслийн 20% нь АБАХ, 32% нь СБАХ, 48% нь БАХ-ийн хэрэгжүүлж буй төслүүд байна. Хөрөнгө оруулалтыг төрлөөр нь авч үзвэл малын тэжээл бэлтгэл, бэлчээр, малын үүлдэр угсаа, чанар сайжруулах чиглэлд нийт төсвийн 80 орчим хувь нь зарцуулагджээ.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын СБАХ 4.2 сая төгрөгийн зээл, 0.6 сая төгрөгийн өөрийн санхүүжилтээр “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” жижиг төсөл хэрэгжүүлсэн. Өвлийг өнөтэй давж, хавар төлөө бүрэн бойжуулахад нь малчдад дэмжлэг үзүүлж, хямд үнэтэй өвс тэжээл, хужир шүү бэлтгэн нийлүүлэх зорилгоор СБАХ өвс, тэжээл, давс, хужир бэлтгэн малчдад борлуулж, 6 сарын хугацаатай авсан зээлээ хугацаандаа эргэн төлсөн. Төслийн үр шим хүртэгч Арвидах БАХ-ийн малчин Батсайхан: “Өмнөх өвөл маш хүнд болсон тул өнгөрсөн өвлийн бэлтгэлийг малчид нэлээн сайн хийж, өвлийг өнөтэй давлаа. Манай өрхийн хувьд хадлангийн газрын гарц муу, хүн бүл муутай байсан учраас сумын СБАХ-аас 300 боодол өвс боломжийн үнээр авч төлөө онд бүрэн оруулсан. Малчдад тустай ажил хийсэнд баяртай байна”.

Цагаантохой БАХ-ийн малчин Ганчулуун: “Манайх СБАХ-аас 200 боодол өвс, 10 шуудай хивэг 1 сард зээлээр худалдаж аваад хавар ноолуур борлуулсны дараа өгсөн. Малчид бид байнга бэлэн мөнгөтэй байдаггүй, тэр тусмаа өвлийн цагт эргэлтгүй байдаг, тэр үед үнэхээр хэрэг болсон. Сайн, чанартай ногоон өвс байсан болохоор хавар мал, төлд их хэрэг боллоо”

БАХ-ийн тогтолцооны удирдлагын багт эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж байна: МБАНХ-ноос эмэгтэйчүүдийг БАХ, СБАХ, АБАХ-ны удирдах албанд томилогдон ажиллах, тэдний манлайллын ур чадварыг сайжруулах, гишүүн эмэгтэйчүүдэд шинэ ур чадвар эзэмшихэд нь туслах ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр БАХ, СБАХ, АБАХ, хоршооны удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо өнгөрсөн онд 376 байсан бол 61-ээр нэмэгдэж 437 болжээ. БАХ-ийн ахлагчаар нийт 214 эмэгтэй, СБАХ-ны тэргүүнээр 44 эмэгтэй, АБАХ-ны гүйцэтгэх захирлаар 7 эмэгтэй ажиллаж байна. 2019 онд 1768 (18 АБАХ, 157 СБАХ, 1488 БАХ, 105 хоршоо) малчдын байгууллага ажиллаж байгаа бөгөөд эдгээрт нийт 437 эмэгтэй буюу 25% нь удирдах түвшний ажил хийж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2.5 хувиар өссөн байна.

МБАНХ-ноос эмэгтэйчүүдэд өрхийн орлого нэмэгдүүлэх жижиг төсөл хэрэгжүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж байна: Малчин эмэгтэйчүүдэд бэлчээрийн

менежментийг дэмжих, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор МБАНХ-ноос "Гар урлалаар хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд борлуулан өрхийн орлого нэмэгдүүлэх" жижиг төслийн уралдаан зарлаж, төслийн хүрээнд санаачлагатай тууштай ажиллаж байгаа эмэгтэйчүүдээ зах зээлд холбоход нь дэмжлэг үзүүлсэн. 2018 онд суран, ноосон болон давуун эдлэл үйлдвэрлэлийн 13 төсөлд 41 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй хүүгүй хөрөнгө оруулалтын зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.

2018 онд санхүүжүүлсэн 13 төслийн эргэн төлөлт 70 хувьтай байгаа бөгөөд 2019 онд багтаан төлөгдөх төлөвлөгөөтэй байна. Санхүүжилт олгосон төслүүд 2018-2019 онд эргэн төлөгдөж, аймгийн бэлчээр ашиглагчдын холбоонд жижиг төслийн сан байдлаар 15,150,000 төгрөг хуримтлагдсан байна. Хэдийгээр богино хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авсан ч ихэнх төслүүд үр дүнтэй хэрэгжиж эмэгтэйчүүд өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжтэй болж, үйл ажиллагаа нь жигдэрч байна.

Жижиг төслийн зээл авсан малчин эмэгтэйчүүдийн төлөөлөл болох Завхан аймгийн Аргалант БАХ-ийн малчин эмэгтэйчүүд малчдын эсгий гутлын эрэлт хэрэгцээг хангах замаар малын гаралтай түүхий эдийг эргэлтэнд оруулж, орлого нэмэгдүүлэх зорилгоор 10,7 сая төгрөгийн өртөг бүхий төсөл хэрэгжүүлсний 5 сая төгрөгийг төслөөс санхүүжүүлсэн. Тэд ноос сэмлэх төхөөрөмж, гутлын хэв болон гишүүн малчдаас ахар ноос худалдан авч эсгий оймс, хүүхдийн эсгий гутал үйлдвэрлэж, ажиллах хүчээ сургаж, 4 өрх орлогын шинэ эх үүсвэртэй болжээ. Өөрийн орон нутагт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн тул үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ их, борлуулалт сайн байна.

Сумын нийт иргэдийн 60-70 хувь давуун уут ашигладаг болжээ. Дорнод аймгийн Баян-Уул сумын иргэн Н.Батжаргал "давуун уут" үйлдвэрлэх төслийн хүрээнд дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлттэй энэ үед байгальд сөрөг нөлөөтэй нийлэг хальсан уутыг халж давуун уут хэрэглэх зорилго тавьсан бөгөөд төслийн санхүүжилтээр шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, бизнесээ эхлүүлэн одоогоор сумын иргэдийн 60-70 хувь давуун уут ашиглаж эхэлсэн байна. Одоогоор 5 төрлийн нимгэн зөөлөн, дахин ашиглах боломжтой уут үйлдвэрлэн гаргах хүчин чадалтайгаар ажиллаж байна. Сумын хэмжээнд Засаг даргын захирамжаар гялгар уутны хэрэглээг халж давуун уут хэрэглэх шийдвэрийн дагуу жижиг төсөлд хамрагдсанаар ажлын байр бий болгож, давуун уутны захиалга авч, эдийн засгийн байдал тодорхой хэмжээгээр нэмэгдсэн. Мөн төслийн хүрээнд нэг малчин эмэгтэйг оёдолд сургаж, нэг эмэгтэйг ажлын байраар бүрэн хангасан байна.

Эмэгтэйчүүдийг үзэсгэлэн, худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлж байна: Жил бүрийн 1-р сард Улаанбаатар хотод зохион байгуулагддаг цагаан идээний үзэсгэлэн худалдаанд Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улаан, Тариат, Их тамир сумдын малчид оролцдог ба үзэсгэлэн худалдаанд оролцоход нь эко цаасан уут хийлгүүлж малчдад өгөх, замын зардал, лангуу, майхан, асар зэрэг шаардлагатай зүйлүүд дээр сумын бэлчээр ашиглагчдын холбоо болон анхан шатны хоршоод дэмжин ажиллаж байна. Жил бүрийн Цагаан сарын өмнө зохион байгуулагддаг уг арга хэмжээнд нэг сумаас 80-100 малчин өрх оролцдог ба нэг өрх дунджаар 5-8 сая төгрөгийн борлуулалт хийж өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.

Эмэгтэйчүүд бэлчээр, МАА-н менежментийг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна: Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах, малын тоог бэлчээрийн даацад тохируулах, сүргийн эргэлтийн схем боловсруулж хэрэгжүүлэх, мал сүргийг онд мэнд оруулах, өвөл хаврыг өнөтэй давахад тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлэх, эмэгтэй малчдыг дэмжих хүрээнд төслийн зүгээс Архангай, Говь-Алтай аймгийн 7 сумын малчдын 11 төсөлд 6,1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Энэ ажлын хүрээнд Говь-алтай аймгийн АБАХ-аас Эрдэнэ, Дарив сумын эмэгтэй малчдад жижиг төсөл хэрэгжүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлснээр эдгээр 2 сумын 14 өрхийн эмэгтэй малчид нэгдэж 1,8 тонн

гар тэжээл, сорс зоодой бэлтгэж нөөцөллөө. Энэ нь өвөл цаг хүндэрсэн үед ядарч доройтсон малыг нэмэгдэл байдлаар тэжээхэд хамгийн үр дүнтэй хүчит тэжээл болдог.

Тэжээлийн чанар, хангамжийг нэмэгдүүлэх, орон нутагт олноор ихтэй түүхий эдийг түүж чанар сайтай, хямд өртөгтэй тэжээл бэлтгэн ашиглах зорилгоор Архангай аймгийн Ихтамир сумын Иххужирт БАХ-ийн ахлагч Оюунцэцэг, Хөх нуур БАХ-ийн ахлагч Алтантуяа, Чулуут сумын Цогтсүмбэр БАХ-ийн малчин Цэдэвдорж нар ХААИС-ийн багш нарын сургалтаар заасан арга, технологийн дагуу нийт 305 кг дарш, 590 кг холимог багсармал тэжээлийг тус тус бэлтгэсэн байна.

5.1.5. Дүгнэлт, сургамж, санал:

- Сүргийн эргэлтийн тооцооллын дагуу малын тоог бэлчээрийн даацад тохируулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, зах зээлд борлуулах малын судалгааг он оноор гаргаж байгаа нь салбарын хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, бэлчээрийн ачааллыг бууруулахдаа бүс нутгийн байгаль экологийн өвөрмөц онцлог, орон нутгийн бодлого, малын үүлдэрлэг байдлыг харгалзах, малчдын орлогыг бууруулахгүйгээр мал сүргийн тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

- Сүргийн эргэлтийн тооцоолол хийх веб суурьтай (bams.digitalmedic.mn) программ шинээр нэвтрүүлснээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлтийг улсын хэмжээнд нэг арга зүй, норматив үзүүлэлт, стандартыг ашиглан хийх, цаг хугацаа хэмнэх, мал аж ахуйн төлөвлөлтийн мэдээллийн сан бүрдэх, дахин засвар хийх, шинэчлэх, тайланг хэвлэж авах зэрэг боломжийг олгож буй давуу талтай байна.

- Сүргийн эргэлтийн тооцоолол, төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх тухай шат дараалсан сургалтыг аймаг, сум бүрд зохион байгуулснаар загвар 24 сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн, мал зүйчид сүргийн эргэлтийн төлөвлөгөөг сум, БАХ-ын түвшинд төдийгүй малчин өрхийн түвшинд, малчдын сонирхол, хэрэгцээнд нийцүүлэн гаргах, зөвлөх, хамтран ажиллах чадавх нэмэгдэж байна.

- Шинээр хөгжүүлж байгаа программаа ашиглан сүргийн эргэлтийн төлөвлөлтийг хийхэд орон нутгийн удирдлагын оролцоо, дэмжлэг, тоног төхөөрөмжийн (компьютер, принтер, интернетийн хурд гэх мэт) хүрэлцээ, хангамж, хүчин чадал муу, зарим суманд мэргэжлийн боловсон хүчин дутмаг зэрэг бэрхшээл байна.

- Бэлчээрийн даац олон дахин хэтрэлттэй, чанар бүтээмж улам бүр доройтож байгааг малчид харж ойлгож, улмаар эр сувай, нас гүйцсэн малаа зах зээлийн эргэлтэд оруулж бүтээмж сайтай мал сүрэгтэй болох хандлага өсөж буй өнөө үед орон нутаг дахь мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тэдний зүгээс малчдад өгөх технологийн зөвлөмж, орон нутгийн удирдлагын бодлогын дэмжлэг үгүйлэгдэж байна.

- Малчид мал борлуулах хүсэлтэй, төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа боловч махны экспорт хязгаарлагдсантай холбоотой махны үнэ буурсан, зарим суманд малын амьдын жин муу байгаа зэрэг нь мал борлуулалтад нөлөөлж байна. Энд төрийн зөв бодлого, дэмжлэг шаардлагатай байна.

- Бэлчээрийн төлөв байдлыг тогтвортой хадгалах, сайжруулахад хуваарьтай ашиглах, шаардлагатай нөхцөлд урт хугацаагаар өнжөөж амрахын чухлыг малчид ойлгосноор улирлын сэлгээг зохих журмын дагуу хэрэгжүүлж байна. Харин зуслан намаржааны бэлчээрийн ачаалал өндөр, богино хугацааны сэлгээг нэвтрүүлэх боломж хомс байгаа тул малын тоо, ачааллыг даацад тохируулахад чиглэсэн, зохистой ашиглалтын зөвлөмж үгүйлэгдсээр байна.

- МБАНХ-ноос 2019 онд онцгой анхаарал тавьж аймаг, сумдын газрын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласны үр дүнд БАГ байгуулсан БАХ-ийн 45% нь “Лэнд менежер” программд БАГ-гээ бүртгэлжүүлсэн байна.

- “Лэнд менежер” программд оруулсан мониторингийн мэдээлэл дээр үндэслэн холбогдох цэгүүд өнгөөр ангилагдах, мониторингийн мэдээллийг жил бүр шинэчлэх, онуудаар харьцуулалт хийхийн зэрэгцээ тайлан материалыг хэвлэх цэстэй болсон нь сумын газрын даамлын хувьд БАГ-ий хавсралт бэлтгэх цаг хугацаа, хөдөлмөр ихээхэн хэмнэгдэж байна.

- БАГ-г ЛМ мэдээллийн системд бүртгүүлэх ажил БАХ улирлын бэлчээрийн хил заагийг системд оруулахаас эхэлдэг. Хил заагийг оруулахад ЛМ-д байгаа сумын хилээс зөрөх хилүүд хоорондоо завсар гарах зэрэг алдаанаас хамаарч системд орохгүй цаг алдаж байна.

- Төслийн гэрээт байгууллагууд санхүүгийн аудит хийлгэхээр аудитын олон улсын эрхтэй “БДО аудит”, “Грант торнтон аудит” компаниас сонгож 5 дугаар сард гэрээ байгуулан 7 дугаар сард аудитын компани дүгнэлт тайлангаа ирүүлсэн.

5.2. ҮР НӨЛӨӨ 2.

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНД МАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР САЙЖИРЧ, ЗАХ ЗЭЭЛД ХАМТРАН НИЙЛҮҮЛСНЭЭР МАЛЧИН ӨРХИЙН ОРЛОГО НЭМЭГДЭНЭ.

5.2.1. Үр дүн 2.1.

Малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрийн хоорондын харилцаа холбоо тогтворжсон байна.

Хоршоод, үндэсний үйлдвэрүүд түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн гэрээ байгууллаа: 2019 онд үндэсний боловсруулах үйлдвэр, хоршоодын хооронд түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт хийх, гэрээ хэлцлийн уулзалт, сургалтыг МБАНХ, Ногоон Алт дундын хоршоо болон бусад олон улсын байгууллагууд хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд НАМЭМ төслийн хамтран ажилладаг 10 аймгийн загвар 28 сумын хоршоо, СБАХ-ны төлөөлөл болон МННХ, Арьс ширний Холбоо, Үндэсний арьс, шир, ноос ноолуур, махны 12 үйлдвэрийн төлөөлөл нийт 70 хүн оролцсон. Уулзалтаар хоршоод, СБАХ-ын төлөөлөл үндэсний үйлдвэрүүдэд 2019 онд бэлтгэн нийлүүлэх түүхий эдийн нөөцөө танилцуулж, бэлтгэн нийлүүлэх хэлцэл хийж, үйлдвэрүүд түүхий эдэд тавигдах чанар, стандартыг хоршоодод танилцуулж түүхий эд нийлүүлэлтийн гэрээ хэлцэл хийсэн. Уулзалтын үр дүнд хоршоод 65 тн сарлагийн хөөвөр, 8 тн торомны ноос бэлтгэн нийлүүлэх хэлцэл байгуулсан байна.

Хоршоодын борлуулалтын орлого: Үндэсний боловсруулах үйлдвэрүүдтэй хийсэн гэрээ хэлцлийн дагуу хуучин 7 аймаг, төвийн 3 аймгийн анхан, дундын хоршоод 2019 онд нийт 66.5 тн сарлагийн хөөвөр, 32.2 тн тэмээний ноос, 999.1 тн хонины ноос, 28 тн ямааны ноолуур, 140,528 толгой мал, 10 тн сүү, 13365 арьс шир, бусад цагаан идээг зах зээлд нийлүүлж 17.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа.

Өнгөрсөн онтой харьцуулахад хоршоодын борлуулалтын орлого 7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь малчид малаа их борлуулсантай холбоотой байна. 2017 оны суурь түвшний борлуулалттай харьцуулахад 2019 онд борлуулалт 12.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт бэлтгэн нийлүүлсэн сарлагийн хөөврийн 30 хувийг Архангай аймаг, тэмээний ноосны 70 хувийг Баянхонгор аймаг, хонины ноосны 35 хувийг Завхан аймаг, ямааны ноолуурын 24 хувийг Архангай аймаг, бог малын 38 хувийг Ховд аймаг, бод малын 63 хувийг Архангай аймаг бэлтгэн нийлүүлсэн байна.

Малчдын Ногоон алт дундын хоршоо нь 2017 онд байгуулагдсанаас хойш орон нутгийн малчдын хоршоодыг үндэсний болон олон улсын түүхий эд худалдан авагч, боловсруулагч нартай холбож, шинэ зах зээлтэй болох, зах зээлээ өргөжүүлэхэд нь холбогч гүүр болон ажиллаж байна. 2019 онд дотоодын зах зээлд түүхий эд бэлтгэн нийлүүлэх зуучлалын гэрээний тоо нэмэгдэж, 4 төрлийн түүхий эд, мал, мах нийлүүлэх 6 гэрээг үндэсний 4 боловсруулах үйлдвэр, гадны 2 худалдан авагчтай байгуулж гэрээгээр хүлээсэн үүргээ 21 хувиар давуулан биелүүллээ. Тухайлбал, 0.8 тонн сарлагийн цэвэр хөөвөр, 0.1

тонн тэмээний утас болон 0,1 тонн сартуул хонины утас бэлтгэн Англи, Непал улсын гэрээлэгч талд нийлүүллээ. Харин дотоодын зах зээлд дундын хоршоогоор дамжуулан 50000 толгой малыг Мах маркет ХХК-д, 500 тонн хонины ноос Эрдэнэт хивс ХХК-д, 41 тонн сарлагийн хөөврийг Баялаг-Өлзий, Сор компанид бэлтгэн нийлүүлсэн байна.

Анхан шатны хоршоод түүхий эдийг тус тусдаа бага үнэ ханшаар бэлтгэн нийлүүлдэг байсан бол анхан шатны хоршоодоо төлөөлсөн нэгдсэн гэрээг дундын хоршоо байгуулснаар үйлдвэрт нийлүүлэх түүхий эдийн хэмжээ нэмэгдэж, үйлдвэрүүд бөөнөөр, илүү өндөр үнээр худалдан авах сонирхлоо илэрхийлсэн. Ийнхүү анхан шатны хоршоодыг төлөөлж дундын хоршоо гэрээ байгуулах нь түүхий эдийн үнэ нэмэгдэж, малчид, хоршоодод очих үнийн зөрүү, ашиг нэмэгддэгээрээ онцлогтой. Тухайлбал, Мах маркет ХК-тай Иран улс руу импортлох 50,000 толгой бог малын бэлтгэлийг сумдын хоршоодоор дамжуулан бэлтгэх зуучлалын гэрээ байгуулж гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн. Мөн Эрдэнэт хивс ХК-тай хийсэн гэрээгээр малчдад падаан олгох журмыг оруулж өгснөөр килограмм тутамд 1000 төгрөгийн урамшуулал малчдад олгохоор болсон. Дундын хоршооноос гадны зах зээлд худалдан борлуулах түүхий эдийн гэрээ байгуулж түүхий эдийн чанарыг гадаад зах зээлд таниулах, эрэлт нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж байна. Цаашид гадаад зах зээлд ноолуур, ноос, тэмээний ноос борлуулахад анхан шатны хоршоодыг холбож өгөх зорилготой ажиллаж байна. Харин сарлагийн хөөврийн гарц бусад түүхий эдээс хязгаарлагдмал тул нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлоход нь дэмжлэг үзүүлж үндэсний үйлдвэрт илүүтэй нийлүүлэх бодлого баримталж байна.

Дундын хоршоо үйл ажиллагаа явуулснаар дараах үр дүнд хүрч байна. Үүнд:

- ❖ Дундын хоршооны зүгээс сарлаг, тором самнах, түүхий эдийн ангилан ялгалт хийх сургалтыг малчдад зориулан зохион байгуулж, зориулалтын сам, шуудайгаар хангаж байгаа нь түүхий эдийн гарц, хэмжээ нэмэгдэх, чанар сайжрах, малчдыг идэвхжүүлэх хөшүүрэг болж байна. Ингэснээр анхан шатны хоршоодоос нийлүүлэх сарлагийн хөөврийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна.

- ❖ Түүхий эдийг гадаад зах зээлд нийлүүлж эхэлснээр түүхий эдийн эрэлт, хэрэгцээ, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

- ❖ Түүхий эдийн мөшгөх тогтолцооны системийг хөгжүүлэх, бүртгэлжүүлэх, үйлдвэрүүдтэй холбох, таниулах ажлыг эрчимжүүлж, сургалт, арга зүйн зөвлөмжөөр хангаж байгаагийн үр дүнд анхан шатны хоршоодын түүхий эдийн нийлүүлэлт, чанарыг бүртгэлжүүлэх ажил нэг алхмаар сайжирч байна. Үүнийг цаашид илүү боловсронгуй болгох, сургалт арга зүйгээр хангах, хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

- ❖ Анхан шатны 22 хоршоонд түүхий эдийн агуулах барих, засварлах ажилд санхүүжилт олгож дэмжлэг үзүүлснээр түүхий эдийн чанар сайжирч, ангилан ялгалт хийдэг болж, үйлдвэрээс тавьж буй стандартад илүү ойртсон түүхий эд бэлтгэдэг болсон.

- ❖ Анхан шатны хоршоо байгуулах, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулж хоршоог хууль, дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлж байна. Мөн шинээр хоршоо үүсгэн байгуулах сонирхол нэмэгдэж байгаа. Шинээр байгуулагдаж буй хоршоо нь зөв зарчмаар үйл ажиллагаа эхлүүлэх, эзэн төвтэй биш гишүүн төвтэй хоршоо байгуулагдаж ХАА-н загвар хоршоо болох эхлэл тавигдаж байна. Дундын хоршооны зүгээс шинээр байгуулагдаж буй хоршоодыг загвар хоршоо болгох чиглэл дээр байнга анхаарал хандуулж сургалт, зөвлөгөөг дэс дараатай өгөхөөр ажиллаж байна.

Гарал үүсэл тодорхой махны борлуулалт нэмэгдэж байна: Малын эрүүл мэндийн мөшгөх тогтолцооны системийг сайжруулах, хэрэглээнд оруулах, хэрэглэгчдэд сурталчлан таниулах, гарал үүсэл тодорхой, чанартай мах хэрэглэгчдэд нийлүүлэх, байнгын хэрэглэгчтэй болох зорилгоор Ногоон Алт дундын хоршоо 2019 онд Лавай төв болон Наадам худалдааны төвд хоршооны борлуулалтын лангуу түрээсэлж, гарал үүсэл тодорхой

малын мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулж байна. Эдгээр төвд борлуулалтын 2 ажилтанг тогтмол ажлын байраар хангаж, чанартай мах борлуулж байгаа нь хэрэглэгчдийн шаардлагад нийцэж байнгын худалдан авагч 3 байгууллагатай болж, худалдан авалтын тоо хэмжээ өмнөх оныхоос 80 хувиар нэмэгджээ. Наадам, Лавай төвөөр 5 аймгийн 7 сумын гарал үүсэл тодорхой эмийн үлдэгдэлгүй үхрийн мах 3.7 тн, хонины мах 17.2 тн, нийт 20.9 тн мах бэлтгэснээс Наадам төвөөр 8.6 тн мах, Лавай төвөөр 7.7 тн мах, бусад эх үүсвэрээр 3.3 тн мах борлуулж, 183.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Борлуулалтын дараах ашиг болох 61.1 сая төгрөгийг ложистик, шатахуун, лангууны түрээс, тохижилт болон борлуулалтын ажилтнуудын цалин хөлсийг олгоход зарцуулсан байна.

5.2.2. Үр дүн 2.2.

БАХ-ийн хоршооны чадавх бэхэжсэн байна.

Сургалтад хамрагдсан хоршооны гишүүдийн тоо: Хоршоо байгуулах, хөгжүүлэх, сарлаг, тором самнах, үйлдвэрээс тавьж буй чанарын шаардлага, стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх, ХЗХ байгуулах сургалтад 4142 хүн хамрагдаж мэдлэг, ур чадвараа сайжруулсан бөгөөд нийт оролцогчдын 1498 буюу 37% нь эмэгтэйчүүд байлаа. Хоршооны сургалтад хамрагдсан нийт оролцогчдын 70 хувь буюу 3,692 оролцогч ХЗХ, дундын сан байгуулах сургалтад хамрагдсан бол 30 хувь буюу 1,598 хүн маркетингийн хоршоо буюу түүхий эд бэлтгэлийн сургалтад хамрагдсан байна.

Сарлагийн хөөвөр, торомны ноос самнах сургалтыг Увс, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн 12 сумын 2200 малчинд явуулсан. Үүнээс 750 орчим малчинд практик сургалт буюу малчны хотонд очиж сарлагийн хөөвөр, торомны ноос самнах сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад Баялаг-Өлзий компанийн анхан шатны ангилан ялгалтын инженер оролцож түүхий эдийг малчдын байгууллагаар дамжуулан үндэсний үйлдвэрт хаягдалгүй, шууд нийлүүлж ашгаа нэмэгдүүлэх боломжтой талаар мэдээлэл өгсөн. Сургалтын үеэр сарлаг, тором самнах гарын авлага 2000 ширхэг, 650 сам, 120 ширхэг стандартын шуудай, мөн Бөхмөрөн, Толбо суманд сарлаг самнах хашааг малчдад хүлээлгэн өгсөн нь сургалтын үр дүнг нэмэгдүүлэхэд хөшүүрэг болсон. Сургалтын үр дүнд тус сумдаас бэлтгэн нийлүүлсэн түүхий эдийн хэмжээ өмнөх оноос нэмэгдэж 1620 кг хөөвөр, 1598 кг тором, тэмээний ноосыг Ногоон алт дундын хоршоонд бэлтгэн ирүүлж, үндэсний болон гадаадын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн.

Сургалтын үр дүнд малчдад 93,2 сая төгрөгийн орлого, хоршоод 5,6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хоршоо байгуулах, хоршооны засаглал, менежмент, эрх зүйн орчин, санхүү, маркетинг болон хоршоодоос бэлтгэх түүхий эдийн чанарыг сайжруулах, тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн сургалтыг шинэ буюу Хэнтий аймгийн Норовлин, Дорнод аймгийн Цагаан овоо, Сүхбаатар аймгийн Халзан суманд Ногоон алт дундын хоршооноос зохион байгууллаа. “Хөдөөгийн хөгжлийн загвар хоршоог буй болгох” сэдэвт тус сургалтад улсын тэргүүний Буян-Ундрал хоршоог үүсгэн байгуулагч, МУ-ын Гавъяат эдийн засагч Б.Авирмэд сургагчаар ажиллаж, 435 хүн хамрагдсан. Сургалтын үр дүнд тус 3 суманд “Хөдөөгийн загвар хоршоо” буюу зуугаас дээш гишүүнтэй, 500 саяас доошгүй хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хоршоог Сүхбаатар аймгийн Халзан сум үүсгэн байгуулах, бусад 2 сумын хувьд өмнө үүсгэн байгуулагдсан зөв зарчмаар явж буй хоршоог загвар хоршооны дүрэм журамд нийцүүлэн хөгжүүлэх, идэвхжүүлэхээр шийдвэрлэсэн.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын СБАХ-ны дэргэдэх “Дархад малын хишиг ундрах” хоршоо 2018 онд байгуулагдсан. Хоршооны дарга Отгонбаатар алслагдсан суманд малчдын байгууллага байгуулж, хөгжүүлэх амаргүй ажилд цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулан идэвх зүтгэлтэй ажиллаж байна. Зөвхөн энэ онд гэхэд 4-5 сард Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга, эмч нартай хамтран 5 багийн 305 малчин өрхөөр явж малчдын хаврын бэлтгэл байдалтай танилцаж, 3 БАХ-ийн хурлыг зохион байгуулан санал хүсэлтийг

сонсож, бэлчээрийн маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж, бэлчээр, МАА-н менежмент, сарлагийн хөөвөр бэлтгэх, сарлаг самнах сургалт, мэдээлэл өгч, бэлчээр ашиглах гэрээ байгуулах тохиролцоонд хүрчээ. Үүний үр дүнд 2019 онд 1 тн ноолуур, 3 тн сарлагийн хөөвөр үндэсний үйлдвэрт нийлүүлж, өмнөх жилээс бэлтгэн нийлүүлэлт нь 2 дахин нэмэгдэж, зөвхөн сарлагийн хөөврөөс 50 гаруй сая төгрөг малчдад орлого болон үлдсэн.

Хөвсгөл аймгийн АБАХ, Жинст мөрөн ХХК хамтран хөх сарлагийн судалгааг сүүлийн 3 жил дараалан хийж байна. Энэ ажлын хүрээнд хоршооны дарга Отгонбаатар Тоом багт хийсэн судалгааны багийг ахлан ажиллаж 102 өрхийн 3087 хөх сарлагийг ээмэглэж бүртгэлжүүлэв. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 20 дугаар тогтоолоор “Сарьдагийн хөх сарлаг дэд хөтөлбөр”-ийг зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж дэд хөтөлбөрийг батлуулсан байна. АБАХ, Улаан-уул СБАХ, хоршоо хамтран Мунгараг БАХ-ийн малчдын дунд ОНХС-д санал өгөх нэг хэлбэр болох “Бүлгийн ярилцлага”-ыг анх удаа зохион байгуулснаар уг хурлаас “Хөх сарлагийн дэд хөтөлбөр” нэгдүгээрт эрэмбэлэгдсэн. Ийнхүү иргэд тулгамдсан асуудлаа хоорондоо хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлж Багийн ИНХ-аас дахин дэмжигдвэл ОНХС-аас санхүүжилт авах боломжтой гэдгийг малчдад харууллаа.

Баян-Өлгий аймгийн АБАХ-ны дэргэд байгуулагдсан “Малчны түшиг” дундын хоршоо нь малчдыг өргөн хэрэглээний бараагаар хангаж, малчдын, малчдын байгууллагын орлого нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Тус хоршоонд Алтай, Сагсай, Өлгий сумын СБАХ-ны дэргэдэх тус бүр 1 хоршоо, Улаанхус, Цэнгэл, Бугат сумдын ХАА-н анхан шатны болон Хадгаламж, зээлийн тус бүр 2, нийт 9 хоршоо тус бүр 500,000 төгрөгийн ХНХ нийлүүлж гишүүнээр элсэн хамтран ажиллаж байна. Хоршоо АБАХ, СБАХ-ны дэргэдэх ХЗХ-д дээр байгуулагдсан бэлчээрийн эрсдлээс хамгаалах сан болон гишүүдийн нийгмийн хамгааллын сангийн хөрөнгийг түшиглэн 10-р сараас эхлэн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлж, цаг хүндэрсэн үед СБАХ-ны дэргэдэх хоршоодоор дамжуулан борлуулалт хийж ашиг, үнийн зөрүүг гишүүн хоршоодод олгох ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд Алтай, Цэнгэл сумын болон АБАХ-ны дэргэдэх ХЗХ-ны бэлчээр хамгаалах сангийн хөрөнгөөр 100 тн хорголжин тэжээлийг өөрийн агуулахад нөөцлөөд байна. Бусад сумдын ХЗХ-ны сангийн хөрөнгөөр өвсний нөөц бүрдүүлэх зах зээлийн судалгаа, бэлтгэл ажил хийж байна. АБАХ-ны дэлгүүрийн байранд малчдад зориулсан 10 орчим төрлийн электрон барааны лизингийн үйлчилгээ үзүүлж, Алтай, Буянт, Цэнгэл, Сагсай сумдад борлуулж, 550,400,000 төгрөгийн борлуулалттай ажиллаж байгаа нь малчдын хэрэгцээнд нийцсэн ажил болж байна. Гурван тулгуурт малчдын байгууллага болох ТББ, ХАА-н болон ХЗХ үйл ажиллагаагаа уялдуулан үр дүнтэй хамтран ажиллаж байгаа загварыг тус хоршоо харуулж байна.

Шинээр байгуулагдсан хоршоодод зориулсан амжилтын түүх, сургалтын видео бэлтгэж түгээлээ. НАМЭМ төсөлтэй амжилттай хамтран ажиллаж буй ХАА-н хоршоод болох “Малчдын Ногоон алт” дундын хоршоо, Архангай аймгийн “Баялаг хангайн сор” дундын хоршоо, Их тамир сумын “Тамир таван эрдэнэ”, Чулуут сумын “Буга зүрх”, Тариат сумын “Хоргын мишээл”, Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын “Халзан хангайн хишиг”, Говь-Алтай аймгийн Халиун сумын “Эвт залаа”, Тайшир сумын “Газрын өгөөж хуримт”, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Алтан Алдар” зэрэг 9 хоршооны амжилт, туршлагыг олон нийтэд болон шинээр байгуулагдсан хоршоодод танилцуулах, түгээх зорилгоор “Хоршооны амжилтад юу нөлөөлдөг вэ?” сэдвийн хүрээнд 10 цуврал видео болон Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Алтан Алдар” хоршооны амжилтын видео бэлтгэн НАМЭМ төслийн Youtube аккаунт, аймгуудын ФБ групп, “Малчин” ТВ-ээр нэвтрүүлж, малчдын сургалтын үеэр үзүүлж танилцуулж байна.

Сэдэв Холбоос:

1 Малчид яагаад хоршоонд элсдэг вэ? https://youtu.be/M_TUY9RM5no

2 Хоршооны гишүүдийн оролцоо https://youtu.be/CbWK0waB_Uo

- 3 Хоршооны гишүүдийн итгэлцэл <https://youtu.be/IVKeeZ14pVw>
- 4 Хоршоо үйл ажиллагаагаа өргөжүүлэх нь <https://youtu.be/7SC6flvxCyA>
- 5 Хоршооны засаглал, гишүүдийн ардчилсан удирдлага, хяналт
<https://youtu.be/cCK0ujwT5e0>
- 6 Үнийн зөрүү ба ноогдол ашиг хуваарилалт <https://youtu.be/uXmo7UnCLUI>
- 7 Хоршооны нийгмийн үйлчилгээ https://youtu.be/GD_P8cVxB5A
- 8 Хоршооны хамтын ажиллагаа <https://www.youtube.com/watch?v=LuQcj2SAmP4&feature=youtu.be>
- 9 Хоршооны сургалт, мэдээлэл <https://youtu.be/roqOiTGwNIo>
- 10 Малчдын байгууллагын хамтын ажиллагаа <https://youtu.be/EiSEnfbESFk>
- 11 Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Алтан-Алдар” хоршооны “Итгэлээс төрсөн алдар” амжилтын түүх
<https://www.youtube.com/watch?v=f1EgZfocxL4&fbclid=IwAR1DNLfiUI7nNY59Df4HMj6EKyVXK9fLevilmXmTAIj mHCv-uxrWayUFk1Y>

Хоршооны эмэгтэй удирдлага: 2019 онд БАХ-ийн малчдад суурилсан ХАА, маркетингийн 4, хадгаламж зээлийн 7 хоршоо шинээр нэмэгдэж нийт 105 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хоршоо нь нийтдээ 16,000 хүний гишүүнчлэлтэй бөгөөд хоршооны удирдлагын багт 209 эмэгтэй ажиллаж байгаагаас 20 нь хоршооны дарга, 189 нь тэргүүлэгчээр ажиллаж байна. 2018 онтой харьцуулахад энэ тоо 37%-иар өссөн байна.

Дундын сан, ХЗХ-ноос үйлчилгээ авч буй малчдын тоо нэмэгдэж байна: НАМЭМ төслийн хүрээнд 2004-2016 онд нийт 11 аймгийн 125 суманд малчдын дундын сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн. 2017 оноос төслийн 4-р үе шатанд нийт 18 аймгийн 157 суманд өргөжиж, 2019 оны 11 сарын 20-ны байдлаар 998 БАХ-ийн 254 дундын сангийн тусгай тохиргоотой данс дээр 29'593 малчин өрхийн 3.7 тэрбум төгрөгийн хуримтлал бүрдсэн байна. Өнгөрсөн хугацаанд нийт системийн хэмжээнд 783,3 сая төгрөгийн орлого олж, 507,2 сая төгрөгийн зардал гарсан байна. Зардлын дийлэнх хувь хадгаламжийн хүүд олгогдож, малчдад бодит үр ашгаа өгчээ. 2019 онд нийт 106,6 сая төгрөгийн орлого олж, 18,9 сая төгрөгийн зардал гарсан байна. 2019 оны 11 сарын 20-ны байдлаар дундын санд нийт 466,8 сая төгрөгийн хуримтлагдсан ашиг бий болсон байна. Дундын сангийн зээлийн зориулалтыг авч үзвэл нийт зээлийн 20 хувийг хадлан тэжээл бэлтгэхэд зориулан авсан байна. Малын үүлдэр угсаа сайжруулах, малын эрүүл мэнд, хадлан тэжээл бэлтгэл зэрэг МАА-н үйлдвэрлэлийн бизнестээ нийт зээлийн 43.5%-ийг зарцуулсан байна.

Дундын сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 399,4 сая төгрөг буюу 11.9%-иар өссөн дүнтэй байна. Дундын санд суурилсан малчдын ХЗХ-ны тоо нэмэгдэж байна: Дундын сан байгуулах, дундын санд суурилсан малчдын ХЗХ үүсгэн байгуулж хөгжүүлэх чиглэлээр 3692 хүнийг хамруулсан сургалт техникийн туслалцааны үр дүнд 2019 онд Баянхонгор аймагт 2, Завхан аймагт 5, Ховд, Увс аймагт тус бүр 1 нийт 9 ХЗХ шинээр байгуулагдсанаар ХЗХ-ны тоо 33-д хүрлээ. Эдгээрээс 23 ХЗХ нь “Хадгаламж зээлийн” үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч гишүүддээ хадгаламж зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн 6 хоршооны тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо хянаж байгаа бөгөөд 4 ХЗХ тусгай зөвшөөрлийн материалаа бэлтгэж байна.

Байгуулагдсан ХЗХ-ны статистикаас дүгнэж үзвэл нийт гишүүдийн тоо 7,069, актив нь 5,838.9 сая төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 640.0 сая, нэг гишүүний ХНХ-ийн доод хэмжээ дунджаар 101.3 мянган төгрөг болсон байна. Тухайлбал, Ховд аймгийн Дөргөн суманд үйл ажиллагаа явуулдаг банкны зээлийн хэмжээ 2017 оноос 2018 онд 519.4 сая төгрөгөөр буурсан байна.

ХЗХ-дыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлж байна: Өнгөрсөн онд байгуулагдсан 10 ХЗХ-г зөөврийн компьютер, хэвлэх төхөөрөмж, ХЗХ-ны санхүүгийн программаар хангаж, ХЗХ-нд ашигладаг санхүүгийн "Спинел-6.0" программын сургалтад Баянхонгор, Говь-

Алтай, Увс, Ховд аймгийн 6 сумын ХЗХ болон Ногоон-Алт финанс ХЗХ-ны нягтлан бодогч нар оролцож ур мэдлэг, ур чадвараа сайжрууллаа. БАХ-ийн дундын сан нийт 254 ширхэг тусгай тохируулгатай данстай болж өмнөх оноос 9,6%-иар нэмэгдсэн. Төсөл хэрэгжиж буй 18 аймгийн СБАХ бүхий 157 сумын 998 БАХ-ийн 29593 өрх дундын сан бүрдүүлсэн байна. 2019 онд дундын санд шинээр элссэн БАХ-ийн гишүүдийн тоо өмнөх оноос 10,6%-иар өслөө.

Дундын сангийн хуримтлал өмнөх оныхоос 10.7%-иар өссөн бөгөөд малчдаас оруулсан хөрөнгийн хэмжээ 5,9% буюу 103 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Дундын сангийн нийт хүүгийн ашиг 466,8 сая төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оноос 29,5 хувиар өссөн байна. Шинэ 7 аймгийн 35 сумын 135 БАХ-ийн 4626 гишүүд 250,6 сая төгрөгийн дундын сан бүрдүүлжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулбал 62,2 хувиар өссөн байна.

Дундын санд суурилан байгуулагдсан ХЗХ-дын нэг болох Ховд аймгийн Дөргөн сумын “Мөнхийн буян өгөөж” хадгаламж зээлийн хоршоо 2017 оны 10 сард 29 гишүүнтэй 5.8 сая төгрөгийн хөрөнгөтэй байгуулагдсанаас хойш 2019 оны 11 сарын байдлаар 200 гаруй гишүүнтэй 400 орчим сая төгрөгийн актив хөрөнгөтэй үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Нийт гишүүдийн 80% нь малчид бөгөөд гишүүдийнхээ итгэлийг хүлээн хариуцлагатай хамтран ажиллаж орон нутагт 3 ажлын байр шинээр бий болгож, 2018 онд 15 сая төгрөгийн ашигтай ажиллан, орон нутагт 3 сая төгрөгийн татвар төлж, гишүүддээ 12 сая төгрөгийн ноогдол ашиг хуваарилсан байна. 2019 онд 102 сая төгрөгийн хүүгийн орлого олж, 49.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 5 орчим сая төгрөгийг зөвхөн ААНОАТ-т төлсөн байна. 2019 онд багадаа 25 сая төгрөгийн ноогдол ашиг хуваарилах төлөвлөгөөтэй байна.

5.2.3. Үр дүн 2.3.

Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний чанар сайжирсан байна.

Түүхий эд нийлүүлэлтийн эргэн мөшгөх системийг хөгжүүлж байна: Дэлхийн зах зээл дэх хэрэглэгчид байгальд ээлтэй, гарал үүсэл тодорхой бүтээгдэхүүнийг илүү сонирхох болжээ. Хэрэглэгчдийн сонирхолд нийцүүлэн боловсруулах үйлдвэрүүд болон худалдан авагчид байгаль орчинд ээлтэй, баталгаатай, эргэн мөшгөх боломжтой түүхий эд бэлтгэлийн систем нэвтрүүлсэн малчид, хоршоодоос түүхий эд, материалаа авах хандлага нэмэгдэж байна. Монгол малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр хүнд, үнэлэмжийг өсгөхийн тулд МБАНХ нь 2017 оноос эхлэн УЦУОШГ, ГЗБГЗЗГ, МЭЕГ, ХААШУОНТ, МННХ, МАШҮХ зэрэг төрийн болон салбарын ТББ-уудтай хамтран мэдээлэл технологид суурилсан “Хариуцлагатай нүүдэлчид” мөшгөх системийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна. Хариуцлагатай нүүдэлчид систем хөгжүүлэх ажлын хүрээнд МЭЕГ-аас хөгжүүлж буй мал эмнэлэг, сүлжээ лабораторийн систем, мал эмнэлгийн гэрчилгээний систем, малын бүртгэлийн систем, ГЗБГЗЗГ-ын газрын кадастрын мэдээллийн систем, газрын мониторингийн систем зэрэг улсын хэмжээний мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгууллаа. Энэхүү систем нь малын гаралтай түүхий эдийг нийлүүлж буй малчдын бэлчээрийн төлөв байдал, малын тавлаг байдал болон эрүүл мэнд, малын гаралтай түүхий эдийн чанар, хүрээлэн байгаа байгаль орчинд ээлтэй байдал зэрэг үзүүлэлтийг цогцоор нь багтааснаар хэрэглэгч худалдан авч буй бүтээгдэхүүний түүхий эдийн гарал үүсэл, чанарын мэдээллийг авах боломжтой болно. Нөгөө талаар сайн чанарын малын гаралтай түүхий эд (сарлагийн хөөвөр, торомны ноос, ноолуур, арьс, шир, мах, сүү) нийлүүлснээр эдийн засгийн урамшуулал хүртдэг “Хариуцлагатай малчин” болон малчдын байгууллагыг баталгаажуулах юм.

МБАНХ-ноос уг системд малчдын байгууллагын (АБАХ, СБАХ, түүхий эдийн анхан шатны болон дундын хоршоо) бүртгэл мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулж байна. Уг системд одоогоор 18 АБАХ, 30 СБАХ, 4 дундын хоршоо 40 гаран түүхий эдийн анхан шатны хоршоод, мах, ноос ноолуур, сүүний чиглэлийн 10 үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн ажилчид, албан тушаалтнууд хэрэглэгчийн эрхээрээ нэвтэрч системээр дамжуулан түүхий эд бүтээгдэхүүний худалдан авалт борлуулалтыг хийж байна. БАХ болон хоршоод нь

нийлүүлж буй түүхий эдийнхээ гарал үүсэл, хэмжээ, чанарын талаарх мэдээллийг энэхүү системд оруулснаар түүхий эд худалдан авагчдад чанарын баталгаа олгох, гарал үүслийн эргэн мөшгөх тогтолцоог нэвтрүүлэх суурь болно.

Энэ онд төслийн 29 сумын хэмжээнд малчдын нийлүүлсэн малын гаралтай 10 төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний 2.7 тэрбум төгрөгийн худалдан авалтыг системд бүртгэсэн байна. Нийт худалдан авалтын үнийн дүнгийн 50 хувийг амьд малын борлуулалт эзэлж байна.

Сүүний мөшгөх тогтолцооны систем амжилттай хэрэгжиж байна: Түүхий эдийн эргэн мөшгөх тогтолцооны нэг хэсэг болох сүүний мөшгөх тогтолцооны туршилтын төслийг ХХААХҮЯ-ны ХААҮШУОНТ-тэй хамтран Борнуур сумын Витафит компанид сүү нийлүүлдэг малчид/фермерүүдэд түшиглэн хэрэгжүүлж байна. 2019 онд ХААҮШУОНТ, МЭЕГ, Витафит компани, МБАНХ, Дижитал медик компани сүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах төслийг хамтран зохион байгуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хүрээнд МБАНХ-ны дэргэдэх "Хариуцлагатай нүүдэлчид" түүхий эд нийлүүлэлтийн эргэн мөшгөх системд "Сүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах

СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МӨШГӨХ ТОГТОЛЦОО



Сүү худалдан авах процесс

Сүүний үйлдвэрийн ажилтан малчин/фермер эрхүүдээс сүү худалдан авахдаа "Хариуцлагатай нүүдэлчид" мэдээллийн системийн сүүний үйлдвэрийн модуль хэсэгт бүртгэн оруулах ба энэ үеэр өрхийн мал эмнэлгийн үйлчилгээг аянах боломжтой. Мөн тухайн өрхийн сүүт үйлдвэрийн стандартын дагуу шинжилгээний үзүүлэлтээр шалган сүүг худалдан авна.



Сүү үйлдвэрлэлийн процесс

Сүүний үйлдвэрт ирсэн сүүг системээр хүлээн авч үйлдвэрийн агуулаагыг үүсгэх ба агуулаахын сүүнд лабораторийн шинжилгээ хийнэ. Лабораторид шинжлэгдсэн сүүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.



Эцсийн бүтээгдэхүүний савлагаа

Үйлдвэрээс гарсан эцсийн бүтээгдэхүүний саван дээр QR код болон бүтээгдэхүүнийг боловсруулсан үйлдвэр, үйлдвэрлэсэн он, сар, өдөр гэх мэт мэдээлэл байна.



Гарал үүсэл шалгах

QR кодыг уншуулахад гарал үүсэл шалгах линк гарч ирэх ба тухайн линкээр орж бүтээгдэхүүний гарал үүслийг шалгана.

Тухайн бүтээгдэхүүний түүхий эд болох сүүний гарал үүсэл, эрүүл ахуй, сүү нийлүүлсэн хариуцлагатай малчид/фермерийн мэдээлэл, тухайн малчдын ашиглан буй балчээрийн төлөв байдлын мэдээлэл зэрэг олон мэдээллийг холбогдох эх үүсвэрээс авах боломжтой.



мөшгөх тогтолцооны модулийг” Дижитал медик, МБАНХ, Витафит компани хамтран боловсруулж жил орчим хугацаанд туршиж, цахим системийг хөгжүүлж бэлэн боллоо. Ингэснээр сүү боловсруулах үйлдвэрүүд тухайн модулийг ашиглан малчдаас авч буй сүүний чанар, эрүүл ахуйн холбоотой мэдээлэл, сүү нийлүүлэгч малчид/фермер, тэдний ашиглаж буй бэлчээр, малын эрүүл мэнд гэх мэт олон мэдээллийг бүртгэж, хэрэглэгчдэд гарал үүсэл нь тодорхой, хариуцлагатай малчдын нийлүүлсэн бүтээгдэхүүнээр үйлчилж буйгаа батлах, мөшгөх боломжтой болж байна. 2019 оны 3-11 дүгээр сард Витафит компани тус системийг ашиглан Төв аймгийн Борнуур, Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Мандал,

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын 300 гаруй малчид/фермерээс 304 тн сүү худалдан авалтыг бүртгэлжүүлж, малчид 244 сая гаруй төгрөгийн орлого орсон байна. Цахим системийн үр дүн болох гарал үүсэл тодорхой, эрүүл малын гаралтай бүтээгдэхүүний савлагаан дээр тавигдах QR кодыг шинээр байршуулахаар Витафит компанитай хамтран ажиллаж байна. Хамтран ажиллах гэрээний хүрээнд Төв аймгийн ХХААГ “Сүүнд антибиотикийн үлдэгдэл шалгах аргачлал” сэдэвт сургалтыг онол, дадлага хосолсон хэлбэрээр Сүү үйлдвэрлэлийн процесс Сүүний үйлдвэрт ирсэн сүүг системээр хүлээн авч үйлдвэрийн агуулахыг үүсгэх ба агуулахын сүүнд лабораторийн шинжилгээ хийнэ. Лабораторид шинжлэгдсэн сүүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МӨШГӨХ ТОГТОЛЦОО

Сүү худалдан авах процесс Сүүний үйлдвэрийн ажилтан малчин/фермер өрхүүдээс сүү худалдан авахдаа “Хариуцлагатай нүүдэлчид” мэдээллийн системийн сүүний үйлдвэрийн модуль хэсэгт бүртгэх ба энэ үеэр өрхийн мал эмнэлгийн үйлчилгээг хянах боломжтой. Мөн тухайн өрхийн сүүг үйлдвэрийн стандартын дагуу шинжилгээний үзүүлэлтээр шалган сүүг худалдан авна.

Эцсийн бүтээгдэхүүний савлагаа: Үйлдвэрээс гарсан эцсийн бүтээгдэхүүний саван дээр QR код болон бүтээгдэхүүнийг боловсруулсан үйлдвэр, үйлдвэрлэсэн он, сар, өдөр гэх мэт мэдээлэл байна.

Гарал үүсэл шалгах: QR кодыг уншуулахад гарал үүсэл шалгах линк гарч ирэх ба тухайн линкээр орж бүтээгдэхүүний гарал үүслийг шалгана. Тухайн бүтээгдэхүүний түүхий эд болох сүүний гарал үүсэл, эрүүл ахуй, сүү нийлүүлсэн хариуцлагатай малчид/фермерийн мэдээлэл, тухайн малчдын ашиглаж буй бэлчээрийн төлөв байдлын мэдээлэл зэрэг олон мэдээллийг холбогдох эх үүсвэрээс авах боломжтой. Борнуур, Сүмбэр сумын МЭТ-ийн мэргэжилтнүүд, сумдын МЭҮН-ийн малын эмч нар, СБАХ-ны тэргүүн, сумдын бэлчээрийн менежментийн ажлын хэсгийн гишүүдийг оролцуулан МЭЕГ, Төв аймгийн МЭГ, УМЭАЦТЛ, Монветмед ХХК хамтран зохион байгуулснаар эмийн үлдэгдэлгүй сүүг баталгаажуулах боломжийг сумдын МЭҮН-ийн эмч нарт олголоо.

Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн дэх эмийн үлдэгдлийг хянах эрх зүйн орчныг бүрдүүлэх, улмаар аймаг, сумын мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мах, сүүнд эмийн үлдэгдлийн шинжилгээ хийх арга зүй нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж байна. Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний хувьд хэрэглэгчдийн зүгээс онцгойлон анхаарч байгаа эгзэгтэй асуудал бол эмийн үлдэгдэл юм. “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, ХХААХҮ-ийн сайдын 06 дугаар сарын 05-ны өдрийн А-178 дугаар тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийг боловсруулах, хэлэлцүүлэг хийх ажилд НАМЭМ төсөл санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Хөтөлбөрийг оролцогч талуудад таниулах, мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор НАМЭМ төсөл, МЭЕГ хамтран 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт ХХААХҮЯ, МЭЕГ, МХЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, НМЭГ, ХААИС-ийн МЭС, Хүнсний захуудын дэргэдэх Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн 50 мэргэжилтэн хамрагдсан байна.

Маханд антибиотик илрүүлдэг Преми тест болон сүүнд бета-лактамы (пенициллин болон цефалоспорины бүлэг), тетрациклин, стрептомицин, хлорамфениколыг ялган илрүүлдэг Юнисенсор гэдэг багажийг 100 сорьц шинжлэх оношлуурын хамт загвар сумын мал эмнэлгүүдэд гардуулж, эдгээр багажийг ашиглан шинжилгээ хийх аргачлал эзэмшүүлэх зорилгоор НАМЭМ төсөл 2018 оноос эхлэн сургалт зохион байгуулж байна.



Энэ багаж нь хэрэглэхэд энгийн бөгөөд автомашинаар тээвэрлэн явж малчны хотонд шинжилгээ хийх боломжтой тул анхан шатны мал эмнэлгүүд ашиглахад нэн тохиромжтой гэж үзэж байна. Энэ багажаар нийтдээ 2700 сорьцод шинжилгээ хийж дүнг системд оруулахаар төлөвлөн ажиллаж байгаагаас 12 сарын 18-ны байдлаар нийт 309 сорьцод шинжилгээ хийсэн байна. Энэ хүрээнд Ховд аймгийн Дуут сум 74 сорьцод шинжилгээ хийж оношлуурын ашиглалт хамгийн өндөр хувьтай байна. Дуут сум сургууль, цэцэрлэгийн үдийн цайнд нийлүүлж буй маханд эмийн үлдэгдлийн шинжилгээ хийж хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашиглаж байна. Төв аймгийн Борнуур сумын МЭТ, мал эмнэлгийн анхан шатны нэгжийн эмч нар 7.4 тн сүүний 28 дээжид антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээ хийхэд бүгд сөрөг гарсан байна. Ховд аймгийн Булган, Мөнххайрхан, Дуут, Чандмань сумд, Завхан аймгийн Тэс, Баянтэс, Сантмаргаз, Эрдэнэхайрхан сумдаас хонины 40, ямааны 39 нийт 79 малын булчин мах, бөөр, элэгнээс санамсаргүй түүврийн аргаар сорьц авч антибиотикийн үлдэгдэл тодорхойлсон. Хлорамфениколын үлдэгдэл тодорхойлох шинжилгээг Ховд аймгийн Булган, Мөнххайрхан, Дуут, Чандмань сумд, Завхан аймгийн Тэс, Баянтэс, Сантмаргаз, Эрдэнэхайрхан сумдаас хонь, ямааны 79 малын булчин махны сорьцод хийсэн байна.

Ховд аймгийн төсөл хэрэгжиж буй 4 сумаас цуглуулсан нийт 39 сорьцод хлорамфениколын шинжилгээг хийхэд 15 (38.5%) сорьцод хлорамфениколын үлдэгдэл 0.18-7.4 мкг/кг-ийн хооронд илэрчээ. Малын махны төрлөөр авч үзвэл хлорамфениколын үлдэгдэл хонины махны 22.5% (9 дээж)-д, ямааны махны 15.3% (6 дээж)-д тус тус илрэв.

Завхан аймгийн төсөл хэрэгжиж буй 4 сумаас цуглуулсан нийт 40 сорьцод хлорамфениколын шинжилгээ хийхэд Баянтэс, Эрдэнэхайрхан сумаас цуглуулсан бүх сорьцод хлорамфениколын үлдэгдэл илрээгүй харин Тэс, Сантмаргаз сумаас цуглуулсан дээжнээс тус бүр 1 сорьцод илэрсэн байна. Завхан аймгаас цуглуулсан нийт сорьцын 5%-д хлорамфениколын үлдэгдэл 0.5-2.4 мкг/кг-ийн хооронд илэрчээ. Малын махны төрлөөр авч үзвэл хлорамфениколын үлдэгдэл хонины махны 2.5% (1 дээж) -д, ямааны махны 2.5% (1 дээж) -д тус тус илэрсэн байна.

Ховд аймгийн Булган, Мөнххайрхан сумаас цуглуулсан сорьцод авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл илрээгүй, харин Чандмань, Дуут сумдаас цуглуулсан сорьцод илэрсэн байна. Ховд аймгийн 4 сумын нийт сорьцын 7.6% (3 дээж)-д ивермектиний үлдэгдэл 3.327 мкг/кг-ийн хэмжээтэй илэрсэн. Ивермектиний үлдэгдлийн дээд хязгаараас хэтэрсэн нийт сорьцын 2.5% (1 дээж)-д 27 мкг/кг-аар илрэв. Малын төрлөөр авч үзвэл ивермектиний үлдэгдэл хонины элэгний нийт сорьцын 10% (2 дээж) -д, ямааны элэгний нийт сорьцын 5.3% (1 дээж) -д тус тус илэрчээ.

Завхан аймгийн 4 сумаас нийт 40 сорьцод авермектиний бүлгийн эмийн шинжилгээ хийхэд Сантмаргаз, Эрдэнэхайрхан сумаас цуглуулсан сорьцод илрээгүй харин Тэс, Баянтэс сумаас цуглуулсан сорьцод авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл илэрсэн. Завхан аймгаас цуглуулсан нийт сорьцын 5%-д авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл 2-33.2

мкг/кг-ийн хооронд илэрсэн. Ивермектиний үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хязгаараас хэтэрсэн буюу 33.2 мкг/кг үлдэгдэл нийт сорьцын 2.5% (1 дээж)-д илэрлээ. Малын төрлөөр авч үзвэл авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл хонины элэгний 5% (2 дээж)-д, ямаанаас авсан сорьцын 5% (2 дээж) -д тус тус илэрсэн байна. Дээрх аймаг, сумдаас цуглуулсан сорьцод хийсэн шинжилгээгээр пенициллин, тетрациклиний бүлгийн эмийн үлдэгдэл илрээгүй байна.

УМЭАЦТЛ-ийн шинжээч Х.Дэлгэр, Ч.Бадрахзул, Албаны дарга Ц.Энхтуяа нар Преми тест болон Юнисенсорын аргын баталгаатай эсэхийг тогтоох судалгааны ажлыг Европын Холбооны малын эмийн үлдэгдлийн илрүүлэх аргад баталгаажуулалт хийх зааврын дагуу хийж гүйцэтгэсэн. Арга баталгаажуулах нь урт хугацаанд хийгддэг, нарийн төвөгтэй үйл явц тул энэ удаад эдгээр аргын илрүүлэх доод хязгаар (ССβ), хуурамч эерэг (FP) болон хуурамч сөрөг (FN) дүнгийн хэмжээ, таарц, тохирц зэрэг цөөн хэдэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, илрүүлэх түвшний аргын шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох зорилго тавин ажилласан байна. Судалгааны дүнгээс харахад Преми тестийн аргын окситетрациклинийг илрүүлэх доод хязгаарыг 100 мкг/кг буюу үлдэгдлийн дээд хязгаарын түвшинд, хуурамч эерэг дүн үзүүлэх хэмжээ 5%, хуурамч сөрөг дүн үзүүлэх 100 мкг/кг окситетрациклины түвшинд 5%, таарц, тохирц сайтай буюу маханд окситетрациклинийг үлдэгдлийн дээд хязгаарын түвшинд илрүүлэх аргын шаардлагыг хангаж байгаа нь тогтоогдсон байна.

Мөн Юнисенсор аргын илрүүлэх доод хязгаарыг пенициллин G-г 2 мкг/л, окситетрациклинийг 10 мкг/л, хлорамфениколыг 0.3 мкг/л, стрептомицинийг 200 мкг/л, таарц сайтай, хуурамч эерэг, сөрөг дүн үзүүлдэггүй болохыг тогтоосон. Иймээс Премитест, Юнисенсорын түргэн тест нь үлдэгдлийн дээд хэмжээний түвшинд байгаа антибиотикийг илрүүлэх боломжтой гэж дүгнэжээ.

5.2.4. Үр дүн 2.4.

Сонгосон аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.

Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлж малын эрүүл мэндийг мөшгөх цахим гэрчилгээ бүхий мал, мах худалдан борлуулж буй аймгийн тоо нэмэгдэж байна: Монгол Улсын мал эмнэлгийн байгууллагаас олгож байгаа баталгаажуулалтын баримт бичиг болох "Мал эмнэлгийн гэрчилгээ"-г дотоод, гадаад зах зээл дэх хэрэглэгчдийн тавьж байгаа шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, улмаар малын гаралтай бүтээгдэхүүн худалдан авч байгаа улс орнуудын мал эмнэлгийн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор НАМЭМ төсөл МЭЕГ хамтран "Мал эмнэлгийн нэгдсэн систем" хөгжүүлж, төслийн 15 суманд туршилтаар нэвтрүүлсэн ба 2018 оны 11 дүгээр сард МЭЕГ-ын өмчлөлд албан ёсоор хүлээлгэн өгч улсын хэмжээнд нэвтрүүлэх боломжтой болсон. Мал эмнэлгийн нэгдсэн систем (МЭНС)-ийг иж бүрэн нэвтрүүлснээр ХХААХҮЯ, МЭЕГ салбарын статистик мэдээллийн гүйцэтгэл, холбогдох тайланг бодит цаг хугацааны /real-time data/ үзүүлэлтээр шууд гаргаж, ашиглах боломж бүрдэж байгаа тул мал эмнэлгийн салбарт тулгарч буй асуудлыг богино хугацаанд үнэн зөв, хурдан шуурхай шийдвэрлэх, инноваци нэвтрүүлэх зэрэг өргөн боломжтой болж байна.

Малын эрүүл мэндийн нэгдсэн систем /МЭНС/ түүний ач холбогдлын талаар малчид, малчдын байгууллага, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, танилцуулах, тус системийг ашиглах малын эмч мэргэжилтнүүдэд зориулан танхимын болон ажлын байран дээрх сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг МЭЕГ-ын даргын 2019 оны А/167, 2019 оны 206 дугаар тушаалаар тус тус байгуулж ажиллуулсан. Сургалтыг 3 үе шаттай зохион байгуулж байгаа бөгөөд 1 дүгээр шатанд сумдын МЭТ, МЭҮН-ийн малын эмч нарыг төлөөлүүлэн сум тус бүрээс 3 малын эмч сонгон аймгийн төвд ирүүлж "Танхимын нэгдсэн сургалт" зохион байгууллаа. Энэ сургалтыг МЭЕГ-ын төлөөлөл удирдаж, Дижитал медик ХХК-ийн мэдээллийн технологийн инженерүүд сургагч багшаар ажилласан ба сургалтад нийт 1197

оролцогч хамрагдсан. Сургалын үед аймгийн нийт сумдыг 3 тойрогт хувааж эдгээр тойргийг хариуцах 3 малын эмчийг аймгийн МЭГ-аас сонгон тусгай хөтөлбөрөөр ганцаарчилсан сургалт хийж МЭНС-ийн орон нутаг дахь сургагч багшийн баг бүрдүүлсэн. Ажлын байран дээрх ганцаарчилсан сургалтыг аймгийн МЭГ-ын тойргийн сумд хариуцсан сургагч багш нар удирдан зохион байгуулсан ба нийтдээ 2138 малын эмчийг хамруулан зохион байгуулсан тус сургалтын хэрэгжилтэд МЭЕГ, Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл хяналт тавьж ажиллалаа. Сумын малын эмч нар МЭНС нэвтрүүлэхэд шаардагдах компьютер, техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй, МЭЕГ-аас томилогдсон зарим багийн ажил хугацаандаа зохион байгуулагдаж чадаагүй зэрэг шалтгааны улмаас МЭНС систем нэвтрүүлэх ажлын явц аймаг, сумдад харилцан адилгүй байна. Завхан аймаг 2019 онд 105.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн бусад зардлыг НАМЭМ төсөл, МЭЕГ гаргаж аймгийн хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан. Ховд аймаг 76.8 сая, Говь-Алтай аймаг 63.2 сая, Увс аймаг 78.8 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс шийдвэрлэж 2019 онд багтаан аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэхээр НАМЭМ төсөл, МЭЕГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн Баянхонгор, Баян-Өлгий, Өмнөговь, Дорнод аймаг тус бүр 115.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гаргахаар шийдвэрлээд байна.

Европын холбооны санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөс 31.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 12 малын эмчид МЭНС дээр ажиллахад зориулсан ухаалаг төхөөрөмж, зөөврийн жижиг хэвлэгчийг малын эмийн үлдэгдлийг илрүүлэх багажийн хамт гардуулан өгч сургалт зохион байгуулсан байна. Мөн SECIM төсөл МЭЕГ, МХЕГ, аймгийн МЭГ-тай хамтран МЭНС-ийн сургалтыг 6 аймгийн махны 16 үйлдвэрийн 25 төлөөллийг хамруулан зохион байгуулж, энэхүү системийг үйлдвэрийн түвшинд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлжээ.

Мал эмнэлгийн цахим гэрчилгээ бүхий гарал үүсэл тодорхой түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалт нэмэгдэж байна: Шинээр нэвтрүүлж байгаа “Мал эмнэлгийн нэгдсэн систем” нь малчны хотонд байгаа малд мал эмнэлгийн байгууллагаас үзүүлж байгаа бүхий л үйлчилгээг бүртгэхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн болж хэрэглэгчийн ширээн дээр очих хүртэлх бүх үе шатыг хамарч байгаа цогц систем юм. Мал эмнэлгийн ерөнхий газар тус системийг 2019 оноос 22 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, 330 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасаг, 1009 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, мэргэжлийн хяналт, цагдаагийн албан хаагч нарт ашиглуулж эхэлсэн нь улс орны хэмжээнд мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдаа, шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянах, мал эмнэлгийн гэрчилгээний олголт, хэрэглээнд хяналт тавих боломжийг олгож байна. 2019 оны 12 сарын 31-ний байдлаар Улаанбаатар хот болон 21 аймагт нийт 18673 цахим гэрчилгээ бичиж мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн байна.

Завхан аймгийн малчид, бизнес эрхлэгчид 2019 оны 12 сарын 18-ны байдлаар мал эмнэлгийн байгууллагаас 4243 цахим гэрчилгээ авч 97057 толгой мал 730 тн мах зах зээлд нийлүүлсэн байна. Мөн Баян-Өлгий аймгийн МЭГ Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэх сургалтыг бүх сумын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан 2 удаа зохион байгуулсны зэрэгцээгээр аймгийн Цагдаагийн газартай хамтран нэг сарын хугацаатай малын хулгайтай тэмцэх аян зохион байгуулж, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сумын нутаг дэвсгэрээс гадагш чиглэсэн тохиолдлууд буюу худалдаалах, төхөөрөх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, мал, амьтан шилжүүлэн авах, отор нүүдэл хийх, хээлтүүлэгт ашиглах болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлгийн цахим гэрчилгээ олгох ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсны дүнд 2019 оны 12-р сарын 14-ны байдлаар 45 тн адууны мах, 80 тн үхрийн мах, 4.5 тн

тэмээний мах, хонины мах, 70 тн ямааны мах, 55 тн ноос, 40 тн ноолуур, 35тн хөөвөр түүхий эд бүтээгдэхүүнд 4400 мал эмнэлгийн гэрчилгээг цахимаар олгож, баталгаажуулалт хийсэн байна. 2019 онд Баян-Өлгий аймгаас “Зергер Интернэйшнил” ХХК Иран улсад 288.0 тн хонины мах, “Ет транзит” ХХК 60.0 тн, “Азык” ХХК 20 тн адууны мах Казахстан улс руу, нийт 368 тн мах экспортолсон байна.

Тайлант хугацаанд МЭНС-д бүртгэгдэн шилжилт хөдөлгөөнд орсон нийт малын 90.2% нь хүнсний зориулалтаар шилжилт хөдөлгөөнд орсон бол 2.2% нь үржлийн, 7.4% нь отор нүүдэл хийж байгаа, 0.6% нь үзэсгэлэн, уралдаанд оролцсон, 0.06% нь алдуул мал байна. Шилжилт хөдөлгөөнд орсон нийт малыг малын төрлөөр авч үзвэл 58.5% нь хонь, 26.2% нь ямаа, 9.3% нь адуу, 6.4% нь үхэр, 0.2% нь тэмээ байна. Энд дурдагдаж байгаа малын зонхилох хэсэг нь хамгийн анх систем нэвтрүүлсэн Завхан аймаг болон Цагдаагийн газартай хамтарсан арга хэмжээ зохион байгуулсан Баян-Өлгий аймгийн мал байгааг энд дурдах нь зүйтэй гэж үзэж байна. Ирэх 2020 онд улсын хэмжээний тайланг энэ байдлаар харуулах нөхцөл бүрдээд байна. Систем нэвтрүүлэх сургалтыг орон даяар зохион байгуулж эхэлсэнтэй холбоотойгоор оны эцэст буюу 10, 11, 12 дугаар сар тус бүрт зах зээлд нийлүүлсэн малын тоо өмнөх 3 улирлын улирал тус бүрийн дүнтэй дүйх хэмжээнд очсон байна. Энэ нь нэг талаас хүнс бэлтгэх улирлын ажилтай холбоотойгоос гадна МЭНС-ийн хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгааг нотлон харуулж байна. Хүнсний зориулалттай малын 9.03% нь адуу, 6.39% нь үхэр, 61.40% нь хонь, 22.97% нь ямаа, 0.22% нь тэмээ байна. Тэдгээрийн сүүлийн 3 сарын хөдлөл зүйг авч үзвэл, ямаа, үхрийн мах бэлтгэл 10-аас 12 сар хүртэл тасралтгүй нэмэгдсэн, адууны мах бэлтгэл 11 дүгээр сард огцом нэмэгдэж үхрийн мах бэлтгэлийн 12 сарын түвшинд хүрээд 12 дугаар сард буурсан, хонины мах бэлтгэл 10-аас 11 сар хүртэл огцом нэмэгдээд 11-12 сард ижил түвшинд байгаа дүр зураг харагдаж байна. Энэ нь хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор мал эмнэлгийн хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой үзүүлэлт юм. Энэ онд олгосон мал эмнэлгийн цахим гэрчилгээний 5.0%-ийг эхний хагас жилд, 25.0%-ийг 3 дугаар улиралд олгосон бол 10 дугаар сард 13.0%, 11 дүгээр сард 23.0%, 12 дугаар сард 33.0 хувийг тус тус олгожээ. Үүнээс харахад зах зээлд мал нийлүүлж байгаа малчид, мал худалдан борлуулагчид бидний нэвтрүүлж байгаа шинэ ажлын ач холбогдлыг ойлгон дэмжиж байгаа эерэг хандлага ажиглагдаж байна.

МЭНС-ийг нэвтрүүлснээр малын хулгайтай тэмцэх ажилд томоохон ахиц дэвшил гарч байна. Тэлмэн сумын малын эмч П.Энхболд 2019 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Өгөөмөр багийн малчин Н.Алтан-Очирын хотноос 5 настай, 5 эр хонийг .6051, 6055 дугаартай ээмгээр ээмэглэн Meg3 дугаартай цахим гэрчилгээ бичиж Мах маркет ХХК-ийн Тосонцэнгэл сум дахь үйлдвэр рүү илгээснийг Н.Алтан-Очир өөрийн эзэмшлийн 2782 ЗАА дугаартай автомашинаар тээвэрлэн хүргэсэн ба үйлдвэрт 2019 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авчээ. МЭНС дээр гэрчилгээний дээрх мэдээллээс гадна ямар замаар явж эцсийн цэгт хүрэх замын зургийг харах боломжтой юм. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.3-т мал, амьтныг тогтоосон замаас өөр замаар тээвэрлэх, тууварлахыг хориглосон байгаа. Гэвч цаасан гэрчилгээ олгох үед мал тээвэрлэх, тууварлах маршрутыг тогтоох асуудал малын эмчид нэн хүндрэлтэй асуудал болоод байв. Энэ систем нь эхний цэгээс эцсийн цэгт хүрэх хамгийн дөт замыг улсын баталгаат зам дагуу шууд зурж өгдөг тул малын эмчид тулгараад байсан дээрх асуудлыг маш хялбархан шийдэж өгч байгаа юм. Тухайн малыг ээмэглэх боломжгүй нөхцөлд малын эмчид олгосон ухаалаг төхөөрөмжийг ашиглан тухайн малын зургийг системд оруулах замаар гэрчилгээнд хавсралт үүсгэх боломжтой. Ингэснээр малыг тээвэрлэн явж байх үед, эсхүл үйлдвэрт хүлээлгэн өгөх үед систем рүү нэвтэрч зургийг тулган харах боломж бүрдсэн.

Баян-Улаан багийн малчин О.Ууганбаярын 4 настай байдасыг Улаанбаатар хотын иргэн Ц.Загдаа өсгөж үржүүлэх зорилгоор худалдан авсныг Тосонцэнгэл сумын малын эмч Д.Энхтайван, мал эмнэлгийн улсын байцаагч М.Нансалмаа нар гэрчилж Meg633 дугаартай

гэрчилгээ олгон Ц.Загдаа өөрийн эзэмшлийн 4082 УБВ дугартай автомашинаар тээвэрлэжээ.

Малын эмч, мал эмнэлгийн улсын байцаагч, цагдаагийн албан хаагчид МЭНС-д нэвтрэх хувийн нууц дугаар бүхий эрхтэй бөгөөд хянаж шалгаж байгаа гэрчилгээний дугаарыг ашиглан тухайн малын зургийг харж болно.



Малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд аймаг, сумын малын эмч нар, малчдын мэдлэгийг дээшлүүлэх, мал эмнэлгийн байгууллага, боловсруулах үйлдвэр, малчдын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мал эмнэлгийн үйлчилгээний оролцогч талуудад Малын эрүүл мэндийн суурь мэдлэг олгох сургалтын удирдамж, хөтөлбөрийг МЭЕГ-ын даргаар батлуулан УМЭАЦТЛ-ийн шинжээчдийн баг хариуцан зохион байгуулж байна. Төсөл хэрэгжиж байгаа 10 аймгийн 26 сумын Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлыг үнэлэх, лабораторид шинжилгээ хийх, Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангах, Мал эмнэлгийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, сумдад мал эмнэлгийн үйлчилгээний загвар нэгж бий болгох зорилготой энэхүү сургалтын хүрээнд дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- Аймаг сумын удирдлагууд, холбогдох байгууллагын дарга, албан хаагчдад төслөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, тэдний санал хүсэлтийг сонсож, төсөл хэрэгжүүлэх нэгжид уламжлах,

- Малын гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах, малын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр МЭЕГ, аймгийн МЭГ, аймгийн ХХААГ, АБАХ-аас Ногоон алт, Малын эрүүл мэнд төсөлтэй хамтран тус аймагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар малчид, сумын удирдлагуудад танилцуулах,

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шинээр батлагдан гарсан эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулах,

- Төсөл хэрэгжиж байгаа 10 аймгийн 26 сумын Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлыг үнэлэх, лабораторид шинжилгээ хийхэд зориулан сорьц цуглуулах,

- Тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дэх малын халдварт, шимэгчтэх өвчний нөхцөл байдлын талаар малчдад зориулан мэдээлэл хийх, учрах хор уршигийг ойлгуулах, улмаар мал эмнэлгийн үйлчилгээнд мал хамруулах санаачлагыг нэмэгдүүлэх,

- Төсөл хэрэгжиж байгаа аймгийн МЭГ, сумын Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн малын эмч нарт зориулан ажлын байран дээрх сургалт зохион байгуулж Мал эмнэлгийн нэгдсэн систем болон Мал эмнэлгийн лабораторийн удирдлага, мэдээллийн систем дээр ажиллах, лабораторийн анхан шатны шинжилгээ хийж дүнг системд оруулах дадлага, ур чадвар эзэмшүүлэх.

Энэхүү сургалтад нийт 1338 хүн оролцсоноос 74.1 хувь буюу 992 нь малчин, 1.4 хувь буюу 98 нь малын эмч, үлдсэн 24.0 хувь нь бусад бүлгийн оролцогч байна.

Малчдад зориулсан сургалтын модуль боловсруулах ажлыг 2019 онд ХААИС-тай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд тусган хэрэгжүүлж байна. Малчид, мал аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхлэгч, сум, орон нутгийн удирдлагуудад малын эрүүл мэндийн талаар мэдлэг олгох сургалтын хэрэгцээг ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш нар тусгайлан судалж, судалгааны үр дүн дээр тулгуурлан сэдвүүдийг сонгож, боловсруулж байгаа сургалтын модуль нь унших материал, тухайн сэдвээр 20-30 минутын сургалт хийх нарийвчилсан хөтөлбөр, сургалтад ашиглах үзүүлэн, сургалтын дараа оролцогчдод тараах материалаас бүрдэж байгаагаас гадна сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааны дүн, бусад холбогдох баримт нотолгоог оруулсан. Өмнөх онд хэвлүүлсэн сургалтын модулийг төсөл хэрэгжиж байгаа сумдын сургагч малын эмч нарт хүргүүлсэн бөгөөд энэ онд 5 шинэ сэдвээр сургалтын модуль боловсруулж, гарын авлага гаргасны зэрэгцээ алсын зайн сургалт хийхэд зориулан 10 сэдвээр 4-6 минутын видео хичээл бэлтгэн гаргалаа.

Малчид, мал аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхлэгчдэд малын эрүүл мэндийн талаар мэдлэг олгох сургалтыг сумын малын эмч нар тухайн сумын СБАХ-ны тэргүүнтэй хамтран зохион байгуулах үүрэг хүлээж байгаа. Малчны хотонд очиж идэвхтэй оролцооны аргаар сургалт зохион байгуулахын өмнө сумын малын эмч нар болон СБАХ-ын тэргүүнийг сургалтад хамруулж дадлагажуулах ажлыг ХААИС-ийн багш нар хариуцан зохион байгуулж байна. Эдгээр малын эмч, СБАХ-ын тэргүүнтэй хамтран сумын төвөөс алслагдсан газар байгаа малчдын хотонд очиж сургалт хийх ажлыг зохион байгуулсан арга хэмжээнд нийт 3650 малчин хамруулан мэдлэг олгожээ.

Малын эрүүл мэндийн шинэ тогтолцоонд мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх бизнес, зохион байгуулалтын загвар боловсруулахад дэмжлэг үзүүлж байна. Шинэ хууль, тогтоомж, стандартад тавигдсан шаардлагыг ханган хувийн мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэхийн тулд малын эмч нар багагүй хөрөнгө зарцуулах шаардлагатай байна. Нэг суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нэг дор байрласан тохиолдолд энэхүү шаардлагыг хангахад харьцангуй хялбар болно. Харин тус тусдаа байршсан өнөөгийн хэв маягаар цааш явбал үр ашиггүй зардал гарч мал эмнэлгүүдэд санхүүгийн ихээхэн хүнд ачаалал үүсэхээр байгаа нь суманд загвар мал эмнэлэг, лаборатори барьж байгуулах, шаардагдах тоног төхөөрөмж авахад нийт 133.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгтэй гэсэн тооцоо, судалгаанаас харагдаж байна. Иймд анхан шатанд ажиллаж байгаа хувийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарын ажлыг хөнгөвчлөх, орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн ачааллыг багасгахын тулд мал эмнэлгүүдийг айлын хашаа, гэрээс гаргаж, нэг суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг нэг барилгад нэгэн дээвэр дор ажиллуулах арга хэмжээг НАМЭМ төсөл, МЭЕГ, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

Төсөл хэрэгжиж байгаа сумдад загвар мал эмнэлэг байгуулах, мал эмнэлгийн үйлчилгээний шилдэг загвар бий болгох үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, төсөл сонгон шалгаруулах үүрэг бүхий тендерийн үнэлгээний хороог МЭЕГ-ын даргын 2019 оны А/207 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Үнэлгээний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулан МЭЕГ-ын даргаар батлуулж төсөл хэрэгжиж байгаа аймгуудад хүргүүлсэн. Төслийн баримт бичигт заасны дагуу дараахь шаардлагыг хангасан МЭТ, МЭҮН-д төслөөс дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Мал эмнэлгийн тасаг, нэгжид ажиллаж байгаа малын эмч нар нэгдсэн мал эмнэлэг байгуулж хамтран ажиллах санаачлагыг дэмжиж хамтын шийдэлд хүрсэн байх,
- Мал эмнэлгийн ерөнхий газраас санал болгосон жишиг зурагт нийцсэн өрөө талбайн хуваарилалт бүхий барилга, байгууламжийн эскиз, эсхүл план зураг үйлдсэн байх,
- Нэгдсэн мал эмнэлгийн газар эзэмшил, өмчлөлийн асуудлыг албан ёсоор шийдвэрлүүлсэн байх,
- Өөрийн оролцооны хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх тухай эрх бүхий байгууллагын албан ёсны шийдвэр гарсан байх,
- Өөрийн оролцооны хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлын 50-аас доошгүй хувийг төсөл ирүүлэхээс өмнө, эсхүл санхүүжилт авахаас өмнө хийж гүйцэтгэсэн байх,
- Нэгдсэн мал эмнэлэг нь Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн MNS 5368:2018 стандартын шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар өөрийн үнэлгээ хийж, хамтрагч талууд гарын үсэг зурсан байх,
- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид ажиллаж байгаа итгэмжлэл бүхий малын эмч нь тухайн сумын байнгын оршин суугч байх,
- Төслийн саналыг аймгийн Мал эмнэлгийн газар дэмжсэн байх. Дээрхээс гадна сумдад байгуулах нэгдсэн мал эмнэлэг нь Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хэрэгжилтийг суманд хариуцан зохион байгуулдаг төрийн бус байгууллага /СБАХ/-тай нэг дор байрлаж хамтарсан үйл ажиллагаа явуулах хувилбарыг сонгож байгаа бол төсөл сонгон шалгаруулалтад давуу эрх эдэлнэ гэдгийг төслийн баримт бичигт тусгаж өгсөн. Төсөлд сонгогдсон Архангай аймгийн Өндөр-Улаан сум, Завхан аймгийн Сантмаргаз сум, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын мал эмнэлгийн барилгын шинэчлэл өргөтгөл хийх төслийг 50.0-60.0 сая төгрөгт багтаан хэрэгжүүлэхээр тооцож байгаа бөгөөд 20.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20.0 сая төгрөгийг НАМЭМ төсөл тус тус санхүүжүүлж, үлдсэн санхүүжилтийг малын эмч нар гаргахаар төлөвлөн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

5.2.5. Дүгнэлт, сургамж, санал.

- Малчдын зарим хоршоод боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулж түүхий эд бэлтгэх урьдчилгаа авсан ч зах зээлд илүү үнээр авч буй хувь хүн, байгууллагад түүхий эдээ нийлүүлж, гэрээний үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй, ёс зүйгүй хандаж байгаа байдал гарч байна.
- Хоршоодод үзүүлж буй бодлогын дэмжлэг, эдийн засгийн хөшүүрэг хангалтгүйгээс хоршоодын хөгжил зогсонги, удаашралтай, гишүүдэд үр ашгаа төдийлөн өгч чадахгүй байна. Цаашид малчдын хоршооны засаглалыг сайжруулах, эдийн засгийн хөшүүрэг бий болгох, хоршоодыг чадавхжуулж, зарчмаараа ажилладаг болоход нь дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байна.
- 10 аймгийн загвар 24 сумын БАХ-ийн сүргийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу 4 сая гаруй мал борлуулах тооцоо гарч, малчид мал борлуулах сонирхол ихтэй байгаа боловч мах худалдан авах үндэсний үйлдвэрийн үнэ ханш бага, орон зай алслагдмал, МЭЕГ-тай байгуулах гэрээ хойшлогдсоноос ээмэгний нийлүүлэлт оройтож байгаа зэрэг олон шалтгаанаас мөшгөх боломжтой, гарал үүсэл тодорхой мал мах бэлтгэн нийлүүлэх ажил төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна. Үүнд төр засгийн оновчтой, бодлого дэмжлэг мөн шаардагдаж байна.
- “Хариуцлагатай нүүдэлчин” түүхий эдийн мөшгөх тогтолцооны мэдээллийн санд БАХ, хоршоод мэдээлэл оруулах ажил сумын ажилтнуудын компьютер хуучирсан, эвдэрсэн, зарим ажилтны ур чадвар муу зэргээс хамааран удаашралтай байна. Түүхий эдэд олгож буй Засгийн газрын урамшууллыг энэхүү системээр дамжин үндэсний үйлдвэрт борлуулж буй малчдад олгох ажлыг хэрэгжүүлвэл илүү үр дүнтэй болно.
- МБАНХ-ноос шинээр байгуулагдсан болон хуучин хоршоодын Мал эмнэлгийн бүртгэл, мэдээ, тайлан, баталгаажуулалтын уламжлалт хэлбэр бусад сумдад хэрэглэгдэж

байгаатай холбоотойгоор төсөл хэрэгжиж байгаа аймаг, сумын малын эмч нар системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглахгүй, мэдээллийн санг баяжуулах үйл ажиллагааг хангалттай хийхгүй байна. Тиймээс уг системийг 2019-2020 онд улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг баруун бүсээс эхлэн бүсчлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- Малын эрүүл мэндийн баталгаажуулалтын системийн дагуу баталгаажсан бүтээгдэхүүнийг худалдан авсан хэрэглэгчид сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлж байгаагийн зэрэгцээгээр энэ төрлийн бүтээгдэхүүний хэрэглэгчийн тоо өсөн нэмэгдэж байна. Гэвч мал өвчлөх үед малчид өөрсдөө эмчилгээ хийдэг, гарал үүсэл нь тодорхойгүй, хүнсний аюулгүй байдлын баталгаагүй бүтээгдэхүүн дотоодын зах зээл рүү саадгүй нэвтэрдэг дутагдал нийтлэг байгаа нь хариуцлагатай үйлдвэрлэл эрхэлж, баталгаатай бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх сонирхолтой малчдын идэвх санаачилгыг сулруулах шалтгаан болж байна.

- Худалдааны хорио цээрт халдварт өвчингүй, тайван нутаг дэвсгэрийг тогтоон баталгаажуулж, нийтэд зарлан мэдээлэх үйл ажиллагааг яам, агентлагаас хэрэгжүүлэхгүй байгаагийн улмаас эрүүл малтай нутаг дэвсгэрт байгаа малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн давуу эрхээр зах зээлд нэвтрэх, илүү үнэ цэнэтэй байх нөхцөл хангагдахгүй байна.

- Аль ч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид зориулалтын лаборатори, лабораторийн тоног төхөөрөмж байхгүй, байгаа төхөөрөмжийг ашигладаггүй дутагдал нийтлэг байна.

- Түүхий эдийн эргэн мөшгөх систем бусад сангуудтай мэдээллээ хэрхэн солилцож байх, олон нийт, хэрэглэгч, хамтрагч байгууллагуудад өгөх мэдээллийн боломжит бүтээгдэхүүн, төлбөрийн систем зэрэг асуудлыг шийдвэрлэх дүрэм, журамтай болох, хамтын ажиллагааны гэрээний хүрээнд мэдээлэл солилцох асуудлыг тодорхой болгох, МБАНХ түүхий эдийн гарал үүслийн баталгаа гаргах байгууллагын эрх, баталгаажуулалт авах талаар судалж, хэрэгжүүлэх шаардлага нэн тэргүүнд тулгарч байна.

5.3. ҮР НӨЛӨӨ 3.

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮР ӨГӨӨЖТЭЙ ТОГТОЛЦОО, БЭЛЧЭЭРИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН ТААТАЙ ОРЧНЫГ ДЭМЖИХ

5.3.1. Үр дүн 3.1.

Малын эрүүл мэнд, бэлчээрийн хууль эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Бэлчээр хамгаалах хуулийн төслийг малчид дэмжиж байна: Монгол орны бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, малчдын дуу хоолойг сонсох зорилго бүхий “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг УИХ, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, НАМЭМ төсөл, МБАНХ хамтран зохион байгуулсан. Үндэсний хэлэлцүүлэгт УИХ-ын дарга, гишүүд, Засгийн газрын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох яам, агентлагийн албан тушаалтнуудаас гадна 21 аймгийн ИТХ-ын дарга, ХХААГ-ын дарга нар болон малчид, тариаланчдын төлөөлөл нийт 850 гаруй хүн оролцсон.

Хэлэлцүүлгийн үеэр “Монгол Улсын бэлчээр нутгийн өнөөгийн төлөв байдал”, “Бэлчээрийг ашиглах, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх арга замууд, үр дүн сургамж”, “Малчдын бүлгийн зохион байгуулалтад үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлсэн туршлага”, “Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх асуудлууд”, “Малчдын санаачлагаар бэлчээр ашигласны хураамжаар суманд эрсдэлийн сан бүрдүүлж, зарцуулсан туршлага сургамж” зэрэг сэдвээр илтгэл, танилцуулга хийж, малчид төлөөлөгчдөөр хэлэлцүүлээ. Төлөөлөгчдийн зүгээс бэлчээрийн тухай хуулийн төслийг нэн даруй батлах шаардлагатайг онцлохын зэрэгцээ малын тоо толгойг цөөрүүлэх, улсын сайн, аварга малчин шалгаруулахдаа тоо бус чанарт анхаарсан журам боловсруулах, малчдын өвөлжөө, хаваржаа болон сэлгээний газрыг эзэмшүүлж, хадлан бусад газрыг нийтийн эзэмшилд үлдээх, отрын бүсийн зохицуулалтыг оновчтой тодорхой болгох, бэлчээрийн тухай хуульд говь, хангай, хээрийн бүсийг

харгалзсан зохицуулалт, уул уурхайн лицензийг олгохдоо бэлчээр сүйтгэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхаарах шаардлагатай гэсэн саналыг үндэсний хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжид тусган УИХ, Засгийн газарт хүргүүлээ.

Бэлчээр ашиглалтын эрх зүйн орчинг сайжруулах “Агшиж буй Монгол” аян өрнүүлж байна: МБАНХ-ноос бэлчээр ашиглалтын эрхзүйн орчныг сайжруулахын тулд хууль санаачлагч, бодлого боловсруулагчдын анхаарлыг татах зорилгоор “Агшиж буй Монгол” олон нийттэй харилцах компани ажлыг санаачилсан. Энэ ажлын хүрээнд Вайрал Партнерс ХХК-тай хамтран 8 видео контент, эх бэлтгэлийн дизайн болон веб сайт санал хураалтын 32 цэс, вебсайтад 2 нийтлэл, сонингийн нэг нийтлэл бэлтгэн сошиал сувгуудаар түгээлээ. Сонгуулийн насны залуучуудад Монгол орны бэлчээрийн өнөөгийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын тухай мэдлэг, мэдээллийг өгсөнөөр бэлчээр ашиглалтыг зохицуулалттай болгохыг дэмжсэн саналыг веб сайтаас гадна Мобиком, Юнител, Скайтел, Жи-мобайл зэрэг үүрэн телефоны 4 оператортой гэрээ байгуулж бүх сүлжээний хэрэглэгчид SMS-ээр санал өгөх боломжийг бүрдүүлэв. The Shrinking Country фейсбүүк хуудаснаас цацагдсан бүх төрлийн фото, видео контентод төлбөртэйгээр хандалтыг нэмэгдүүлж, “Last Nomadic” сэдвийн хүрээнд Төв, Сүхбаатар, Хэнтий аймгийн малчид, иргэдтэй ярилцаж Төв аймгийн малчны нэвтрүүлгийг олон нийтэд цацлаа. МУИС-ын оюутнууд “Агшиж буй Монгол” давалгааг санаачилж МУИС-ийн маркетингийн 3-р анги, МУИС-ийн эрэгтэй сагсан бөмбөгийн шигшээ баг, МУИС-ийн 3-р дотуур байрны оюутнууд давалгаанд нэгдэв. АПУ дэйри, Витафит милк компани аянд нэгдэж 185 ажилтан санал өглөө. Мөн 10,000-аас дээш дагагчтай, нөлөөлөх чадвар өндөр 10 хүнээр мэдээлэл түгээх зэргээр давхардсан тоогоор нийт 2.4 сая орчим хүнд мэдээлэл хүргэлээ.

Малын эрүүл мэндийн холбогдолтой эрх зүйн баримт бичиг: Мал эмнэлгийн байгууллагын бие даасан байдлыг хангаж, захиргааны, мэргэжлийн, санхүүгийн удирдлагын уялдаа холбоог сайжруулснаар мал, амьтны халдварт өвчний дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх бэлэн байдлын чадавх сайжирч байгаагаас гадна мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримталж байгаа бодлого, чиглэл илүү тодорхой болж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх давуу талууд бий болж байна. НАМЭМ төслөөс журам, заавар болон бусад баримт бичгийн төслийг боловсруулах, хэлэлцэх, санал авах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг МЭЕГ-тай 2019 онд хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжилтийг хамтран зохион байгууллаа. Тайлант хугацаанд 2 журам, 1 төлөвлөгөө, 2 судалгааны хуудас, 1 аргачлал, нийт 6 эрх зүйн актын төсөл батлуулаад байна. Хууль батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 105 эрх зүйн актыг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэ оны 11 дүгээр сард хот, хөдөөгийн 1000 гаруй малын эмчийг оролцуулан малын эмч нарын их хурлыг ХХААХҮЯ, МЭЕГ зохион байгуулах үед хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг МБАНХ-той хамтран зохион байгууллаа.

Улсын аварга малчин өрх, фермер, саальчин шалгаруулах журмыг шинэчлэв: Засгийн газрын хуралдаанаар Улсын аварга, хошой аварга малчин өрх, улсын аварга фермер, улсын аварга саальчин шалгаруулах журмыг шинэчлэн баталлаа. Монгол улсын бэлчээрийн даац цаг агаар хэвийн жилд 84.6 сая хонин толгой малын багтаамжтай бөгөөд гантай жилд бэлчээрийн даац 30 хүртэл хувиар буурдаг байна. Өнгөрсөн жилийн эцэст тоологдсон 66.5 сая толгой малыг хонин толгойд шилжүүлэхэд 111 сая хонин толгой болж байгаа нь бэлчээрийн даацаас 25.4 сая толгойгоор хэтрээд байгаа юм. Ийнхүү МБАНХ-ноос ХХААХҮЯ-нд улсын аварга малчин өрх шалгаруулах болзлыг өөрчлөх талаар санал, хүсэлт явуулж хамтран ажилласны үр дүн гарч байна.

5.3.2. Үр дүн 3.2.

Яам, агентлагийн хүсэлтэд тулгуурлан бодлогын арга хэмжээг дэмжих.

Чадавхжуулах арга хэмжээнд хамрагдсан яам, агентлаг, үндэсний холбоод: Говийн, төвийн бүсийн мал эмнэлгийн чухал асуудлууд зөвлөгөөнийг Өвөрхангай, Дархан-Уул аймагт зохион байгуулахад төслөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулсан Говийн бүсийн зөвлөгөөнд Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо, түүний салбар зөвлөлүүд, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай зэрэг 7 аймгийн малын эмч, мэргэжилтнүүд, ХХААХҮЯ, МЭЕГ, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, Мал эмнэлгийн хүрээлэн, ЖАЙКА, ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл зэрэг олон улсын байгууллагын төлөөлөл, Өвөрхангай аймгийн ХХААГ, Мал эмнэлгийн эмч мэргэжилтнүүд, Дэлгэр-агьт, Монветмед, Сорлог сүрэг зэрэг хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл, удирдлага, малын эмч, мэргэжилтнүүд болох нийт 285 хүн оролцжээ. Харин Дархан-Уул аймагт зохион байгуулсан зөвлөгөөнд төвийн бүсийн 5 аймаг, Нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын 100 гаруй төлөөлөгч оролцсон байна. Энэхүү зөвлөгөөний үеэр мал эмнэлгийн салбарын хууль эрхзүйн шинэчлэл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн танилцуулга сурталчилгаа, журам, зааврын өөрчлөлтүүд, малын эрүүл мэндийн талаар төрөөс баримталж буй бодлого, говийн бүс дэх мал эмнэлгийн тулгамдсан асуудлууд, мал эмнэлгийн мэргэжлийн шат шатны байгууллагын хамтын ажиллагаа, мал эмнэлгийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, мал эмнэлгийн боловсролын шинэчлэл, цаашдын хөгжлийн талаар хэлэлцэж, 34 санал, зөвлөмжийг МЭЕГ, Мал эмнэлгийн сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, Монголын үндэсний мал эмнэлгийн холбоонд хүргүүлсэн байна. Үүнд. Мал эмнэлгийн ерөнхий газарт 18 санал, зөвлөмж, Мал эмнэлгийн сургуульд 3 санал, зөвлөмж, Мал эмнэлгийн хүрээлэнд 5 санал, зөвлөмж, Монголын үндэсний мал эмнэлгийн холбоонд 8 санал, зөвлөмжийг хүргүүлжээ.

5.3.3. Дүгнэлт, сургамж, санал:

- Малын эрүүл мэндийн харилцаанд оролцогч талуудын төлөөллийг өргөн хүрээнд хамруулан хуулийн сургалт, сурталчилгаа хийсэн хэдий ч зорилтот бүлгийг нэг, хоёр удаагийн нөлөөллөөр хангалттай мэдлэгтэй болгох боломжгүй нь харагдаж байна. Иймээс цаашид яриа таниулга хийх уламжлалт хэлбэрийн зэрэгцээгээр олон төрлийн контент бүтээх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн орон нутагт түгээх аргыг түлхүү хэрэглэх хэрэгтэй байна.

- Мал эмнэлгийн төвийн байгууллагаас орон нутагт томилогдон ажиллаж байгаа албан хаагчид Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнийг дагалдан гарч байгаа эрх зүйн баримт бичгийн талаар жигд, зөв ойлголттой болж чадаагүй байгаа нь аймаг, сумын албан хаагчдыг төөрөгдөлд оруулах, малын эрүүл мэндийн харилцаанд оролцогч талуудын итгэлийг сулруулах сөрөг нөлөө үзүүлж байна. Иймээс хууль тогтоомжийн ухуулга, сурталчилгаа хийх баг бүрдүүлэх, тэднийг тогтмол уулзуулан туршлага, мэдээллээ хуваалцах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

- Шинэ хууль тогтоомжийг сурталчлахад зориулсан гарын авлага, материалыг малчдад зориулсан, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан, сум, орон нутгийн удирдлагад зориулсан, анхан шатны малын эмч нарт зориулсан, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа малын эмч нарт зориулсан гэх мэтээр зорилтот бүлэг тус бүрт зориулан төрөлжүүлж гаргах хэрэгтэй байна.

- Малын эрүүл мэндийн чиглэлээр загвар сум тус бүрт нэг БАХ дээр загвар болохуйц үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗУРГАА. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮНГИЙН ХҮРСЭН ТҮВШИНГИЙН ҮНЭЛГЭЭ.
2019 онд гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ
1.	(БАХ), (БАГ)-гээр дамжуулан бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх	1.БАХ/БАГ-г төсөл одоо хэрэгжиж байгаа 11 аймагт бэхжүүлэх	100
		2.Шинээр хамрагдах 7 аймагт БАХ/БАГ-г нэвтрүүлэх	95.4
		3.Бэлчээр ашиглалтын гэрээний асуудлаар техник арга ажиллагаа, мэдээллийн санг үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагын түвшинд дэмжин хөгжүүлэх	91.4
		4.БАХ-ийн тогтолцооны бүтэц, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх	95.7
Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн дундаж үнэлгээ			95.6
2.	Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх	1.Боловсруулагчид, БАХ-ийн хоршоодын холбоо хоорондын хамтын ажиллагааг зуучлан бэхжүүлэх	91.4
		2. БАХ-ийн дэргэдэх хоршоодыг чадавхжуулах	85.7
		3.Мал аж ахуйн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах	100.0
		4.Сонгосон аймгуудын мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	60.0
Бүрэлдэхүүн хэсэг 2-ын дундаж үнэлгээ			84.3
3.	Малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийн бодлогын таатай орчныг дэмжих	1.Малын эрүүл мэнд, бэлчээрийн хууль эрхзүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	92.5
		2.Яам, агентлагийн хүсэлтэд тулгуурласан бодлогын арга хэмжээг дэмжих	95.0
Бүрэлдэхүүн хэсэг 3-ын дундаж үнэлгээ			93.8
Дундаж үнэлгээ			91.2

ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

д/д	Үзүүлэлт	Хяналт-шинжилгээ, үнэлгээ /хувь/			
		2017	2018	2019	Дундаж
1	Зорилтын биелэлт	75.0	77.2	81.1	77.8
2	Төлөвлөгөөний биелэлт	95.0	87.9	91.2	91.4

ДОЛОО. ДҮГНЭЛТ

1. Тус төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 91.2 хувьтай дүгнэгдэв.

2. Малчдын зохион байгуулалтад оруулсан болон мал, малын гаралтай бүтээгдэхүүний эргэн мөшгих тогтолцоо бүрдүүлсэн программ хангамжийг хөгжүүлсэн нь Монгол орны нөхцөлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц ахицтай ажил болсон байна.

3. Төслийн жилийн эцсийн тайлан нь үр дүнд суурилсан, биелэлтийг төсөл хэрэгжиж буй сум, малчдын бүлгийн үзүүлэлтээр гарган, үр нөлөөллийг тодорхой тусгасан байна.

4. Төсөл хэрэгжүүлэгч нэгж, төрийн, төрийн бус байгууллага, төсөлд хамрагдсан сумын малчдын ажлын уялдаа, хамтын ажиллагаа сайн байна.

НАЙМ. ЗӨВЛӨМЖ.

1. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний эргэн мөшгөх тогтолцооны программд мал эмнэлгийн үйлчилгээний мэдээллийг бүрэн оруулуулах, гарал үүслээс гадна жинхэнэ утгаар нь хүнсний аюулгүй байдлын баталгааг бий болгоход анхаарах,

2. Орон нутаг дахь төрийн албан хаагчдад хөрөнгө оруулалт хийж, үйлчилгээ үзүүлж байгаа байдлыг таслан зогсоож, хувийн хэвшлийн аж ахуйд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх (Хөдөө аж ахуйн тасгийн дэргэд хээлтүүлэгч төвлөрүүлсэн, тасгийн мэргэжилтэнд хөрөнгө оруулалт хийж, зохиомол хээлтүүлэг хийлгэсэн зэрэг),

3. Сүргийн эргэлтийн программ хангамжийг улс даяар нэвтрүүлэх, малын үржил бүртгэлийн программтай холбож өгөх,

4. Мал сүргийн зохистой бүтцийг (зүйл хоорондын болон зүйл доторх харьцаа) тогтоож, бодлогын шийдвэр гаргуулж, үр дүнг баталгаажуулах,

5. Төсвийн зарцуулалт хангалттай биш байгаа тул шалтгааныг судалж, зарцуулалтыг сайжруулах шаардлагатай байна.